ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2019 ОНЫ 7-Р САР

Лиахона

Анхдагчид: Тэдний баатарлаг амьдрал ба бидний итгэлийн өв, 20, 28-р хуудас

Арван хоёр төлөөлөгч: Дэлхий даяарх дуудлага ба хувийн тохинуулал, 12-р хуудас

Аюулыг даван туулах нь, үйлчлэлийн үйл, 22-р хуудас

СҮМ
ЭНД
БИЙ

Энэтхэгийн
Бенгалур

Өнөөдрийн Энэтхэгийн Сүмийн тухай зарим мэдээ баримтыг доор оруулав.

1 — Бенгалурт баригдах ариун сүм

Сүмийн гишүүн — 13570

43 — Тойрог, салбар (Конвент Роуд тойргийн цуглааны байр зургийн доод талын төв хэсэгт байгаа)

Номлол — 2

5 — Энэтхэгт Мормоны Номыг бүтнээр нь болон хэсэгчлэн гаргах боломжтой хэл

Энэтхэгт ярьдаг үндсэн хэл — 22

1851 Хэд хэдэн хүн баптисм хүртэж, Колкатад жижиг салбар үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

1993 Энэтхэгийн Бангалор номлол 13 салбар, 1150 гишүүнтэй байгуулагдаж байсан.

2007 Энэтхэгийн Шинэ Дели Номлол нээгдсэн.

2012 Хайдерабад дахь анхны гадсыг ерөнхийлөгч Даллин Х.Өүкс зохион байгуулж байсан.

Бид бусдыг Сүмд татан оролцуулдаг соёлыг хэрхэн бий болгож болох вэ?
8

Бид бол гэрчүүд: Өнөөгийн арван хоёр төлөөлөгч
Сара Жэйн Вийвэр, Жэйсон Свэнсэн
12

Тэнгэрийн таалал л байх даа

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн бүртэй ярилцаж, тэдний төлөөлөгч байх ариун нандин дуудлагын талаар бичих боломж бол ховор тохиолдол юм ("Бид гэрчүүд," 12-р хуудсыг үзнэ үү).

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллардтай уулзсаныхаа дараа би түүний өрөө рүү эргэж харав. Тэр ширээнийхээ ард суугаад, Ерөнхий чуулган дээр хэлэх үгээ бичиж байлаа. Тэр 1976 онд Далын нэгдүгээр чуулгад дэмжигдэн батлагдсанаасаа хойш Сүмд хамгийн удаан хугацаагаар ажиллаж байгаа ерөнхий эрх мэдэлтэн юм. Тэр ядарсан ч гэсэн эрч хүчтэй харагдаж байв. "Сайн байна уу?" гэж тэр надаас асуусныхаа дараа "Өөрийгөө хэт ядрааж болохгүй шүү" гэж эелдгээр зөвлөсөн юм. Үлдсэн амьдралаа дуустал Их Эзэнд эцэж цуцалтгүй үйлчлэх дуудлага авсан түүний хэлсэн үг миний хувьд ач холбогдолтой зүйл байв.

Арван хоёр нь "бүх үндэстэнд, [Сүмийн] бүх хэрэг явдлыг зохицуул[ахаар] дуудагддаг болой" (Сургаал ба Гэрээ 107:33-ыг үзнэ үү). Гэвч тэдэнтэй хамт байх үед тэдний анхаарал дэлхий даяарх Сүм дээр гэлтгүй өмнөө суугаа хувь хүн дээр шууд төвлөрдөг. Тэд дэлхийнхний хувьд шагшин магтагддаг албан тушаалаа орхин, дуудлагат ажил дээрээ ирсэн бөгөөд өрөөнөөс нь гарах үед даруу бөгөөд сайхан сэтгэлтэй гэсэн үгс л тэднийг тодорхойлно.

"Заримдаа би өөрөөсөө 'Би яагаад энэ агуу хүмүүстэй хамт байгаа юм бол?' хэмээн асуух үе гардаг" гэж ерөнхийлөгч Баллард надад хэлсэн юм. Харин дараа нь тэр "Тэнгэрийн таалал л байх даа" хэмээн гэрчилж билээ. Та бүхэнд төлөөлөгчийн дуудлагыг зэрвэсхэн харуулсан маань таалагдсан байх гэж найдаж байна.

Сара Жэйн Вийвэр
Сүмийн мэдээ сонины редактор

Бидний анхдагчдын үргэлжлүүлж буй өв
20

Үйлчлэлийн илүү ариун загвар
Ахлагч Патрик Кийрон
22

Гарчиг

5 Шашин бидний амьдрал болон нийгэм дэх адислал
Шашин зөвхөн бидний сүнсэнд төдийгүй нийгэм, эрүүл мэнд, харилцаанд нөлөөлдөг.

6 Итгэлийн хөрөг: Иона Викайра—Шинэ Зеланд, Кайкохе
Иона жишгүүдээ дагахын ач холбогдлыг харсан. Тэр Аврагч дээр анхаарлаа төвлөрүүлснээр ухаалаг шийдвэр гаргаж чаддаг.

8 Тохинууллын зарчмууд: Бид бусдыг Сүмд татан оролцуулах соёлыг хэрхэн бий болгож болох вэ?
Бид бусдыг татан оролцуулах хандлагыг хэвшүүлснээр ганцаарддаг байж магадгүй хүмүүсийн амьдралыг өөрчилж чадна.

12 Бид бол гэрчүүд: Өнөөгийн арван хоёр төлөөлөгч
Сара Жэйн Вийвэр ба Жэйсон Свэнсэн
Орчин үеийн төлөөлөгчид өөрсдийн ариун дуудлагын талаар санаа бодлоо хуваалцаж байна.

20 Бидний анхдагчдын үргэлжлүүлж буй өв
Та анхдагчдынхаа үлдээсэн өвийг хэрхэн хүндэтгэж мөн хуваалцаж байна вэ?

22 Үйлчлэлийн илүү ариун загвар
Ахлагч Патрик Кийрон
Тохинуулал бол Сүмийн гишүүдийг тодорхойлогч шинж чанаруудын нэг юм. Та бусдад тохинуулах чадвараа хэрхэн хөгжүүлж болохоо олж хараарай.

28 Бүлэг гэгээнтнийг цуглуул
Энэ бол *Гэгээнтнүүд* цуврал номын 2-р ботийн хараахан хэвлэгдэж гараагүй байгаа хэсэг бөгөөд үүнд Сүмийн эхэн үеийн гишүүд Баруун зүг рүү нүүхээр бэлтгэж байгаа тухай өгүүлдэг.

32 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой
Түүний хүүхдэд өгсөн амлалт адислал болсон. Залбирал нь сорилт бэрхшээлийг туулах явцад гэр бүлд амар амгаланг авчирдаг. Хүнд хэцүү мөчүүд сайн сайханд хүрэх арга замыг тавьж өгдөг. Тэвчээр хатуужил гэгээрэлд хүргэсэн.

36 Бие даасан байдлаас ирдэг адислалууд: Ажилтай болох зургаан алхам
Бруно Вассэлл III
Ур чадвартаа тохирсон ажил олох энгийн зургаан алхмыг өгөв.

⏱ Богино өгүүллүүд



Хавтсан дээр
Христ Арван хоёр төлөөлөгчийг томилж байгаа нь, Харри Андэрсон

Хэсгүүд

Залуучуудад зориулав
42
Хугацаанаасаа өмнө номлолоос бууж, **гэртээ буцаж ирсэн** хүмүүсийн хувийн туршлага **Аврагчийн тусламжтайгаар энэхүү өөрчлөлтийг хийж чадна** гэдгийг харуулдаг.

Өсвөр үеийнхэнд зориулав
50
Коллежид элсэн ороход түүнд Их Эзэний тусламж хэрэгтэй байв. **Ажил хөдөлмөр бол хүнд хүчир ажил биш, харин баяр баясгалан болой.** Та **Христийн гэрч болж** чадна. Цөл газар сүнслэг хоргодох газар болсон нь. Захидал бол хамгийн сайхан бэлэг. **Та Мормоны Номоос юу олж мэдэх вэ?**

Хүүхдүүдэд зориулав
Найз
Хэрхэн хайраар **сайн мэдээг хуваалцах** вэ? Камбожид амьдардаг гишүүдийн талаар уншина уу. **Христэд итгэгч байна гэдэг нь** таны хувьд ямар утгатай болохыг тодорхойл.

ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД

Сэтгэл гутралыг даван туулах нь

Бие даах чадвар хөгжүүлэх үйлчилгээ

Амьдрал сорилт бэрхшээлээр дүүрэн. Гэвч баяр баясгалан болон найдвар олох арга зам үргэлж байдаг.

Хугацаанаасаа өмнө номлолоос бууж, гэртээ буцаж ирсэн номлогчдыг дэмжих нь

Доктор Кэвин Тэриот

Хугацаанаасаа өмнө номлолоос бууж, гэртээ буцаж ирсэн номлогчдыг бид хайрлаж, ойлгох хэрэгтэй.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшн болон comefollowme.lds.org вэбсайтаас дараах зүйлсийг олж болно.

- Сэтгүүлийн энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбараар гарах агуулгыг унш.
- Өмнөх дугааруудыг хай.
- Өөрийн түүх, санал зөвлөмжийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад захиалж өгч, бэлэглэ.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар суралцахаа сайжруул.
- Таалагдсан нийтлэл, бичлэгээ хуваалц.
- Нийтлэлүүдийг татаж ав эсвэл хэвлэ.
- Дуртай нийтлэлүүдээ сонс.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаяг руу э-мэйлээр илгээнэ үү.

Итгэлийг тань хүчирхэгжүүлсэн түүхийг liahona.lds.org вэбсайтад илгээ эсвэл доорх хаягаар шуудангаар илгээнэ үү:
Liahona, flr. 23
50 E. North Temple Street
Salt Lake City, UT, 84150-0023, USA

2019 ОНЫ ДОЛДУГААР САР, 20, №4
Лиахона 18607 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Гонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Рэнди Д.Фанк

Зөвлөхүүд: Бриэн К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт, Бэкки Крэйвэн, Шэрон Юбанк, Кристина Б.Франко, Доналд Л.Холлстром, Ларри С.Качер, Эрих В.Копишкэ, Линн Г.Роббинс

Гүйцэтгэх захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Аллан Р.Лойборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Камилла Кастрион

Редакцийн баг: Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Гаррэтт Х.Гарфф, Жон Райн Жэнсэн, Аарон Жонстон, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мөрдок, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороү, Ричард М.Ромни, Минди Сэлү, Лори Фүллэр Соса, Чакэлл Вардлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн

Зургийн дарга: Тадд Р.Пэтэрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жинэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнтли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Жошуа Дэннис, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чиэко Рэмингтон, Марк В.Робисон, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэтт Нэбэкэр Аун

Хэвлэлийн менежер: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэн Адэйр, Жюли Бөрдэтт, Томас Ж.Кронин, Брайн В. Гайги, Жинни Ж.Нилсон, Мэррисса М.Смит

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Баркэр

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар *Liahona,* Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литов, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португаль, румын, свахили, самоа, себү, словени, солонгос, сингал, тагалог, тай, тамил, тахити, телуг, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2019 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн талаарх мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс арилжааны бус зорилгоор (Сүмийн дуудлага зэрэг) хувийн хэрэгцээндээ *Лиахона* гаас материал хувилан авч, ашиглаж болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол үзүүлэнгийн материалыг хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн сог -intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: July 2019 Vol. 20, No. 4. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.50 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (American Express, Discover, MasterCard, Visa) may be taken by phone or at store.lds.org. (Canada Post Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

ШАШИН

бидний амьдрал болон нийгэм дэх адислал

Итгэл болон шашин шүтлэг нь биднийг тодорхойлох гол хүчин зүйл юм. Нэг үгээр хэлэхэд бидний итгэл бишрэл, шашин шүтлэг өдөр тутмын амьдралд маань нөлөөлдөг гэсэн үг. Христийн болон бусад шашны олон тооны судалгаа шашинд итгэгчид илүү эрүүл саруул байхын зэрэгцээ нийгэмдээ илүү их хувь нэмэр оруулдаг болохыг тогтоожээ. Энд танилцуулсан судалгааны үзүүлэлтүүд шашин бидний амьдралыг сайжруулдаг олон арга замын зарим жишээ юм.

ШАШИНТАЙ ХҮМҮҮС ДАРААХ ХАНДЛАГАТАЙ БАЙДАГ.

- САЙН ДУРЫН АЖИЛД ОРОЛЦОХ,[1] ХАНДИВ ӨГӨХ,[2] ЯНЗ БҮРИЙН КЛУБ, БҮЛГҮҮДЭД ХАМРАГДАХ.[3]
- ИЛҮҮ ЭРҮҮЛ “НИЙГМИЙН ХАРИЛЦААТАЙ, ИЛҮҮ ТОГТВОРТОЙ ГЭРЛЭЛТЭЙ” БАЙХААС ГАДНА НИЙГМИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХУВЬД ИЛҮҮ ӨРГӨН БАЙХ[4].
- “ГЭРЛЭХ МАГАДЛАЛ ӨНДӨР, САЛАХ МАГАДЛАЛ БАГАТАЙ БАЙДАГ БА [ТЭДНИЙ ДУНД] ЭХНЭР НӨХӨРТӨӨ СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙХ ҮЗҮҮЛЭЛТ ӨНДӨР.”[5]
- “БАРАГ ГУРВАН ХҮН ТУТМЫН НЭГ НЬ АЗ ЖАРГАЛТАЙ БАЙГАА ГАА ИЛЭРХИЙЛДЭГ.”[6]
- СЭТГЭЛ ГУТРАЛ, САНАА ЗОВНИЛЫН ТОО ҮЗҮҮЛЭЛТ БАГА.[7]
- ШАШИНГҮЙ ХҮМҮҮСЭЭС ДОЛООН ЖИЛЭЭР УРТ НАСЛАХ ХАНДЛАГАТАЙ.[8] ■

ЭШЛЭЛҮҮД

1. Arthur C. Brooks, *Gross National Happiness: Why Happiness Matters for America—and How We Can Get More of It* (2008), 52-ыг үзнэ үү.
2. Rodney Stark, *America's Blessings: How Religion Benefits Everyone, Including Atheists* (2012), 4-ийг үзнэ үү.
3. Robert D. Putnam, *Bowling Alone* (2000), 66–67-г үзнэ үү.
4. Tyler J. VanderWeele, “Does Religious Participation Contribute to Human Flourishing?” *Big Questions Online,* Jan. 14, 2017, bigquestionsonline.com.
5. Stark, *How Religion Benefits Everyone,* 4.
6. Brooks, *Gross National Happiness,* 48.
7. Andrew Sims, *Is Faith Delusion? Why Religion is Good For Your Health* (2009), 220-ийг үзнэ үү.
8. Stark, *How Religion Benefits Everyone,* 4, 106–107, 111-ийг үзнэ үү.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙН БИЙЧ

Иона Викайра

Шинэ Зеланд, Кайкохе

Хэдийгээр шоронгийн хамгаалагчийн хувьд түүнд асуудал тулгардаг ч Иона Есүс Христэд итгэх итгэлээрээ дамжуулан хүч чадал олж авч, амар тайван байж чаддаг.

КРИСТИНА СМИТ, ЗУРАГЧИН

Ажлын тань хүрээнд ажилладаг хүмүүс таныг Сүмийн гишүүн гэдгийг мэдэж, байгаа орчноосоо шалтгаалан жишгээ бууруулахгүй байгааг тань хараад, таныг болон Сүмийг хүндэлдэг болохыг би мэддэг болсон. Тиймээс хожмын үеийн гэгээнтний сайн үлгэр жишээг үзүүлэхийг хичээх нь миний хувьд чухал юм.

Ямар ч нөхцөлд орсон бай, би “Аврагч надаас биеэ хэрхэн авч явахыг хүсэх байсан бэ?” эсвэл “Тэрээр намайг үүнийг хэрхэн шийдвэрлэ гэх байсан бол?” гэж боддог. Би ямар ч үед үйлдлүүдээ Аврагчийн хийх байсантай адил байлгахыг хичээж анхаардаг. Энэ нь надад хүнд хэцүү ажлын эмх замбараагүй орчинд ч гэсэн илүү хүлээцтэй, тайван байхад тусалдаг.

ИЛҮҮ ИХИЙГ СУРАЛЦ

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) **lds.org/go/7197** дээр эргэн тойрныхоо бүх хүнд үлгэр жишээ болохын ач холбогдлыг заасан.

Итгэлийн хөрөг цувралын бусад түүхийг **lds.org/go/18** вэбсайтаас үзнэ үү.

Тохинууллын зарчмууд

Бид бусдыг **Сүмд татан оролцуулах** соёлыг хэрхэн бий болгож болох вэ?

Бид тойрог, салбарынхнаа тойруулан харах юм бол бусадтай хэл амаа амархан ололцдог хүмүүсийг илүү сайн олж хардаг юм шиг санагддаг. Харин хэл амаа амархан ололцдог олон хүний дунд хүний нүдэнд өртөлгүй өнгөрдөг хүмүүс байдаг гэдгийг бид ухааран ойлголгүй өнгөрдөг. Жишээлбэл, саяхны нэгэн судалгаагаар Нэгдсэн Улсын насанд хүрэгчдийн бараг тэн хагас нь ганцаардсан, орхигдсон эсвэл бусдаас тусгаарлагдсан байдаг[1] гэдгийг олж тогтоожээ.

Хамт олны нэгэн хэсэг гэдгээ мэдрэх нь чухал байдаг. Энэ бол хүний үндсэн хэрэгцээ бөгөөд гадуурхагдаж байгаагаа мэдрэх хэцүү. Орхигдох нь уйтгар гуниг эсвэл уур уцаарыг төрүүлдэг.[2] Хамт олны нэгэн хэсэг биш юм шиг санагдах үед бид арай ая тухтай газрыг хайж эхэлдэг. Бид хүн бүрд сүмийн нэгэн хэсэг гэдгийг нь ойлгуулан туслах хэрэгтэй.

Аврагчтай адил татан оролцуулах нь

Аврагч бусдыг үнэлэх, тэднийг татаж оролцуулахын төгс жишээ байсан. Тэр төлөөлөгчдөө сонгохдоо тэдний нийгэмд эзлэх байр суурь, эд хөрөнгийг эсвэл нэр төртэй ажил мэргэжлийг нь чухалчилж үзээгүй. Тэр худаг дээрх самари эмэгтэйг хүндэтгэж, иудейчүүд самаричуудыг хэрхэн басамжилдгийг үл харгалзан Өөрийн бурханлаг байдлын талаар түүнд гэрчилсэн юм (Иохан 4-ийг үзнэ үү). Тэр зүрх сэтгэлийг хардаг бөгөөд хүмүүст нүүр тал хардаггүй (1 Самуел 16:7; Сургаал ба Гэрээ 38:16, 26-г үзнэ үү).

Аврагч "Бие биенээ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биенээ хайрлагтун гэсэн шинэ тушаалыг Би та нарт өгч байна.

Бие биендээ хайртай байваас та нарыг Миний шавь нар мөн гэдгийг үүгээр чинь бүгд мэдэх болно" (Иохан 13:34–35) гэж хэлсэн.

Бид юу хийж чадах вэ?

Заримдаа хэн өөрийгөө гадуурхагдаж байна гэж бодож байгааг олж хэлэхэд хэцүү. Ихэнх хүн үүний талаар, өчүүхэн ч болов тодорхой ярьдаггүй. Гэвч бид зүрх сэтгэлдээ хайрыг тээн, Ариун Сүнсний удирдамжийг дагаж, ажигч гярхай

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

байхыг хичээвэл Сүмийн цуглаанд болон үйл ажиллагаануудад оролцохгүй байгаа хүмүүсийг ялган таньж чадна.

Гадуурхагдаж байгаа гэж бодож байгаа хүмүүсийн зарим шинж тэмдэг:

- Цээжин дээрээ гараа зөрүүлж тавих, доошоо харах зэргээр хаагдмал байдал үзүүлэх
- Өрөөний ар талд эсвэл ганцаараа суух
- Сүмд огт ирэхгүй байх эсвэл хааяа нэг ирэх
- Цуглаанаас эсвэл үйл ажиллагаанаас эрт гарч явах
- Ярианд эсвэл хичээлд оролцохгүй байх зэрэг юм.

Эдгээр нь бас ичимхий байх, сэтгэл санааны хувьд тавгүй эсвэл тухгүй байх зэрэг өөр сэтгэлийн хөдлөлийн илрэл байж болно. Сүмийн шинэ гишүүн байх, өөр улс орноос эсвэл өөр соёл бүхий газраас шилжиж ирэх, гэр бүл салах, гэр бүлийн гишүүнээ алдах юм уу хугацаанаасаа өмнө номлолоос буух зэрэг амьдралын хүнд өөрчлөлттэй тулгарсан бол гишүүдэд бусдаас "өөр" гэсэн мэдрэмж төрөх үе бий.

Ямар ч шалтгаантай бай, хайраар тусламжийн гараа сунгахаас бүү эмээ. Бидний хэлж, хийж буй бүхэн хүмүүсийг дотно угтан авч, тэдний оролцоо хэрэгтэй гэдгийг нь мэдрүүлэхэд болно.

Өөрсдөөсөө өөр хүмүүсийн эргэн тойронд биеэ чөлөөтэй авч явах тийм

ТУРШЛАГАА ХУВААЛЦ

Та бусдад эсвэл бусад хүн танд тохинуулж байсан туршлагаасаа бидэнд илгээнэ үү. Та liahona.lds.org вэбсайт руу ороод, "Submit an Article or Feedback" дээр дарна уу.

Хүмүүсийг татан оролцуулж, урих аргууд

- Сүм дээр үргэлж нэг хүний дэргэд бүү суу.
- Бусдыг яриандаа оролцуул.
- Сүм нь хүн тус бүрийн ялгаатай байдлаас үл хамааран хүн бүрд зориулагдсан гэж хэлэхдээ, энэ нь үнэндээ юу гэсэн утгатай үг болохыг бодож үзээрэй. Бид үүнийг хэрхэн бодит байдал дээр хэрэгжүүлж болох вэ?
- Бусдыг амьдралынхаа нэг хэсэг болоход урь. Та төлөвлөж байгаа үйл ажиллагаандаа тэднийг оролцуулж болно.
- Хайраа илэрхийлж, чин сэтгэлээсээ магтан сайшаа.
- Таны шаардлагад нийцэхгүй байна гэх шалтгаанаас болж найзалж нөхөрлөхөө больж болохгүй.
- Та тухайн хүнээс ямар нэг онцгой зан чанарыг олж харвал үүнийг нь үл тоомсорлож эсвэл зайлсхийхийн оронд сонирх.
- Нийтлэг сонирхлоо олж, хөгжүүл.
- Доторх жинхэнэ хүнийг нь олж харахын тулд гаднах байдалд нь анхаарлаа бүү хандуул. (Энэ сэдвийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг “Тохинуулал нь бусдыг Аврагчийнхтай адил арга замаар харахыг хэлнэ,” *Лиахона,* 2019 оны 6-р сар, х. 8–11-ээс олж авч үзнэ үү.)

Бусдыг татан оролцуулснаар адислагдсан нь

Кристл Фэчэр төрсөн нутгаа дайнд нэрвэгдсэний дараа өөр улс руу нүүжээ. Тэр хэл сайн мэдэхгүй мөн хөршүүдээ таньдаггүй байсан тул эхэндээ бусдаас тасалгдсан, ганцаардсан байдлыг мэдэрдэг байв.

Тэр Сүмийн гишүүн байсан тул зориг гарган, шинэ тойрогтоо явж эхэлсэн байна. Хатуу хэл аялга нь хүмүүст өөртэй нь ярихад саад болох вий гэхээс эсвэл ганц бие эмэгтэй гэж түүнийг шүүмжлэх вий гэхээс тэр эмээж байлаа.

Гэвч тэр түүний ялгааг үл тоон, найз нөхдийнхөө хүрээлэлдээ урьж оруулсан хүмүүстэй таарсан юм. Тэд түүнийг хайрлан, тусламжийн гараа сунгасан ба тэр удалгүй Хүүхдийн хэсгийн ангид заахад туслан завгүй байх болов. Хүүхдүүд бусдыг хэрхэн хүлээн авахын гайхалтай үлгэр жишээг үзүүлсэн ба бусдын хайрыг мэдэрч, тэдэнд хэрэгтэй гэдгээ мэдсэн явдал түүний бүхий л амьдралынхаа туршид үнэнч байсан Их Эзэнд итгэх итгэлийг нь дахин бадраасан юм.

ч амар хялбар зүйл биш юм. Гэхдээ дасгал сургуулилт хийснээр хүн бүрийн ялгаатай байдлаас сайн талыг нь олж хардаг болж, хүн бүрийн оруулж буй онцлог хувь нэмэрт талархдаг болно. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф бидний өөр хоорондоо адилгүй тал биднийг илүү сайн, аз жаргалтай хүмүүс болгож чадна хэмээн заасан. Тэр “Ирээд, Бурханы бүх хүүхдэд эдгэрч, сайхан сэтгэл, өршөөлийн соёлыг төлөвшүүлж, бэхжүүлэхэд бидэнд туслаач”[3] хэмээн хэлсэн. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Alexa Lardieri, “Study: Many Americans Report Feeling Lonely, Younger Generations More So,” *U.S. News,* May 1, 2018, usnews.com-ийг үзнэ үү.
2. Carly K. Peterson, Laura C. Gravens, and Eddie Harmon-Jones, “Asymmetric Frontal Cortical Activity and Negative Affective Responses to Ostracism,” *Social Cognitive and Affective Neuroscience*, vol. 6, no. 3 (June 2011), 277–285-ыг үзнэ үү.
3. Дийтр Ф.Угдорф, “Итгэ, хайрла, үйлд,” *2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган.*

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Өөр санаа авах хэрэгтэй бол “We Can Do Better: Welcoming Others into the Fold,” *Liahona,* Sept. 2017-оос уншина уу.

АМЬДРАЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч асан Линда К.Бөртон эгч “Эхлээд ажиглаад, дараа нь үйлчил” (*Liahona,* Nov. 2012, 78) хэмээн заасан. Энэ зөвлөгөөг дагах нь бидэнд хүн бүрийг татан оролцуулж, хэрэгтэй хүн гэдгийг нь ойлгуулах тойрог, салбарыг бий болгоход тус дэм болох юм. Асууж болох зарим асуултыг доор өгөв. Үүнд:

- Бид сүмийн байрандаа орж ирээд, тухайн өдөр Их Эзэн хэнийг найзынхаа хүрээлэлд оруулаасай гэж хүсэж байгааг **харж мөн ажигла.**
- Бид заримдаа буруу юм хэлчих вий гэхээсээ айж, өөрсдөөсөө өөр эсвэл хүнд хэцүү байдалд орсон хүмүүсээс зайлсхийдэг. Энэ нь тэдэнд яагаад хэн ч өөртэй нь ярихгүй байгаад гайхан, гадуурхагдсан мэт санагдуулдаг. **Тэдний хажууд сууж, хайраа илэрхийлэн, чин сэтгэлээсээ асуу.** Хүнд хэцүү байдлынх нь талаарх туршлагаас мөн хэрхэн тусалж болох талаар бас асуу.
- Бид үг хэлэхдээ эсвэл ням гаргийн хичээл дээрээ **өөр өөр нөхцөл байдалд амьдарч буй хувь хүн, гэр бүлүүд** сайн мэдээний дагуу амьдарч, адислалуудыг нь хүртэж болохыг харуулсан жишээг ашиглах хэрэгтэй.
- Багш нар **бүх насныхан болоод бүх үндэстэн ястан, бүхий л нөхцөл байдалд байгаа гэр бүлийн гишүүдийг** татан оролцуулбал ангийн гишүүд тун их адислагдах болно. Биднээс өөр туршлагатай Сүмийн олон итгэлтэй гишүүнээс сурах зүйл их бий.
- Багш нар сайн мэдээний дагуу амьдарч байгаа туршлагаасаа хуваалцах аюулгүй орчныг хүн бүрд бүрдүүлж өгч болно. Хүмүүсийг бодол санаагаа хуваалцах тоолонд багш **тэдний хэлж буй зүйлсэд эерэг байдлаар хариулж болно.** Тэгвэл ангийн гишүүд бодол санаагаа өөртөө итгэлтэй, чөлөөтэй хуваалцах болно.

Бид бол гэрчүүд:
Өнөөгийн арван хоёр төлөөлөгч

Орчин үеийн төлөөлөгчид ариун нандин дуудлагынхаа талаарх өөрсдийн бодлыг хуваалцаж байна.

Сара Жэйн Вийвэр, Жэйсон Свэнсэн
Сүмийн мэдээ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм зохион байгуулагдсанаас хойших 189 жилийн хугацаанд 102 хүн Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр үйлчлэхээр дуудагджээ. Их Эзэн үүнээс хойш олон өөрчлөлтийг хийхээр удирдсан ч төлөөлөгчийн үндсэн үүрэг өөрчлөгдөөгүй.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллард Ариун сүмийн талбайн хажууд байдаг албан өрөөнөөсөө, төлөөлөгчдөд олгогдсон дэлхий даяар Аврагчийг гэрчлэх сүнслэг эрх мэдэл, номлогчид, төлөөлөгчдийн хоорондын онцгой холбоо, "төлөөлөгч, үзмэрч, илчлэгч байх" тухай нийтэд түгсэн буруу ташаа ойлголтын талаар ярьсан юм. Энэ нийтлэлийн энэхүү хэсэгт зориулан өөрсдийн ариун нандин дуудлагын талаар ярих Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын өөр гишүүдийг санал

болгож болох эсэхийг түүнээс асуухад “Байлгүй яах вэ. Бүгдээрээ” хэмээн тэр хариулсан юм.

Цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах нь

Өнөөгийн төлөөлөгчдөд асар их саад бэрхшээл тулгарч байна. Тэд улс төрийн тайван бус байдал, гэр бүлийн нуралт, хөврөн үргэлжлэх олон нийтийн мэдээллийн хэрэгслийн дарамт шахалт болон эдийн засгийн тодорхойгүй байдал зэрэг сорилттой тулгарч байгаа дэлхий даяарх цугларагсдад тохинуулж байна. Гишүүдэд тулгамдаж буй асуудал, тэдний нөхцөл байдлыг ойлгодог байх нь төлөөлөгчийн хувьд чухал юм.

Сүмийн удирдагчдын хувьд төлөөлөгчид хүмүүст илүү сайн хүрч үйлчлэхийн тулд тэднийг болон тэдний нөхцөл байдлыг сайн мэддэг байх ёстой.

Ахлагч Улиссэс Соарэс “Бид хүмүүсийн амьдралд нөлөөлж буй зүйлсийг мэддэг байх хэрэгтэй. Төлөөлөгчид байнга суралцаж, асууж лавлан, сүнслэг өдөөлт болон илчлэлт хүлээн авдаг байх ёстой” хэмээн хэлсэн.

Гишүүдэд тулгамдаж байгаа асуудлыг мэддэг байхын зэрэгцээ төлөөлөгчдийн хувьд Бурханы удирдамжийн дуу хоолойг анхааралтай сонсож, Их Эзэний таалалд нийцүүлэх нь илүү чухал хэмээн ерөнхийлөгч Баллард хэлэв. Тэр “Энэ бол Их Эзэний Сүм бөгөөд энэ дэлхий дээрх Түүний хаант улсыг Өөрийнх нь биднээс хүсдэг арга замаар авч явах тухайд анхаарах нь бидэнд тулгардаг томоохон сорилт юм” гэж ерөнхийлөгч Баллард хэлсэн.

Онцгой гэрчүүд

Төлөөлөгч бүрийг өөрийн дуудлагын талаар ярих үед тэдний дуудлагын удирдлагын хэсэг гол ажил нь биш болох нь тодорхой болдог. Тэдний үндсэн үүрэг бол өмнө нь байсанчлан, “бүх дэлхийд Христийн нэрний тусгай гэрчүүд байх” (Сургаал ба Гэрээ 107:23) явдал юм.

Аврагчийн төлөөлөгчдөдөө өгсөн сүүлийн заавар нь “зааж, гэрчилж, баптисм хүртээж мөн Түүний Сүмийг байгуулж, хүчирхэгжүүлэх” (Матай 28:19–20) явдал байсан хэмээн ерөнхийлөгч Баллард хэлэв.

Өнөөгийн төлөөлөгчдийн үүрэг ч гэсэн хэвээр байгаа. “Бид юуны түрүүнд, бүхий л цаг үеийн туршид Их Эзэн Есүс Христ амьд гэдгийн гэрч юм. Бид удирдах ажилтнууд биш, харин Есүс Христийн сайн мэдээний тохинуулагчид мөн” гэж ахлагч Дэвид А.Бэднар хэлсэн.

Ахлагч Жэффри Р.Холланд төлөөлөгчид “бүх дэлхийгээр” “аялан явдаг гэрчүүд байхаар” томилогддог гэж хэлсэн. Тэр мөн “Бид газар зүйн хувьд хамгийн алслагдсан Сүмийн нэгжийнхэнд хүртэл тэднийг Их Эзэний бошиглогчтой ойр дотно холбоотой байдгийг мэдрүүлэхийг хүсдэг. ‘Сүм дэлхийн өчүүхэн хэсгийг

BUSATH PHOTOGRAPHY-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

эзэлдэг' гэж олонтоо хэлдэг. Төлөөлөгчийн харилцаа холбооны хувьд ийм л байгаасай гэж би боддог" хэмээн хэлсэн юм.

Гадас болгонд хүрч үйлчлэх нь

Ахлагч Квинтин Л.Күк дөрвөн жил тутам Сүмийн гадас, тойрог, дүүрэг, салбар бүрд Арван хоёрын гишүүн ирж, удирдагчидтай нь уулзан, тэдэнд бошиглолоор өгөгдсөн нэн чухал асуудлаар сургалт явуулдаг гэж тайлбарласан.

"Удирдагчдын чуулган нь бидэнд Тэргүүн Зөвлөлийн удирдлаган доор 'Сүмийг [төлөвшүүлэн], үүний бүх үйл хэргийг үндэстэн ястан бүрд адилхан [удирдан явуулах]' [Сургаал ба Гэрээ 107:34] сургаалын үүргээ биелүүлэх боломжийг олгодог" гэж хэлсэн юм.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийн хуримтлуулсан баялаг, гүн гүнзгий сургамжтай туршлага орон нутгийн эдгээр удирдагч гишүүдээ асуудалтай үед нь урамшуулж, дэмжих чухал шийдвэрүүдийг гаргахад нь зааварчлан хөтлөн туслах боломж бололцоогоор хангадаг болохыг ахлагч Бэднар хэлсэн.

Ахлагч Гэррит В.Гонгийн хэлснээр "Бид өөр өөр газраар явахдаа гишүүдийнхээ сайн сайхныг мэдэрдэг. Бид туршлагуудыг нь сонсон, дэлхийн өөр өөр хэсэгт болон Сүмийн доторх өөр өөр бүлэгт болж буй зүйлийн талаар чуулгын хувьд хамтдаа зөвлөлдсөнөөр бидэнд ойлгоход туслах зүйлсийг мэдэж авдаг."

Удирдагчдын чуулгануудад оролцохоор явах нь бидэнд "гайхалтай, сайхан хүмүүстэй учрах боломжийг олгодог. Бидэнд тэдний гэрээр айлчилж, тэдэнд тохинуулах боломж гардаг юм. . . . Бидний сэтгэл зүрхэнд хамгийн гүн гүнзгий нөлөөлдөг зүйл бол гэгээнтнүүдэд тохинуулах явдал. Бид үүнийг Ариун Сүнсний болон Аврагчийн удирдамжийн дагуу мөн заримыг нь хуваалцахад хэт ариун нандин туршлагаар олж авсан мэдлэгийнхээ хүрээнд хийдэг" хэмээн ахлагч Күк хэлсэн юм.

Нэг нэгээр нь

Ерөнхий эрх мэдэлтнээр болон одоо Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчлээд нийт 43 жил буюу дөрөв дэх арван жилдээ үйлчилж байгаагийн хувьд ерөнхийлөгч Баллардын ажил үүрэг түүнийг дэлхийн

Төлөөлөгч гэдэг үг нь “илгээгдэх” гэсэн утгатай грек үгээс гаралтай. Аврагч эртний төлөөлөгчдийн нэгэн адил Өөрийн төлөөлөгчдийг “бүх ертөнцөд” илгээсээр байна (Марк 16:15–16).

ЯВЖ, БҮХ ҮНДЭСТЭНД ЗАА, ХЭРРИ АНДЭРСОН

ихэнх улс оронд айлчлан очиж, олон мянган гишүүнтэй болон номлогчтой нүүр тулан уулзаж, тохинуулах боломжийг олгосон. Олон сая хүн түүний Ерөнхий чуулган болон онцгой цугларалт дээр хэлсэн үгийг сонсож байсан. Хэдийгээр түүнд дэлхийг хамарсан үүрэг хариуцлага байдаг ч гэлээ, Ариун Сүнс түүнийг хувь хүмүүстэй холбогдох, тэднийг адислах боломжийг олгодог. Энэ нь учир зүйн хувьд зөрчилтэй мэт санагдавч Аврагчийн арга зам иймл байсан гэж тэр хэлэв. “Би заримдаа ‘Таны сургалтад суух үеэр та амьдралыг минь өөрчилсөн зүйлийг хэлж билээ’ гэсэн захидлуудыг хүлээн авдаг. Энэ бол Ариун Сүнсний хүч юм. Их Эзэн Өөрийн Сүмийн бүх зүйлд жижиг гэлтгүй оролцдог” хэмээн тэр хэлсэн.

“Дэлхий даяарх Сүмийн гишүүдтэй өнгөрүүлдэг энгийн мөртлөө гайхалтай сайхан олон туршлага” төлөөлөгчийн тохинууллыг тодорхойлдог хэмээн ахлагч Бэднар хэлсэн юм. Тэр бас “Их Эзэн Арван хоёрын чуулгын гишүүнийг тодорхой цагт тодорхой газар илгээснээр бид зовж зүдэрсэн эсвэл тайтгарал, урмын үг сонсох хэрэгтэй итгэлтэй хожмын үеийн гэгээнтнүүдтэй болон өөр бусад хүнтэй учирдаг. Бурхан эдгээр уулзалтыг удирддаг” гэж нэмж хэлсэн.

Ахлагч Роналд А.Расбанд төлөөлөгчөөр дуудагдсаныхаа дараа Сүмийн гишүүдтэй болон бусадтай мэндчилэхэд цаг гаргахын тулд амьдралдаа нэмэлт цаг гаргах хэрэгтэйг мэдэж авснаа хуваалцаж билээ. “Энэ нь миний тухай асуудал биш юм. Асуудал нь энэ Сүмийн гишүүд төлөөлөгчийн албыг хэрхэн өөрөөр харж, хүндэтгэл үзүүлдэгт оршдог юм” хэмээн тэр хэлсэн.

Ахлагч Расбандыг төлөөлөгчөөр томилогдох үед түүнд “Бид таныг бүх дэлхий даяар, бүх цаг үед мөн ямар ч нөхцөл байдалд Христийн нэрийн онцгой гэрч байхаар томилж байна” хэмээн зааварласныг тэр хэлэв. ‘Бүх цаг үед, ямар ч нөхцөл байдалд’ гэсэн үг намайг томилох адислалд орсон байсан” хэмээн тэр нэмж хэлсэн юм.

Чухал харилцаа

Төлөөлөгчид болон Сүмийн 70000 гаруй бүрэн цагийн номлогчийн хоорондын харилцаа холбоо ариун нандин, тэр ч бүү хэл харилцан хамааралтай байдаг.

Төлөөлөгч гэдэг үг нь “илгээгдэх” гэсэн утгатай грек үгээс гаралтай хэмээн ахлагч Дэйл Г.Рэнланд тайлбарлав. “Бүх ертөнцөөр явж, сайн мэдээг хамаг бүхэнд тунхаглагтун. Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно” (Марк 16:15–16) хэмээн Аврагч эртний төлөөлөгчдөдөө үүргийг нь тодорхойлсныг бодож үзнэ үү.

Арван хоёр нь энэ зарлигийг дагахдаа номлолын болон сайн мэдээний захиасыг хүргэх ажилд “зөв шударгаар оролцдог” хэмээн ерөнхийлөгч Баллард хэлэв.

Эртний Паулын адилаар өнөөгийн төлөөлөгчид бусадтай сайн мэдээнээс хуваалцах үүргийн талаар залбирч, бусдыг томилдог. Мөн номлогчид төлөөлөгчидтэй адил Христийн сайн мэдээг заахаар дэлхий даяар илгээгддэг. “Арван хоёр өөрсдөд нь буй түлхүүрүүдийг ашиглан тэднийг номлолд томилдог. Тиймээс бид ийн тэднийг илгээдэг” гэж ахлагч Бэднар хэлсэн.

Их Эзэн номлолын ажлыг удирдан явуулдаг удирдагч хэвээр. Тэр Номлолын гүйцэтгэх зөвлөлд өөр өөр цаг үед үйлчлэхээр ээлжлэн томилогддог амьд

Ерөнхийлөгч Баллард Испанид

Ахлагч Холланд Англид

Ахлагч Угдорф Орост

төлөөлөгчдөдөө номлолын талбарт үйлчилж буй бүрэн цагийн номлогчдод Өөрийнх нь хүслийг уламжлах эрх мэдлийг олгодог. Эдгээр удирдах үүрэг нь зүгээр нэг "зохион байгуулалтын" үүргийн хүрээнээс хальсан байдгийг ахлагч Бэднар хэлсэн. Төлөөлөгчид Израилыг цуглуулах санваарын түлхүүрүүдийг атгадаг. "Ажлыг Их Эзэний хүслийн дагуу хийхийн тулд бид сүнслэг хараа болон удирдамж зааврыг өгдөг" гэж тэр хэлэв.

Ахлагч Дийтр Ф.Угдорф Сүмийн Номлолын Гүйцэтгэх Зөвлөлийг тэргүүлдэг. Ажлын ширээн дээр нь заах уулзалт руугаа яаран хар хурдаараа дугуйгаа жийж байгаа номлолын хамтрагчдыг харуулсан жижиг хүрэл баримал байлаа. Тэрхүү хүрэл баримал төлөөлөгч, номлогч хоёрын хоорондын салшгүй холбоог түүнд сануулдаг ажээ. "70000 номлогч тус бүр ариун нандин үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд Их Эзэн тэднийг Аврагчийн төлөөлөгч болох Бурханы бошиглогчоос хүлээн авсан захидлаар дуудсан билээ. Тэд Арван хоёрын гар хөл болдог.

Бидэнд цаг зав гарах бүрд бид тэдэнтэй уулздаг" гэж ерөнхийлөгч Баллард хэлсэн. "Би тэдэнд асуух боломж олгодог. Бид тэдэнд Тэнгэрлэг Эцэгийнхээ хүүхдүүдийг олж, зааж, баптисм хүртээн, хүчирхэгжүүлэхэд нь туслахыг хичээдэг.

Хамтарч ажилласнаар хоёр бүлгийг хоёуланг нь сайн мэдээний сайхан мэдээг хуваалцуулахаар дэлхий даяар илгээдэг юм. Бид бүрэн цагийн номлогчдыг өөрсдийн хамтрагчид гэж үздэг" хэмээн ахлагч Д.Тодд Кристоффэрсон хэллээ.

Буруу ташаа ойлголт

Гаднаас нь харж байгаа хүмүүст Сүмийг корпорацийн адил удирддаг гэж ойлгож болох ч төлөөлөгч байх нь "бизнесийн байгууллагын гүйцэтгэх захирал байхтай адилгүй бөгөөд үнэндээ тэс өөр байдаг" гэж ахлагч Гари И.Стивэнсон хэлсэн юм. Их Эзэн Есүс Христийн төлөөлөгч байх үүрэг нь үнэн хэрэгтээ тохинууллын мөн санваарын үүрэг юм. Дэлхийд Есүс Христийн гэрч байх үүрэг нь "бидний сэнхрүүлж, тодорхойлдог."

Ахлагч Нийл А.Андэрсэн Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгад бүлэглэл, лобби эсвэл хүчний төв гэж байдаггүй гэжээ. "Өөр өөр санаа гарч" болох ч "ямар ч хувийн ашиг сонирхол байдаггүй."

Их Эзэн өөр өөр мэргэжил, нөхцөл байдалд байсан хүмүүсийг цуглуулан авчирдаг хэмээн ахлагч Андэрсэн хэлсэн юм. Гэвч "тэд Аврагчийн талаарх гэрчлэл, даруу байдлаараа адилхан. Тэд албан тушаал эрэлхийлж, өрөөнийхөө хамгийн ухаантай хүн болохыг хичээдэггүй. Их Эзэн ийм хүмүүсээр дамжуулан ажиллаж чадна. Би [Арван хоёрын] хэн нэг нь уурлаж байхыг мөн өөр хэн нэгнийг дорд үзэж байхыг харж байгаагүй.

Даруу байдал төлөөлөгчдийг тодорхойлдог хэмээн ахлагч Угдорф хэлэв. Дуудлагууд нь тэднийг аялж яваа бараг газар бүрд нь олны танил болгодог ч "энэ нь бидний тухай биш, харин Түүний тухай гэдгийг бид мэднэ. Бид Түүнийг төлөөлдөг. . . . Энэ бол Түүний сайн сайхны тухай юм."

Ахлагч Кристоффэрсон Мексикт

Ахлагч Бэднар Перуд

Ахлагч Кук Аргентинд

Бид бүгд үйлчлэхээр дуудагдсан

Аврагч Өөрийн үхэл, Амилалтын дараа шавь нартаа 40 өдрийн турш заавар өгч, дараа нь тэнгэрт одсон. Искариотын Иудасын урвалт болон үхлээс үүдэн Арван хоёрын чуулгад хоосон зай гарахад чуулгын гишүүд цугларч, Их Эзэнд хүсэлт тавьсан.

Маттиа болон Барсаб гэсэн хоёр хүнийг тодорхойлсон тул төлөөлөгчид залбирч, "Эзэн, Та энэ хоёрын хэнийг сонгож байгаагаа харуулаач . . . хэмээхэд шавга нь Маттиа дээр бууж, тэрээр арван нэгэн элч нарын хамт тоологдох болжээ" (Үйлс 1:23–26-г үзнэ үү).

Түүнээс хойш өнөөг хүртэл "Төлөөлөгчөөр дуудагдах нь ямар нэг амжилт ололтыг илэрхийлдэггүй" хэмээн ахлагч Рэнланд тайлбарласан юм. "Энэ нь хичээл зүтгэл гарган олж авдаг дуудлага биш. Үйлс номын 1-р бүлэгт Маттиа Барсабын оронд Бурханаар сонгогддог. Бурхан яагаад гэдгийг бидэнд хэлээгүй. Гэхдээ Аврагчийг болон Түүний амилалтыг хүндэтгэсэн Барсабын гэрчлэл Маттиагийнхтай адилхан байсныг бид мэдвэл зохино."

Бурхан сонгосон гэдгийг тэр тайлбарласан. "Хэрэв Барсаб өөрт оногдсон дуудлага бүрээ гүйцэтгэж, дуудлагаа эрхэмлэн биелүүлсэн бол түүний шагнал Маттиагийн хүлээн авсан шагналаас огтхон ч өөр байхгүй байх байсан.

Ахлагч Андэрсэн Бразилд

Барсабын гэрчлэл Маттиагийн гэрчлэлтэй яг адилхан байсан шиг Сүмийн гишүүн бүр "төлөөлөгчийнх шиг харилцааг Их Эзэнтэй үүсгэх эрхтэй бөгөөд үүсгэж ч чадна" хэмээн ерөнхийлөгч Баллард хэлэв.

Их Эзэнд болон Сүмд үйлчлэх нь "онцгой эрх бөгөөд адислал юм. Энэ бол хүндлэл. Их Эзэн биднийг гэх хайраа харуулдаг бөгөөд бид ч гэсэн Түүний биднээр хийлгэхийг хүссэн зүйлсийг хийснээр Түүнд хайраа харуулж чадна" хэмээн ахлагч Угдорф хэлэв.

Ариун туршлага

Аяллын дээд зөвлөлийн гишүүн байх нь ариун туршлага болохыг ахлагч Андэрсэн хэлсэн. "Биднийг гэрчлэлээ хуваалцахад уг гэрчлэл зарим байдлаараа бидний томилолтоос шалтгаалан хүмүүсийн зүрх сэтгэлд хүрдэг."

Ахлагч Кристоффэрсон төлөөлөгчөөр дуудагдсаныхаа дараахан хүмүүсийн хүлээлтээс болж сэтгэлээр унаж байжээ. Гэвч тэр дараа нь "Өөрийнхөө талаар мөн хүмүүст гүн сэтгэгдэл төрүүлсэн эсвэл урам нь хугарсан эсэхээс үл хамааран чиний тухай тэдний бодлыг март. Зөвхөн миний чамаар дамжуулан тэдэнд өгөх зүйлд л анхаарлаа хандуул. Миний чамаар дамжуулан тэдэнд сонсгохыг хүссэн зүйлст л анхаарлаа хандуул" гэх Их Эзэний энгийн хариултыг хүлээн авчээ.

Хэдэн жилийн өмнө ахлагч Кристоффэрсоныг Венесуэлийн Мэридад айлчилж байхад долоо орчим настай гэмээр бяцхан хүү түүнийг цонхоор хараад, *"El Apostol, el Apostol!"* ("Төлөөлөгч өө, төлөөлөгч өө!") гэж хашгирч эхлэв.

Энэ нь маш энгийн үйл явдал байсан ч хүүхдүүд хүртэл энэ дуудлагыг хэрхэн хүндэлж явдгийг надад харуулсан юм. Асуудал нь дуудлагыг хүлээн авсан хүнд байгаа юм биш. Тэр хүүхэд энэ дуудлагад талархдаг төдийгүй энэ нь юуг төлөөлж байгааг мэдэж байлаа" гэж тэр хэлэв. ■

ГЭРЭЛ ЗУРГУУДЫГ ХУАН АНТОНИО РОДРИГЭЗ (ИСПАНИ), САЙМОН ЖОУНС (АНГЛИ), ЛУИС АНТОНИО АРРОЁО АБАНДО (ПЕРУ), КРИСТЭН АЛБО (АРГЕНТИН), ДАЛИНЭ ГРИФФИН (МЕКСИК), АЛЕКСАНДР БӨРЖЭС (БРАЗИЛ) НАР АВАВ

Бид удирдагчдаа хэрхэн дэмжиж болох вэ?

Сара Жэйн Вийвэр, Жэйсон Свэнсэн
Сүмийн мэдээ

Сүмийн гишүүд арван хоёр төлөөлөгчийг дэмжин батлаcнаар төлөөлөгч бүрийг Аврагчид дуулгавартай байна хэмээн өгсөн амлалтдаа үнэнч байна гэдэгт итгэж байгаагаа харуулдаг.

2017 оны 10-р сард Калифорнийн Сонома гүнлэгийн ойр орчмын айлуудыг бүхэлд нь хамарсан түймрийн дараах гунигтай өдрүүдэд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роналд А.Расбанд хожмын үеийн гэгээнтнүүдтэй хамт байхаар түймэрт нэрвэгдсэн газарт очсон юм.

Тэр тохинууллын номлол хийж байлаа. Расбанд ах, Мэлани Расбанд эгч хоёр түймрийн уршгаар ядарч туйлдсан гишүүдийг цуглааны байруудад болон шатсан гэрийнх нь ойр орчинд очин тайтгаруулав.

Түүнийг хаана ч явсан гишүүд ирж, гар барьж байлаа. Энэ нь талархаж буйн илэрхийлэл байв. Тэд төлөөлөгчийг тусалж дэмжсэнд талархаж байв. Гэхдээ хүмүүс гар барих бүрдээ "Би таныг дэмждэг шүү" гэсэн нийтлэг хандлагыг илэрхийлж байлаа.

Итгэлийн үйлдэл

Дэмжих гэдэг нь Сүмийн гишүүдийг Сүмийн удирдагчидтай холбодог ариун нандин үйлдэл юм гэж ахлагч Гари И.Стивэнсон хэлсэн. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм 16 сая гаруй гишүүнтэй боловч төлөөлөгчтэй нүүр тулан ярьж, гар барих боломж Сүмийн гишүүдийн дунд харьцангуй ховор тохиодог. Гэвч гишүүн бүр албан ёсоор дэмжин батлах саналаараа мөн дэмжиж байгаагаа баталж буй өдөр тутмын үйлдлээрээ дамжуулан тэдэнтэй болон Сүмийн бусад удирдагчтай хувийн харилцаа холбоо үүсгэх боломжтой байдаг хэмээн Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллард хэлсэн.

"Бид гараа өргөхийн зэрэгцээ зүрх сэтгэл, үйлдлээрээ дэмжин баталдаг. Бид бие биенээ дэмждэгтэй яг адил арга замаар Сүмийн удирдагчдаа дэмжин баталдаг. Бид гэрээгээр үүрэг хүлээдгээ мэднэ" хэмээн ахлагч Гэррит В.Гонг хэлсэн.

Төлөөлөгчдийн төлөө залбирах нь дэмжиж байгаагийн үнэлж баршгүй хэсэг юм гэж ахлагч Улиссэс Соарэс хэлэв. "Бид энгийн хүмүүс бөгөөд Их Эзэн биднийг чадавхаас минь давсан зүйлийг хийлгэхээр дууддаг. Гэвч хүмүүс бидний төлөө залбирч байгаа учраас бид тэр чадавхдаа хүрч чадна гэж боддог."

Итгэл нь дэмжин батлахын өмнө ч бас дараа нь ч дагалддаг гэж ахлагч Соарэс нэмж хэлэв. "Төлөөлөгчдийг дэмжин батлаcнаар та Аврагчид ажлаа хийхэд нь тусалж байгаа юм. Их Эзэний Өөрийн бошиглогч, илчлэгчдээр дамжуулан хийх зүйлсийг гүйцэлдүүлэхэд итгэл тань тусална.

Би хүмүүсийг гараа дээш өргөхөд мөн үүний цаад далд утганд дуртай" гэж ахлагч Жэффри Р.Холланд хэлсэн. Төлөөлөгчдийн хувьд Сүмийн гишүүдээр дэмжигдэн батлагдана гэдэг нь амьдралыг тэтгэх хоол хүнсийг хүлээн авч байгаатай адил гэж тэр хэлээд, "Дуу хоолой бүрийг тоocoж, тусламжийн гар

Ахлагч Расбанд Энэтхэгт; ахлагч Стивэнсэн Хонконгт; ахлагч Рэнланд Бразилд; ахлагч Гонг Хятадын Шанхайд; ахлагч Соарэс Бригам Янгийн Их Сургууль дээр байхдаа

бүрийг хүлээн авна. Бид ямар дуудлагатай байхаас үл хамааран хэн ч Сүмд ганцаараа үйлчлэх ёсгүй” хэмээн нэмж хэлэв.

Тогтсон уламжлал

Төлөөлөгчдийг дэмжих нь Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн үеэс ирсэн хожмын үеийн уламжлал юм. Эхэн үеийн гэгээнтнүүдийг анхны өдрөөс эхлэн Сүмийн удирдагчдын дуудлагыг хүлээн зөвшөөрч, дуудлагад нь дэмжин батлахад урьдаг байсан.

1830 оны 4-р сарын 6-нд Иосеф Смит болон түүний шинээр баптисм хүртсэн дагалдагчид Нью-Йоркийн Сенека гүнлэгийн Фейетте дэх Ахмад Петр Витмерийн жижигхэн дүнзэн байшинд цугларчээ.

Иосеф зогсоод, цугларсан хүмүүсээс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг зохион байгуулахад оролцохыг хүсэж байгаа эсэхийг асуусан байна.

Нийтээр зөвшөөрөх зарчмыг баримтлан шинэ гишүүд гараа өргөн, санал нэгтэй зөвшөөрчээ. Маргааш нь тэд Иосеф Смит, Оливер Каудери хоёрыг өөрсдийн багш болон сүнслэг зөвлөхөөр хүлээн зөвшөөрсөн юм.

“Сүмийн гишүүнчлэл нь нэн хувийн асуудал юм. Хүн нэг бүр чухал. Тиймээс бид нийтээр зөвшөөрөх зарчмаар ажилладаг. Хүн бүр өөрийн гэсэн бодолтой, өөрийгөө илэрхийлдэг байж, нэгдмэл байдлаар урагшлаасай хэмээн бид хүсдэг” хэмээн ахлагч Холланд хэллээ.

Биднийг өргөдөг үйлдэл

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд төлөөлөгчийн дуудлагыг хүлээн авахдаа Их Эзэний таалын дагуу “хязгаарлагддаг” хэмээн ахлагч Дэйл Г.Рэнланд хэлэв. Гишүүд Арван хоёрыг дэмжин баталснаар төлөөлөгч бүрийн Аврагчид дуулгавартай байна гэсэн амлалтад итгэж байгаагаа харуулдаг.

Төлөөлөгчийг хувь хүнийх нь хувьд дэмжин саналаа өгч байгаа хожмын үеийн гэгээнтнүүд Чуулгыг ч мөн нэгэн зэрэг дэмжин баталж байгаа хэрэг гэж ахлагч Квинтин Л.Кук хэлжээ.

Энэ ариун нандин дуудлага нь төлөөлөгчдийг өргөж, адисалдаг ч дэмжигчдийг ч мөн адил өргөн дэмждэг. “Энэ нь тэднийг хүчирхэгжүүлж, адисалж, удирдан залдаг” хэмээн тэр нэмж хэлсэн.

Энэ нь Санта Розагийн гал түймэрт нэрвэгдсэн гишүүд ахлагч Расбандыг дэмжсэнтэй адил дэлхий даяарх гишүүд Арван хоёрын гишүүн бүрийг дэмжсэнээр өргөгдөх болно гэсэн үг юм. ■

ГЭРЭЛ ЗУРГУУДЫГ ВЭНДИ ГИББС КИЙЛЭР (ЭНЭТХЭГ), КЛЭБЭР ТЭКС (БРАЗИЛ), МОНИКА ЖИОРЖИНА АЛВАРАДО ЗАРАТЭ (ШАНХАЙ), ЖАНАЯ БИНГАМ (БЯИС) НАР АВАВ

Бидний анхдагчдын үргэлжлүүлж буй өв

1847 оны 7-р сард анхдагчдын эхний баг Солт Лэйк хөндийд орж ирсэн ба тэд гэгээнтнүүд мөрдлөг хавчлагагүйгээр эрх чөлөөтэй шүтэн биширч болох мөн шинэ гэр орон нь болох газрыг хайн, Америкийн баруун нутгаар дайран ирсэн байв. Хойд Америкийн олон гишүүн өөрсдийн өвийг эдгээр анхдагч хүртэл мөшгөж болно. Гэвч Сүмийн дэлхий даяарх ихэнх гишүүний хувьд тэдний анхдагчдын өв өөр газраас, тухайлбал хамгийн эхэлж Сүмд нэгдсэн өвөг дээдсээс нь юм уу хэрэв тэд гэр бүл, орон нутаг эсвэл улс орондоо сайн мэдээг хүлээн авсан анхны хүн нь болсон бол өөрсдөөс нь эхэлдэг.

Энэ сард биднийг анхдагч өвөг дээдсийнхээ өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үед та өөрөөсөө дараах асуултуудыг асууж болох юм. Тухайлбал: Миний итгэлийн өв хаанаас эхтэй вэ? Миний өвөг дээдэс дэх анхдагчид Сүмд амьдралаа зориулахын тулд ямар золиос гаргасан бэ? Би тэдний өвийг хэрхэн хүндэлж, хуваалцаж болох вэ? Би бусдад өөрсдийн анхдагч өвөг дээдсийг ойлгож, хүндлэхэд хэрхэн тусалж болох вэ? ■



ИТГЭЛИЙН ӨВ

"Бид [анхдагчдаасаа] хүлээн авсан итгэлийн өвөө хэзээ ч алдагдуулахгүй байхад анхаарах ёстой. Тэдний баатарлаг амьдрал бидний, нэн ялангуяа бидний өсвөр үеийнхний зүрх сэтгэлд хүрэх болтугай. Ингэснээр үнэн гэрчлэлийн гал мөн Их Эзэнийг болон Түүний Сүмийг хайрлах гуйвшгүй хайр манай итгэлтэй анхдагчдынхтай адил бид бүхний дотор дүрэлзэн асах болно."

President M. Russell Ballard, Acting President of the Quorum of the Twelve Apostles, "Faith in Every Footstep," *Ensign*, Nov. 1996, 25.







ЗҮҮН ГАР ТАЛД: ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДАН БӨРР

Зүүн дээд талаас цагийн зүүний дагуу:

Мормоны Ном болон цэцэгтэй сагс барьсан эмэгтэй, Жубал Авилэс Саянз

Мөнх амьдралыг одооноос босгон байгуулах нь, Силвиа Хүегэ дэ Сэрвилл

Сэрэгтүн, сэрэгтүн, сайхан хувцсаа өмсөгтүн, Натали Анн Хансэйкэр

Айлчлал, Чү Чү

** Жозэф Виллям Билли Жонсон: Эзэнд ариун,* Эммалий Глаусэр Паувэлл

Гэр бүлийн уншлага, Хозе Мануэл Валэнсиа Арэллано

Замын хажуу дахь зогсоол, Кармэло Хуан Куютупа Каннарэс

Баяр баясгалангийн үр жимс, Нанако Хаяаши

Сүмийн түүхийн музейн олон улсын урлагийн тэмцээний гэсэн тэмдэглэгээтэйгээс өөр эдгээр болон бусад зургийг lds.org/go/71921 вэбсайтаар орж үзнэ үү.*

АНХДАГЧДЫНХАА ТАЛААР ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Улс орныхоо Сүмийн түүхийн талаар болон анхдагчдын тухай олж мэдье гэвэл **history.lds.org/GlobalHistories** вэбсайт руу орно уу.



Далын ерөнхий-
лөгчийн зөвлөл
Ахлагч Патрик Кийрон

ҮЙЛЧЛЭЛИЙН илүү ариун загвар

Бид амьд Христийнхтэй адил тохинууллаараа дамжуулан үнэнч шавь нь байхын зэрэгцээ Түүнийг өөрийн хүслээр, илүү үр дүнтэй дагах болтугай.

Би 15, 16 орчим настай байхдаа маш хувиа хичээсэн нэгэн байсан ба өсвөр насны бүх хүүхдийн адил тогтворгүй, барьцгүй, эмзэг хүүхэд байсан. Би юу хийхээ сайн мэдэхгүй, бүрэг ичимхий, эв хавгүй нэгэн байв. Намайг Английн далайн эрэг дээрх алслагдсан сургуулийн дотуур байранд байхад, эцэг эх маань Саудын Арабт амьдардаг байсан нь асуудлыг улам хүндрүүлж байлаа. Сургуульдаа би нэг л дасаж өгөхгүй байв.

Эрэг хавиар цаг агаар таагүй байх нь элбэг байсан ч нэгэн өвөл Ирландын тэнгисийн дээгүүр хүчтэй хар шуурга дэгдэж билээ. Эргэн тойронд ойролцоогоор 5000 орон байр үерт автан, хүмүүс хоол хүнсгүй болж, гэр орон нь цахилгаангүй буюу дулаацуулж, гэрэлтүүлэх зүйлгүй үлдсэн юм.

Үерийн ус татарч эхлэхэд цэвэрлэгээнд туслуулахаар сургуулиас биднийг илгээв. Байгалийн гамшгийг иймэ ойрхноос хараад би гайхан балмагдаж билээ. Хаа сайгүй ус, шавар шавхай байв. Үерт автсан хүмүүсийн царай ядарч туйлдан, цонхийсон байв. Тэд олон өдөр унтаж амраагүй байлаа. Би сургуулийнхаа хэдэн хөвгүүнтэй хамт усанд автсан эд хогшлыг дээд давхруud руу зөөж, үерт сүйдсэн хивснүүдийг татан гаргав.

Гэхдээ намайг хамгийн их гайхшируулсан зүйл бол тухайн үед хүмүүсийн хооронд үүссэн найрсаг харилцаа байсан юм. Хүнд хэцүү нөхцөл байдалд зөв үйл хэргийн төлөө нэгдсэн хүмүүсийн дунд гайхалтай, маш сайхан харьцаа тогтсон байв. Хожим эргэн санахад, өсвөр насны ердийн бодлоос гардаггүй байсан түгшүүртэй мэдрэмжүүд хөршүүддээ туслах ажилд оролцож байхад мартагдсан байсныг би мэдсэн.

ЗУРГИЙГ КЭЛЛИ МАКМОРРИС

Бусдад туслах нь миний зожиг, амин хувиа хичээсэн байдлын эсрэг ерөндөг байсан гэдгийг ухаарч ойлгосон бол өөрчлөгдөх байлаа. Уг ухаарал зүрх сэтгэлийн минь гүн рүү ороогүй байсан тул би юу болж өнгөрсөн талаар сайтар эргэцүүлэн бодож чадаагүй юм. Харин тэр ойлголт хожим нь ирж билээ.

Тохинуулах урилга

2018 оны 4-р сарын Ерөнхий чуулганаар би Аврагчийн адил ахин дахин тохинуулах дуудлагын талаар сонссон бөгөөд үүнийг хайраар, бүх хүн Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд гэдгийг хүлээн зөвшөөрснөөр хийх ёстой гэсэн захиасыг сонсохдоо энэ талаар бодож байв.

Бидний үйлчлэлийг тоолж, хэмждэг болохоор биш, харин Тэнгэр дэх Эцэгээ хайрладаг мөн илүү дээгүүр түвшний, нэр төртэй үйл хэргийн төлөө, Түүн рүү буюу гэртээ эргэн очих замаа олж, уг зам дээрээ үлдэхэд нь найз нөхдөдөө тусалж байгаа тул бид үйлчлэх болно. Бид үнэхээр хүмүүсийн амьдралыг сайжруулан, ачааг нь хөнгөлөхийг хичээж байгаа тул Есүс бидний оронд байсан бол хэрхэн үйлчлэх байсны адил хөршүүддээ үйлчлэх болно. Өөрсдийн хэмжээлшгүй үнэ цэн, бидний хүн нэг бүрийг гэх Бурханы мөнхийн хайрын талаарх мэдлэг, мэдрэмжийнхээ үр жимснээс хуваалцах үед өгөгч, хүлээн авагч хоёр хоёулаа баяр баясгалан, удаан үргэлжлэх сэтгэл ханамжийг хүлээн авдаг.

"Их Эзэний үнэн бөгөөд амьд сүмийн таних тэмдэг үргэлж Бурханы хүүхдүүд тус бүрд болон тэдний гэр бүлүүдэд тохинуулах зохион байгуулалттай, чиглүүлсэн хүчин чармайлт байх болно" хэмээн ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон хэлсэн. "Энэ нь Их Эзэний Сүм учраас бид Түүний үйлчлэгчдийн хувиар Түүний хийсний адил тэрхүү нэгэнд тохинуулах болно. Бид Түүний нэрээр, Түүний хүч, эрх мэдэл, хайр, нинжин сэтгэлээр тохинуулах болно"[1] гэж тэр хэлсэн юм.

Хэрэв бид тохинуулах энэхүү дуудлагыг сонсох юм бол бусдыг боддог болж, итгэл, үнэмшил, аз жаргал маань өсөн нэмэгдэж, хувиа хичээсэн байдал болон үүнийг дагалдан ирдэг хоосрол, уйтгар гунигийг даван гарах боломж бидэнд олдоно гэдгийг ойлгосон билээ.

Тохинуулал биднийг өөрчилдөг

Ингэж тохинуулахын сайн тал нь бусдад туслах боломж олгохоос гадна биднийг сэтгэлийн зовнил, айдас, түгшүүр, эргэлзээнээс салгаж, өөрчилдөг явдал юм. Эхэндээ бусдад үйлчлэх нь бидэнд хувийн асуудлаасаа анхаарлаа холдуулахад тусалдаг боловч энэ нь тэр даруй хавьгүй дээд түвшний, илүү сайхан зүйл болон өсөж хөгждөг. Бид өөрсдөө ч анзааралгүй гэрэл гэгээ, амар амгаланг мэдэрч эхэлдэг. Бид тайвширч, халуун дулааныг мэдэрч, тайтгарал олж авдаг. Мөн бид өөр ямар ч арга замаар баяр баясгаланг олж авахгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) "Судруудад цэдэглэгдсэн элбэг дэлбэг амьдрал нь бусдад үзүүлсэн бидний үйлчлэлийг үржүүлж, өөрсдийн авьяас бэлгийг Бурханд болон хүмүүнд үйлчлэхэд зориулснаар ирдэг сүнслэг байдлын нийлбэр үр дүн юм" гэж тайлбарласан. Мөн тэрээр "Бид бусдад үйлчилснээр илүү бие даадаг. Үнэндээ, бидэнд өөрсдийнхөө талаар олж мэдэх зүйл маш их байдаг тул энэ нь өөрийгөө "олох" ажлыг бидэнд хялбарчилж өгдөг билээ!"[2] хэмээн нэмж хэлэв.

Эзэнээс ирсэн дуудлага

Аврагч Петр, Андрей, Иаков, Иохан нарыг Өөрийг нь дагахад дуудах үед тэдний зүг чиг болон анхаарлаа хандуулж байсан зүйл шууд өөрчлөгдөж, "Тэд тэр даруй тороо орхиж Түүнийг дага[сан]" (Матай 4:20).

Харин дараа нь, Аврагчийг тэднээс харгис хэрцгийгээр авч одоход тэд мэддэг зүйлээ

ЭЭЖ, ОХИН ХОЁРЫН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЛИНДА ЖИЙН ПУРНЭЛЛ

хийсэн буюу эргэж загас барих болжээ. Нэгэн удаа амжилт муутайхан загасчилж байхад нь амилсан Аврагч тэдэн дээр ирсэн аж.

"Есүс тэдэнд—Завиныхаа баруун талд тороо хая. Тэгвэл та нар олз олно гэв. Тэд тороо тийш нь хаясанд, маш их загас торонд нь орсон тул тэд тороо ч татаж чадахааргүй болжээ" (Иохан 21:6).

Энэ нь Түүнийг хүч чадлаа алдаагүй гэдгийг харуулаад зогсохгүй, тэдний буруу газар, буруу зүйлд анхаарлаа төвлөрүүлж байсныг нь тод томруун харуулсан юм. Тэднийг эрэг дээр хамтдаа загасаа идэж суухад Аврагч Петрээс Өөрт нь хайртай эсэхийг гурван удаа асуусан. Асуух тоолонд нь Петр улам бүр сандран, тийм хэмээн хариулжээ. Петрийг хариулах бүрд Есүс түүнээс Өөрийн хоньдыг тэжээхийг хүсжээ. (Иохан 21:15–17-г үзнэ үү.)

Яагаад Аврагч Петрээс Өөрт нь хайртай эсэхийг гурван удаа асуусан бэ? Үнэндээ өмнө нь Петрийг Өөрийг нь дагахад дуудах үед тэр шууд хариу үйлдэж, загасчлахаа больж байсан. Харин Есүсийг нас барахад Петр гашуудаж, юу хийхээ мэдэхээ больж, өөрийн хийж чадна гэж бодсон цорын ганц зүйл болох загасчлах ажилдаа эргэн оржээ. Есүс энэ удаа Петрийг үнэхээр Өөрийг нь сонсож, урилгынх нь ач холбогдлыг ойлгоосой хэмээн хүссэн юм. Тэрээр Өөрийн биеэр тэдэнтэй хамт байх боломжгүй болсон тул Петрт амилсан Христийн шавь байх нь юу гэсэн утгатай болохыг ойлгуулах хэрэгтэй байв.

Их Эзэн Петрээс юу хүссэн бэ? Есүс хурганууд ыг нь тэжээхийг Петрээс хүссэн. Энэ бол түүний хийх ёстой ажил байв. Петр Эзэнийхээ энэхүү намуухан дуугаар, нүүр тулан өгсөн дуудлагыг ахмад төлөөлөгчийн хувьд хүлээн авч, хийхээр дуудагдсан тохинуулалдаа үлдсэн амьдралаа зоригтой, айж эмээлгүйгээр зориулсан билээ.

Залбирлаар эхэл

Өнөөдөр дэлхий дээр өөр нэгэн ахмад төлөөлөгч бидэнд бий. Ерөнхийлөгч Нэлсон Есүсийн хоньдыг тэжээх урилгыг та бидэнд өгч байна. Харин одоо сорилт нь бидний эргэн тойронд байх анхаарал хандуулахыг шаардаж, сарниулдаг чухал бус олон зүйлийн дунд энэхүү урилгад *хариу үйлдэх* буюу үнэндээ ямар нэгэн зүйл хийн, үнэхээр өөрчлөгдөж, өөрөөр амьдрах явдал болж байгаа юм.

Танд одоо "Би хаанаас эхлэх вэ?" гэж асуумаар санагдаж магадгүй.

Залбирлаар эхэл. Ерөнхийлөгч Нэлсон "[биднийг] хувийн илчлэлт хүлээн авах одоогийн сүнслэг ур чадвараа нэмэгдүүлэхэд"[3] урьсан. Тэнгэр дэх Эцэгээсээ юуг хэнд зориулан хийж болохыг асуу. Хүлээн авсан мэдрэмж тань ач холбогдолгүй мэт санагдсан ч хариул. Үүнийхээ дагуу үйлд. Үнэндээ, нинжин сэтгэлийн үүднээс хийсэн бага ч болов ямар ч үйлдэл өөрсдийн гэсэн адислалыг дагуулж ирдэг. Энэ нь сайхан үгтэй, санаанд оромгүй мессежийг хэн нэгэнд бичих явдал байж болно. Энэ нь цэцэг, хэдхэн жигнэмэг, эелдэг сайхан үгс байж болно. Мөн энэ нь цэцэрлэг эсвэл хашаа цэвэрлэх, угаалга үйлдэх, машин угаах, зүлэг тайрах, цас цэвэрлэх эсвэл зүгээр л сонсох байж болно.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам эгчийн хэлснээр "Заримдаа бид хөршдөө үйлчлэхийн тулд ямар нэг агуу бөгөөд баатарлаг үйлс бүтээх ёстой гэж боддог. Гэвч үйлчлэлийн энгийн үйлдлүүд нь бусдад болон өөрсдөд маань хүчирхэг нөлөө үзүүлж чадна."[4]

Та цаг зав байхгүй, өөрчлөлт хийж чадахгүй гэдэгтээ итгэсэн учраас эхний алхмыг дурамжхан хийж болох ч өчүүхэн зүйл хийх

ХРИСТ БА ЗАГАСЧИН, Ж.КЁРК РИЧАРДС

нь ямар их өөрчлөлтийг авчирдаг болохыг хараад гайхах болно. Ерөнхийлөгч Нэлсон та бидэнд илүү дээгүүр түвшний, илүү ариун үйлчлэлийн загварыг өгсөн. Энэхүү загварыг дагаснаар бид энэ нь ямар их сэтгэл ханамжийг өгч, эрх чөлөөтэй болгож, тайтгаруулдаг болохыг олж мэднэ. Мөн бид хэрхэн бусдын амьдралыг өөрчилж, тав тухыг авчирдаг хүчин зүйл нь байх боломжтой гэдгээ олж мэднэ.

Заримдаа бид номлолоо хийж дуусгасныхаа дараа “За, би хийчихлээ. Одоо өөр хүн үйлчлэх байлгүй. Би амрах хэрэгтэй байна” гэж хэлэхээр уруу татагдаж магадгүй. Гэвч жинхэнэ тохинуулалд зөвсарлага гэж байдаггүй. Энэ бол амьдралын хэв маяг. Бид ээлжит үйл ажиллагаа, баярын өдрүүдээр амарч, хүчээ сэлбэхийн тулд завсарлага авч болох ч Тэрээр биднийг хайрласан шиг бид бие биенээ хайрлахад мөн Түүний хоньдыг тэжээх гэрээний үүрэг хариуцлагад завсарлага гэж байдаггүй.

Дэлхийг хамарсан Сүмийн тохинуулал

Тохинууллыг амьдрал дээр хэрэгжүүлдэг Сүмд харьяалагддагтаа би бахархдаг. Зөвхөн 2017 онд гэхэд л, манай гишүүд ядуust болон тусламж хэрэгтэй хүмүүст зориулан хүнсний ногоо тарьж ургуулах, хураан авах, тараахад сайн дурын үйлчлэлийн 7 сая гаруй цагийг зориулсан. Сүм ундны цэвэр усгүй байсан хагас сая хүнийг усаар мөн 41 улс орны 49000 хүнийг тэргэнцрээр хангасан. Сайн дурынхан нүдний шил өгч, нүдний эмчилгээний үйлчилгээ үзүүлж, 40 орны хараааны бэрхшээлтэй хүмүүсийн 97000 асран халамжлагчид сургалт явуулсан. 38 орны 33000 асран халамжлагчийг эх, нярайн асаргааны сургалтад хамруулсан байна. Сүүлийн жилүүдэд Тусламжийн гар хөтөлбөрөөр дамжин манай олон зуун мянган хүн олон сая цагаа хандивласан гэдгийг дурдах нь зүйтэй болов уу. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд их, бага хэмжээний гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслахын зэрэгцээ орчин тойрноо болон орон нутгаа сайжруулах ажилд оролцоход бэлэн байдаг.

Үйлчлэл хийх боломжуудын жагсаалтыг гаргадаг JustServe хэмээх нэртэй Сүмийн цэцэглэн хөгжиж буй санаачилгад аль хэдийн 350000 гаруй сайн дурынхан бүртгүүлсэн байгаа бөгөөд тэд орон нутагтаа тусламжийн олон сая цагийн хандивыг өргөсөн байна.[5]

Энэ бол үйлдэл хийдэг Сүм. Энэ бол бидний хийдэг зүйл. Та нар үүнийг л хийдэг. Энэ нь та нарын хэн болохыг тодорхойлдог шинж чанар байх болтугай.

ЭМЧИЙН ӨВЧНӨӨ ТЭВЭРЧ БАЙГАА ЗУРГИЙГ ВЭНДИ ГИББС КИЙЛЭР АВАВ
ТУСЛАМЖИЙН ГАР ХӨТӨЛБӨРИЙН САЙН ДУРЫН АЖИЛТНЫ ГЭРЭЛ ЗУРГИЙГ ХИТАЛО РАНИЭЛ АЗЭВЭДО АВАВ

Гурван төрлийн үйлчлэл

Бидний хүн нэг бүр өргөн хүрээнд оролцож болох гурван төрлийн үйлчлэлийн талаар би онцлон ярих гэсэн юм.

1. Бидний сүм дээр үүрэг хариуцлагаа биелүүлэхээр томилогддог буюу уригдан хийдэг үйлчлэл. Бид харж халамжлах үүрэг хүлээн авсан хүмүүсийнхээ талаар бодож, залбирч мөн хэмжигддэг биш, харин үнэлэгддэг тохинууллыг хийхийн төлөө хичээнгүйлэн зүтгэх болно.

2. Өөрсдийн хүслээр хийдэг үйлчлэл. Энэ нь нэг дэх үйлчлэлийн үргэлжлэл бөгөөд бид өөрсдийгөө умартан, бусдад өөрсдийн санаачилгаар тусламж үзүүлэх тусам энэ нь бидний өдөр тутмын үйлдэл, харилцааны нэгэн хэсэг болж хувирдаг. Албан үүрэг даалгавар хүлээлгэн өгөөгүй ч бид Христийг дагах хүслээр өдөөгдөн, эргэн тойронд байх хүмүүстээ илүү эелдэг хандаж, анхаарал халамж тавьж эхэлдэг.

3. Олон нийтэд үзүүлэх үйлчлэл. Шаардлагатай үед та хувь хүмүүсийг болоод нийгмийг хөгжүүлэх мөн тэдэнд үйлчлэх зорилгоор улс төрд оролц. Тив даяар тархсан хэт нэг талыг баримталсан, хүчирхэг, хор хөнөөлтэй улс төрийн намчирхах зөрчилдөөнөөс зайлсхий. Тус тусын харьяа нутгийнхаа хүрээнд мөн уг хүрээнээсээ гадуурх

зовлон бэрхшээлтэй учирсан хүмүүст туслах зорилготой ажиллаж буй улс төрчидтэй нэгд. Та нийгмийн бүхий л хүрээнд шударга ёсыг сурталчлан, тэнцвэртэй байдал, эрүүл саруул ухааны дуу хоолой байх боломжтой. Ийм зүй зохистой нийгэм рүү чиглэсэн үйл ажиллагаанд өөрсдийн эрч хүчийг зарцуулах эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдсээр байна.

Бид өөрсдийн ертөнцийг өөрчилж чадна

Мэдээ сонсоод, дэлхий сүйрч байна даа гэж бидэнд бодогдож магад. Бидний хүн нэг бүр өдөр бүр их, бага ямар нэг хэмжээгээр үйлдэл хийж л байвал бид өөрсдийн болон эргэн тойрныхныхоо ертөнцийг өөрчилж чадна. Та хөршдөө үйлчлэх үедээ мөн тэдэнтэй хамт орон нутагтаа үйлчилж байх явцдаа бусдад туслах хүслийг тань хуваалцдаг найз нөхөдтэй болно. Эдгээр нь бат бөх нөхөрлөл болж хувиран, соёл, итгэл үнэмшлийг холбох гүүрийг тавина.

Хэрэв та Есүсийн адил тохинуулах урилгыг хүлээн авах юм бол та өөрчлөгдөж, амин хувиа хичээсэн биш, харин амь биеэ үл хайрлахгүй үйлчилдэг нэгэн болно. Та Аврагчийн арга замаар тохинуулснаар ирэх баяр баясгаланг олж нээн, дутагдал гэж үздэг зүйлээс ирэх сэтгэлийн түгшүүр, эргэлзээ, гуниг зовлонгоосоо салах болно.

Хэн нэгний нэр эсвэл ямар нэг ажил үйлс бодолд тань орж ирж магадгүй. Энэ нь Сүнсний урилга байж болох бөгөөд та үүнийг урьд нь хүлээн авч байсан байж болох юм. Тусламжийн гараа сунган, эргэн тойрноо ажиглан харж, өргөн дэмж. Энэ урилгад хариулж, өнөөдөр юу хийж болохоо мэдэхийн тулд залбир. Ингэснээр та нарт болон та нарын тохинуулж буй хүмүүст ямар адислалыг авчирч байгааг харж, мэдрэх юм бол та нар үүнийг өдөр бүр хийж хэвшихийг хүсэх болно.

Есүс Христийн сайн мэдээний гэрэл, найдвар, баяр баясгалан, зорилгыг Бурханы бүх хүүхэдтэй хуваалцаж, гэртээ харих замаа олоход нь тэдэнд туслах нь бидний хийж чадах хамгийн эрхэм дээд, хамгийн сайхан үйл хэрэг. Тэдэнд тусалж, үйлчилж, тохинуулж байгаа нь сайн мэдээ бодит байдал дээр хэрэгжиж байгаагийн бодит илрэл юм. Бид үүнийг өөрсдийн амьдралын хэв маяг болговол өөр хаанаас ч авах боломжгүй сэтгэлийн таашаалыг авч мөн мэдрэхгүй байсан амар амгалан, баяр баясгалангаа олох арга зам гэдгийг олж мэдэх болно.

Аврагч Өөрийн агуу, эцэс төгсгөлгүй гэтэлгэлийн бэлгээрээ дамжуулан төгс гавар, илааршлыг бидэнд өгөхийн тулд ийнхүү амьдарч байсан юм. Бид амьд Христийнхтэй адил тохинууллаараа дамжуулан үнэнч шавь нь байхын зэрэгцээ Түүнийг өөрийн хүслээр, илүү үр дүнтэй дагах болтугай. ■

2018 оны 5-р сарын 6-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль дээр болсон залуучуудад зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт дээрх "A Hallmark of the Lord's True and Living Church" хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, "Бурханы хүч, эрх мэдлээр тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 88.
2. Spencer W. Kimball,"The Abundant Life," *Ensign,* July 1978, 3.
3. Рассэлл М.Нэлсон, "Сүмд зориулсан мөн бидний амьдралд зориулсан илчлэлт," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 119.
4. Жийн Б.Бингам, "Аврагчийн адил тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 130.
5. JustServe.org-ийг үзнэ үү. Энэ вэбсайтыг Хойд Америкт хэрэглэж болох бөгөөд Мексик, Нэгдсэн Вант Улс, Пуэрто Рико болон Австралид туршиж байгаа.

1-р бүлэг

Бүлэг гэгээнтнийг цуглуул

Редакторын тэмдэглэл: Энэ нь Гэгээнтнүүд “Ариун бус гар” *гэх 2-р ботийн 1-р бүлгээс эш татан авсан хэсэг юм. Өнгөрсөн жил хэвлэгдсэн* Үнэний жишиг *хэмээх нэгдүгээр боть нь хожмын үеийн гэгээнтнүүд Науву ариун сүмд хувийн хишгээ хүртээд, өрнөд рүү аялахаар Наувуг орхин явахад бэлэн болж байгаагаар дуусдаг.*

Баригдаад бараг дуусаж байсан Науву ариун сүмийн нэгдүгээр давхрын цуглааны том танхимд Люси Мак Смитийн дуу цуурайтахад мянга мянган гэгээнтэн чимээгүй болов.

Энэ нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн намрын чуулганы 3 дахь буюу сүүлийн өдөр болох 1845 оны 10-р сарын 8-ны өглөө байлаа. Алс холын өрнөд рүү шинэ гэр оронтой болохоор Наувуг орхин явахаар төлөвлөсөн гэгээнтнүүдэд хандан ярих боломж түүнд дахин олдохгүй болж байгааг мэдсэн Люси тамир тэнхээгүй, 70 гарсан хөгшин хүнд баймгүй хүчтэй хоолойгоор ярив.

“Өнгөрсөн 9-р сарын 22-нд, Иосефыг газраас ялтаснуудыг гаргаж авснаас хойш 18 жил өнгөрчээ” хэмээн тэрээр гэрчлэн, “Өнгөрсөн даваа гараг гэхэд, Иосеф Смит Их Эзэний бошиглогч болоод 18 жил болсон байна”[1] гэлээ.

Тэрээр хэсэг чимээгүй болж, алагдсан хүү Иосефоо дурсан санав. Өрөөнд байсан гэгээнтнүүд Их Эзэний тэнгэр элч Иосефыг Кумора толгодод булагдсан алтан ялтаснууд руу хөтлөн удирдсаныг аль хэдийн мэдэж байв. Иосеф алтан ялтаснуудыг Бурханы бэлгээр болон хүчээр орчуулан, уг цэдгийг Мормоны Ном хэмээн хэвлэж гаргасныг тэд мэддэг байсан. Гэвч уг цуглааны танхимд байсан гэгээнтнүүдээс хэд нь түүнийг яг үнэндээ мэддэг байсан бол?

Иосеф хорин нэгхэн насандаа Бурхан түүнд ялтаснуудыг даатгасан тухай анх хэлж байсныг Люси яг л тэр хэвээр нь санаж байсан. Иосефыг өмнөх 4 жилийнхтэй адил толгодоос хоосон буцаад ирэх вий хэмээн бүхий л өглөөний туршид тэрээр сэтгэл түгшин айж байсансан. Гэвч тэрээр буцаж ирээд, түүний санааг түргэхэн тайвшруулжээ. “Битгий зовни. Бүх зүйл зүгээр” гэж тэрээр хэлэв. Тэгээд тэрээр гарын алчууранд ороосон хөрвүүлэгчийг Бурхан ялтаснуудыг орчуулахад зориулж өгсөн хэмээн Люсид гардуулсан нь бичээсийг олж авахад амжилт олсны баталгаа байлаа.

ГРЕГ НЬЮБООЛДЫН *ГЭГЭЭНТНҮҮД: ҮНЭНИЙ ЖИШИГ*

Тэр үед зөвхөн гарын арван хуруунд багтах итгэгчид байсан бөгөөд ихэнх нь Смитийн гэр бүлийнхэн байсан. Харин одоо арван нэгэн мянгаас илүү гэгээнтэн Хойд Америк, Европоос ирж, Иллинойн Наувуд амьдарч байгаа бөгөөд энд Сүм өнгөрсөн зургаан жилийн турш цугласан билээ. Тэдний зарим нь Сүмийн шинэ гишүүд учраас 1844 оны 6-р сард дээрэмчид Иосеф, түүний ах Хайрум нарыг буудан хөнөөхөөс өмнө тэдэнтэй уулзах боломж уг гишүүдэд олдоогүй байсан юм.[2] Тийм учраас Люси нас барсан тэдний талаар ярихыг хүсжээ. Тэрээр Иосефын бошиглогч хэмээх дуудлага болон сайн мэдээний Сэргээлтэд түүний гэр бүлийнхний гүйцэтгэсэн үүргийн талаар гэгээнтнүүдийг нүүж явахаас өмнө гэрчлэхийг хүссэн.

Зохион байгуулалттай бүлэг дээрэмчин ойролцоох суурингууд дахь гэгээнтнүүдийн гэр орон, бизнесийг сар гаруй хугацаанд шатаасан аж. Олон гэр бүл амиа алдахаас айн, Наувугийн хамгаалалт руу зугтсан байна. Гэвч хоног хугацаа өнгөрөх тусам дээрэмчид хүчирхэгжиж мөн илүү зохион байгуулалттай болсноор удалгүй гэгээнтнүүд болон тэдний хооронд зэвсэгт мөргөлдөөн гарав. Энэ үеэр улсын болон мужийн засгийн газар гэгээнтнүүдийн эрхийг хамгаалахаар юу ч хийгээгүй.[3]

Дээрэмчдийн Науву руу довтлохыг цаг хугацааны асуудал гэж итгэсэн Сүмийн удирдагчид хавар гэхэд гэгээнтнүүдийг уг гүнлэгээс нүүлгэн шилжүүлнэ хэмээн зөвшөөрч, тогтворгүй энх тайвны гэрээг байгуулжээ.[4]

Тэнгэрлэг илчлэлтээр удирдуулсан Бригам Янг болон Арван хоёр төлөөлөгчийн Чуулгын бусад гишүүн гэгээнтнүүдийг 1600 гаруй км-т орших өрнөд рүү Хадат уулсыг өнгөрөн, Нэгдсэн улсын хилийн гаднахан нүүлгэхээр төлөвлөсөн байв. Сүмийн тэргүүлэх чуулгын хувьд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга энэ шийдвэрийг намрын чуулганы эхний өдөр гэгээнтнүүдэд зарласан байна.

"Их Эзэн илүү эрх чөлөөтэй үйлдэж болох газар луу биднийг удирдахыг хүсэж байна. Тэнд эрх чөлөө, эрх тэгш байдлын цэвэр зарчмуудад бид баясах болно" хэмээн төлөөлөгч Парлей Пратт тунхаглажээ.[5]

Хэрвээ Люсиг явахаар сонговол гэгээнтнүүд түүнд энэ аялалд нь туслах болно гэдгийг тэр мэдэж байсан. Илчлэлтүүдэд гэгээнтнүүдийг нэг газар хамтдаа цугларахыг зарлигласан бөгөөд Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга Их Эзэний хүслийг биелүүлэхээр шийджээ. Гэвч Люси хөгширсөн байсан ба өөрийгөө удаан амьдрахгүй гэдэгт итгэж байв. Тэрээр нас барах үедээ, өөрийгөө Иосеф, Хайрум, өөрийнх нь нөхөр болох Ахмад Иосеф Смит болон бусад нас барсан гэр бүлийнхэнтэй нь ойролцоо Наувуд нутаглуулахыг хүсжээ.

Үүнээс гадна амьд байгаа ихэнх гэр бүлийнхэн нь Наувуд үлдэхээр болсон байна. Түүний амьд буй ганц хүү болох Виллиам нь Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан ч тэдний удирдлагыг эсэргүүцэн, өрнөд рүү явахаас татгалзав. Түүний 3 охин болох Софрония, Катрин, Люси нар ч бас үлдэхээр болжээ. Бошиглогчийн бэлэвсэн эхнэр, түүний бэр Эмма ч бас үлджээ.

Люси цугласан олонд хандан ярихдаа хийх гэж байгаа аяллынхаа талаар санаа зовох хэрэггүй гэдгийг тэдэнд сануулав. "Гар тэрэг, бусад зүйлийг авч явж чадахгүй гэж хэлэн сэтгэлээр бүү уна" хэмээн тэрээр хэлжээ. Ядуурал, хавчлагаас үл хамааран түүний гэр бүл Мормоны Номыг хэвлэх Их Эзэний зарлигийг гүйцэлдүүлсэн билээ. Тэрээр тэдэнд удирдагчдаа сонсон, бие биенээ халамжлахыг уриалсан.

"Бригамын хэлсэнчлэн та нар бүгдээрээ шударга байх ёстой, эс бөгөөс тэнд хүрч чадахгүй" гэж Люси хэлжээ. "Хэрвээ та нар гомдож уурлавал асуудалтай тулгарах болно."

Люси өөрийнхөө гэр бүлийн тухай мөн Миссурид болон Иллинойд тэдний амссан аймшигтай хавчлагын тухай, түүнчлэн гэгээнтнүүдийн өмнө тулгарах сорилтуудын талаар илүү ихийг ярьжээ. "Сүмийн удирдлагууд болох Бригамыг болон бусад ахыг Их Эзэн адислаасай хэмээн би залбирч байна." "Би нөгөө дэлхийд очих үедээ та нартай бүгдтэй нь уулзмаар байна"[6] гэж тэрээр хэлжээ.

1846 оны 1-р сард Бригам Наувугаас нүүлгэн шилжүүлэх, гэгээнтнүүдийн шинэ цуглах газрыг байгуулах хамгийн хурдан бөгөөд шилдэг арга замыг төлөвлөхөөр Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгатай болон дэлхий дээрх Бурханы хаант улсын материаллаг хэрэгцээг анхаардаг Тавьтын зөвлөлтэй ойр ойрхон уулзав. Түүний анд төлөөлөгч Хибер Кимбалл өрнөд рүү гэгээнтнүүдийн цомхон бүлгийг маш хурдан удирдан гарахыг санал болгожээ.

“Өөрсдийгөө бэлдэж чадах бүлэг гэгээнтнийг цуглуул” гэж тэрээр зөвлөөд, “өөрсдийнхөө гэр бүл, ядуусын төлөөх газрыг бэлдэхийн тулд ямар ч цаг үед дуудахад урагш явахад бэлэн бай” хэмээн хэлсэн юм.

“Хэрвээ урьдчилж явсан бүлэг гэгээнтэн энэ хавар тариа тарихаар бол 2-р сарын 1-нээс эхлэх хэрэгтэй нь зайлшгүй” хэмээн Оорсон Пратт сануулжээ. Тэрээр тариалалтаа урагшлуулахын тулд арай ойрхон газар суурьшуулах нь илүү дээр гэж үзэв.

Уг санаа Бригамд таалагдаагүй. Их Эзэн гэгээнтнүүдийг Агуу Солт Лэйкийн ойр орчим суурьшуулахаар аль хэдийн удирдсан байлаа. Уг нуур нь Агуу их сав газрын хэсэг байсан бөгөөд уулсаар хүрээлэгдсэн асар том аяга хэлбэртэй бүс нутаг юм. Сав газрын ихэнх нь хуурай цөл газар бөгөөд үр тариа боловсруулахад бэрхшээлтэй учраас олон америк хүн өрнөд рүү нүүхийг хүсдэггүй байсан.

“Хэрвээ бид уг газар луу уулс дундуур анхааралтай явбал ямар ч үндэстний атаа жөтөө байхгүй байх болно” хэмээн Бригам тайлбарлажээ. Бригам уг бүс нутагт аль хэдийн уугуул хүмүүс оршин суудаг гэдгийг ойлгож байсан. Гэвч тэр гэгээнтнүүд тэдний дунд эв найрамдалтай суурьших боломж байгаа хэмээн найдаж байсан юм.[7] ■

Бүлгийн үргэлжлэлийг уншихын тулд saints.lds.org хаягаар орж үзнэ үү эсвэл 7-р сарын Лиахона *гаас уг нийтлэлийг Gospel Library болон liahona.lds.org руу орж цахим хувилбарыг харна уу.*

Тэмдэглэл дэх Сэдэв *гэсэн үг нь saints.lds.org вэбсайт дээр дэлгэрэнгүй мэдээлэл байгааг илэрхийлнэ.*

Хавчлагаас болж тусламж эрэлхийлснээр, Бригам Янг (зурган дээрх) болон Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга гэгээнтнүүдийг өрнөд рүү 1600 гаруй км-т Хадат уулаас цааш нүүлгэх Их Эзэний зааварчилгааг дагасан.

BRIGHAM YOUNG, СҮМИЙН ТҮҮХИЙН НОМЫН САНГИЙН ЗӨВШӨӨРЛӨӨР ЧАРЛЭС ДИФОРЭСТ ФРЭДРИК НИЙТЛЭВ.

ЭШЛЭЛҮҮД

1. Түүхчийн хэлтэс, Сүмийн ерөнхий тэмдэглэл, 1845 оны 10-р сарын 8; “Conference Minutes,”*Times and Seasons,* 1845 оны 11-р сарын 1, 6:1013–1014. 1845 оны 10-р сарын чуулганы Люсигийн номлолын бүтэн тайланг тэмдэглэгээтэй нь хамт Реедер болон Холбрүүк, *At the pulpit,* х. 21–26-аас харна уу. **Сэдэв:** Люси Мак Смит
2. Люси Мак Смит, History, 1844–45, book 5, [7]; *Гэгээнтнүүд,* 1-р боть8 4-р бүлэг болон 44; “How Large Was the Population of Nauvoo?” 92–93. **Сэдэв:** Иосеф Смит, Хайрум Смит хоёрын үхэл
3. Соломон Ханкүүк болон Ааланcон нар Бригам Янг дээр, 1845 оны 9-р сарын 11, Бригам Янгийн ажлын өрөөний хавтаснууд, CHL; “Mobbing Again in Hancock!” and “Proclamation,” *Nauvoo Neighbor,* 1845 оны 9-р сарын 11, [2]; Гарцууд, Сэтгүүл 2-р боть, 1845 оны 9-р сарын 13; Glines, Reminiscences and Diary, Sept. 1845 оны 9-р сарын 12; “The Crisis,” and “The War,” *Warsaw Signal,* 1845 оны 9-р сарын 17, [2]; “The Mormon War,” *American Penny Magazine,* 1845 оны 10-р сарын 11, 570–71; Жекоб Б.Бэкенстос Бригам Янг дээр, 1845 оны 9-р сарын 18, Бригам Янгийн ажлын өрөөний хавтаснууд, CHL; Оорсон Спенсер Томас Форд дээр, 1845 оны 10-р сарын 23; Томас Форд Жорж Миллер дээр, 1845 оны 10-р сарын 30, Бригам Янгийн түүхийн баримтууд, CHL; мөн Леонардын *Nauvoo,* 525–542-ыг харна уу.
4. *To the Anti-Mormon Citizens of Hancock and Surrounding Counties* (Варшав, ИЛ: 1845 оны 10-р сарын 4), Chicago Historical Society, Collection of Manuscripts about Mormons, CHL; мөн Леонард, *Nauvoo,* 536–542-ыг харна уу.
5. Тавьтын зөвлөл, “Record,” 1845 оны 9-р сарын 9, *JSP,*-д CFM:471–472; “Conference Minutes,” *Times and Seasons,* 1845 оны 11-р сарын 1, 6:1008–11.
6. Сургаал ба Гэрээ 29:8 (Revelation, Sept. 1830–A, at josephsmithpapers.org); Сургаал ба Гэрээ 125:2 (Revelation, circa Early Mar. 1841, at josephsmithpapers.org); Түүхчийн хэлтэс, Сүмийн ерөнхий тэмдэглэл, 1845 оны 10-р сарын 8; “Conference Minutes,” *Times and Seasons,* 1845 оны 11-р сарын 1, 6:1013–14.
7. Тавьтын зөвлөл, “Record,” 1846 оны 1-р сарын 11, *JSP*-д, CFM:514, 515, 518. **Сэдэв:** Тавьтын зөвлөл

Хүүхдэд өгсөн амлалт

Хэдэн жилийн өмнө би хүнд хэлбэрийн сэтгэл гутралд орсон юм. Надад урам зориг өгдөг ганц зүйл бол миний найз болон түүний хүүхдүүд байв. Бид амралтын өдрүүдээр алхдаг байсан ба надад энэ нь таалагддаг байлаа. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам бидний алхах тоо улам бүр багасаж эхэлсэн юм. Би найзаа мөн найзынхаа гэр бүлийг санах болов. Дараа нь би найзыгаа гэр бүлтэйгээ хамт олон жилийн өмнөөс хийхээ больсон нэг зүйлээ буюу Сүмд явдаг байсан дадал хэвшлээ сэргээсэн тул хамт алхах нь цөөрснийг мэдсэн юм.

Нэг өдөр тэд намайг өдрийн хоолонд урив. Тэднийг дахин харах надад маш сайхан байлаа. Би тэднийг хэчнээн их санаснаа хэлэв. Найзын маань зургаан настай охин надад бидэнтэй хамт сүмд явж энэ асуудлыг шийдэж болно гэж хэллээ. Тэр юу ч бодолгүй намайг шууд л сүмд явахад урив.

Өө, үгүй, үгүй! Сүмд явах нь тэдний хувьд зөв зүйл байж болох ч надад бол дэндүү уйтгартай гэдгийг би энэ гэр бүлд хэрхэн ойлгуулах билээ? Би олон жил сүмд яваагүй ч хүүхдэд хэрхэн татгалзаж чадах билээ дээ? Би сүмд явна гэж хэлсэн боловч үнэндээ амлалтдаа хүрэх хүсэл надад огтхон ч байсангүй.

Тэр ням гарагт би аавындаа өглөөний унд уухаар очив. Гар утас тасралтгүй дуугарч, бяцхан охинд сүмд хамт очно гэж өгсөн амлалтыг маань сануулж байлаа. Аавыг надаас яагаад утсандаа хариулахгүй байгааг асуух хүртэл би утсаа авсангүй. Намайг сүмийн цуглаанд ирэхийг урьсан ч очмооргүй байгаагаа би хэллээ. Аав инээмсэглэн, “Ллувиа, хэлсэн үгэндээ хүрэхгүй л юм бол хүүхдэд биелүүлэхгүй амлалт бүү өгч бай” гэв. Би ч амлалтаа биелүүлэхээр шийдлээ.

Би сүм дээр ирээд, огт өөр мэдрэмжийг буюу дүрслэхийн аргагүй нэг зүйлийг мэдэрсэн юм. Яагаад ийм зүйл болсныг тайлбарлаж чадахгүй байсан ч би дараа дараагийн цуглаануудад очсон бөгөөд миний мэдэрч байгаа зүйл Ариун Сүнс байсныг мэдсэн.

Сүмийн гишүүд надад гэртээ байгаа мэт мэдрэмж төрүүлдэг байлаа. Би ямар ч эргэлзээгүй Сүмийг сонирхож эхлэв. Би номлогчидтой уулзаж, гэрчлэлтэй болж эхэлсэн. Номлогчид тогтмол айлчлан ирэх болж мөн сайн мэдээний талаарх ойлголт маань өсөн нэмэгдсээр, би баптисм хүртэхийг маш их хүсэх болсон юм. Би тун удалгүй баптисм хүртсэн бөгөөд одоо сайн мэдээний адислалуудаас хүртэж байна. Иймээс би зургаан настай охинд өгсөн амлалтдаа хүрсэндээ талархдаг. ■

Ллувиа Парадэс Кабрэра, Мексикийн Юкатан

Миний гар утас тасралтгүй дуугарч, бяцхан охинд сүмд хамт очно гэж өгсөн амлалтыг маань сануулж байлаа.

ЗУРГИЙГ ПАСКАЛ КАМПИОН

Намайг эмнэлэг рүү явахаас өмнө хамт ажилладаг найз маань "Их Эзэний өргөөнд ийм ойрхон байгаа юм чинь эхлээд яагаад хамт залбирч болохгүй гэж?" гэв.

Ариун сүмийн дэргэд залбирцгаая

Манай хүү Марког гурван настай байхад хүү бид хоёр хоолны хүнд хордлогод орсон юм. Маркогийн өвчин хүндэрч, улмаар ухаан алдав. Миний эхнэр Марианэла бид хоёр хүүгээ эмнэлэг рүү яаралтай хүргэсэн юм. Биднийг эмнэлэгт ирэхэд тэр амьсгал хураасан юм шиг л харагдаж байлаа. Эцэст нь бүтэн дөрвөн цагийн дараа тэр ухаан оров.

Үүнээс хойш Марко дараагийн таван жилийн туршид үе үе татдаг болсон юм. Бид орой бүр түүнийг оронд нь оруулахдаа, дахиад шөнө дунд түүнийг эмнэлэг рүү яаралтай хүргэх хэрэг гарах болов уу гэж боддог байв. Ийм их түгшүүртэйгээр бид хэдэн жилийн турш амар тайван унтаж чадаагүй бөгөөд залбирал, итгэл, мацаг, санваарын адислалд найддаг байлаа.

Маркогийг зургаа хүрэх гэж байхад Марианэла ажил дээр байхад маань над руу залгаад, эмнэлэгт яаралтай ир гэв. Марко маш хүнд таталт өгч, комд орсон байлаа. Түүнийг утасдахад би Аргентины Буэнос Айрес ариун сүмтэй залгаа байрладаг Аргентины номлогчийг бэлтгэх төвийн барилгын засвар дээр ажиллаж байв.

Намайг эмнэлэг рүү явахаас өмнө хамт ажилладаг найз маань "Их Эзэний өргөөнд ийм ойрхон байгаа юм чинь эхлээд яагаад залбирч болохгүй гэж?" гэв. Ариун сүм засвар, өргөтгөлийн ажлаар хаагдсан байсан ч бид Их Эзэний өргөөний дэргэд очин, Маркогийн төлөө залбирлаа.

Маркотай хамт туулж өнгөрүүлсэн хүнд хэцүү бүхнээс үл хамааран би Марианэла бид хоёрт хүүтэй минь хамт өнгөрүүлэх цаг хугацаа олгосных нь төлөө Бурханд талархсан юм. Би залбирч байхдаа, бид сайн эцэг эх байхыг хичээж, Маркоги чадлынхаа хэрээр харж хандсан гэдгээ Тэнгэрлэг Эцэгтээ хэлэв. Хэрэв Тэр Маркоги гэртээ иргэж ир хэмээн дуудвал бид Түүний хүслийг хүлээн авах болно гэдгээ би бас хэллээ.

Би эмнэлэг дээр ирээд, Марког комоосоо гарсан эсэхийг мөн тэр дахин алхаж, ярьж чадах эсэхийг ч мэдэхгүй байв. Тэр хоёр цагийн туршид маш хүнд нөхцөлд байсны дараа сая л нэг ухаан оров. Тэр ядарч туйлдсан байсан ч зүгээр байлаа. Түүнээс хойш тэр гайхалтай нь аргагүй сайжирсан юм. Яваандаа Марко эм уухаа ч больж, эмнэлгээс нэгмөсөн гарсан.

Марианэла бид хоёр тэр хүнд хэцүү үеийг эргэн санахдаа, Марко минь бидэнд байгаад мөн энэ бүхнээс ухаарсан зүйлсдээ талархдаг. Тулгарсан сорилт бэрхшээл маань биднийг нэгдмэл, бас сүнслэг байдлын хувьд хүчирхэг болгосон. Энэ явдал болоогүйсэн бол Их Эзэн бидний амьдралд Өөрийн мутрыг ямар олон арга замаар харуулдгийг олж харахгүй байх байсан биз.

Марианэлагийн хэлснээр "Бидэнд Бурханы оршихуйг гэрчилсэн, Түүнийг бидэнтэй хамт байж, биднийг сонсдог гэдгийг баталсан олон нотолгоо, туршлагыг бид олж авсан. Хэрэв бид эцсээ хүртэл тэсэж, тэвчээртэй байвал адислалууд бидний бодож байгаагүй үед ирэх болно. ■

Хуан Бэлтрам, Аргентин, Буэнос-Айрес

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЛЭН ГАРНС

Яагаад Их Эзэн намайг сэрэмжлүүлээгүй вэ?

Нөхөр бид хоёр том хүүхдүүдээ дөрөвтэй, хоёртой байх үед Техас мужийн техникийн институтийн оюутны байранд амьдардаг байлаа. Бид Техас гэх өндөрлөг газарт анх удаа ирсэн байв. Надад ямар их таалагдсан гээч! Хавар болмогц төв Техас цэцгээр дүүрдэг. Цэцэрлэгт хүрээлэн, ой мод, эзгүй тал, замын хажуу гээд хаашаа ч харсан цэцэгс дэлбээлдэг байлаа.

Би хүүхдүүдээ тэргэн дээр нь суулгаад, бараг өдөр бүр гадуур зугаалдаг байв. Бид үзэж харах шинэ газрууд олж, хүүхдүүддээ зэрлэг цэцэгсийг хүссэнээрээ зулгааж авахыг зөвшөөрдөг байсан. Бид сайхан арчилж ургуулсан цэцэгсийн цэцэрлэгтэй айлууд бүхий гудамжаар зугаалж, аяллаа дуусгадаг байлаа.

Нэгэн өдөр бид булан тойроод, цэцэрлэгүүдийн нэгэнд маш олон цаас тараан хаясан байхыг харав. Салхи цааснуудыг нүд ирмэхийн зуур хашаагаар нэг тараасан байлаа. Хогийг цааш тарахаас нь өмнө цэвэрлэе гэж би бодоод, гараараа дүүрэн хуудаснууд атган авч, живхнийхээ цүнх рүү чихэв.

Доош харангуут порнографтай хуудаснууд барьж байгаагаа би мэдлээ. Би хирдхийн цочиж, үлдсэн хуудаснуудыг хамж байхдаа хүүхдүүдээ тэрэгнээсээ буухгүй байхыг хүсэв. Хэзээ ч харахыг хүсэхгүй байсан зүйлээ хальт харсандаа би сэтгэлээр унав. “Яагаад Бурхан намайг өөр замаар гэртээ харь гэж сэрэмжлүүлээгүй юм бол?” гэж би дотроо гоморхов.

Дараа нь би сургуулийн автобус тоормослох танил чимээг сонслоо. Арав гаруй хүүхэд автобуснаас бууж, хэдхэн минутын өмнө порнографтай хуудсаар дүүрсэн байсан хашааны дэргэдүүр өнгөрөв.

Тэр мөчид миний харах өнцөг орвонгоороо өөрчлөгдсөн юм. Яагаад надад өөр замаар яв гэж сэрэмжлүүлээгүйг би одоо ойлгож мэдсэн байлаа. Би хүүхдүүдэд хор хөнөөлтэй зургуудыг харуулахгүйн тулд тэнд байсандаа талархаж байв. Би харих замдаа “Сургуулийн автобус оройтож ирсэн бол яах байсан бол” гэж бодсон. Яагаад ийм зүйл тохиолдсоныг мэдэлгүй өнгөрсөн бол би яах байсан бол? Би Бурханд хэр удаан сэтгэл дундуур үлдэх байсан бол?

Их Эзэн “яагаад” тэр туршлагыг надад өгөх болсноо ойлгуулах боломжийг олгосон тэр өдөр Түүний мэргэн ухаан болон зорилгууд минийхээс хавьгүй илүү агуу гэдэгт итгэхэд тусалсан юм.

Заримдаа яагаад ийм зүйл тохиолдсоныг би мэдэх болно, харин заримдаа мэдэхгүй өнгөрнө. Юу ч болсон бай, Их Эзэнд миний харж чадахаас илүү агуу зорилго байдаг гэдэгт би итгэх ёстой гэдгээ мэддэг болсон. ■

Ларк Монтгомэри, АНУ-ын Техас муж

Салхи цааснуудыг нүд ирмэхийн зуур хашаагаар нэг тараав. Би хогийг цааш тарахаас өмнө цэвэрлэе гэж бодлоо.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ТИМ ЗЭЛТНЭР

Зууран барихад өвдөх үе тохиодог

Долоодугаар сарын нэгэн аагим халуун өдөр би хадам ахдаа далан барихад нь тусалсан юм. Ийн ажиллах болсноор эцэст нь надад зам дээр цэцэглэж байсан интоорын модны үндэстэй хүчээ үзэх хэрэг гарав.

"Асуудалгүй" гэж би бодлоо.

Би тохирох багажуудаа цуглуулан, ажиллах зай гаргахаар үндэсний эргэн тойрныг ухав. Дараа нь хөрөөгөө шүүрэн авч, бодож санах ч юмгүй шууд л үндсийг тайрах ажилдаа орлоо. Жижиг үндэснүүдийг тайрахад амархан байсан ч том үндэснүүд рүү ороход амаргүй болохыг би тун удалгүй ойлгосон юм. Ялангуяа нэг үндэс тун ярвигтай байлаа.

Би шүд зуун уг үндсийг тайрахаар шийдэв. Толгой дээр туссан нарыг харсхийн, хөрөөгөө чанга барихад хүзүүг минь даган хөлс урсаж байлаа. Хөрөө бүх бие сэгсрэгдтэл чичирхийлэх нь тэр. Хөрөөний гохон дээр байсан баруун гараа өвдөн, хорсож эхлэхийг би мэдрэв. Би өвдөлтийг тоолгүй, зуурсаар л.

Эцэст нь хөрөө үндсийг тайрахыг би харлаа. Гараа гохон дээрээс авахад надад ялалтын сайхан мэдрэмж төрөв. Гэвч би бээлийгээ тайлаад, гарын маань арьс зулгарсан байхыг олж харлаа.

Энэ үйл явдлын талаар бодож байхад, хөрөөнөөс зууран барих нь төмөр бариулаас зууран барихтай яг адил болохыг би ойлгосон юм. Биднийг амьдралд урагшлан явахдаа төмөр бариулаас зууран барих ёстой гэдэг. Гэвч төмөр бариулаас зууран барьснаар өвдөлтийг мэдрэхгүй байна гэсэн үг биш юм. Би хөрөөнөөс зуурч байхдаа гараа шархлуулсан. Үүнтэй адил бид төмөр бариулаас зууран барьж байхдаа сорилт, зовлон зүдгүүрийг туулах болно.

Тэнгэрлэг Эцэг Өөрт нь эргэн ирэх аялал аюул заналаар дүүрэн байна гэдгийг мэдэж байсан. Тиймээс Тэр бидэнд туслах зорилгоор судар, бошиглогчдын үгс зэргийг өгсөн билээ. Бид мөнх бус амьдралын сорилт, бэрхшээл дунд эдгээрээс зууран барьснаар хэзээ нэгэн өдөр Түүний оршихуйд эргэн очих болно.

Заримдаа зовлон зүдгүүр амссан ч гэлээ бид Түүнд эргэн очихдоо төмөр бариулаас зууран барьж байсан өөрсдийн гарыг харах болно. Бид үүнийг Тэнгэрлэг Эцэгийн тусламж дэмжлэгээр мөн Есүс Христийн цагаатгагч хүчээр дамжуулан ямар ч саад бэрхшээл тохиолдсон байлаа гэсэн үүнээс чанга гэгч атгаснаар мэдэх болно. ■

Жэфф Бордэрс, АНУ, Вашингтон



Ажилтай болох зургаан алхам

Бруно Вассэлл III

Хэрэв бид ажилд орох хэрэгтэй бөгөөд ажилгүй байгаа бол материаллаг байдлын хувьд бие даах боломжгүй. Ажилтай болох зургаан алхмыг энд оруулав.

Танд ажилд орох эсвэл илүү сайн ажилтай болох хэрэгтэй байна уу? Та ажил хэрэгтэй хэн нэгнийг мэдэх үү? Ажилтай болох эсвэл илүү сайн ажилд орох үнэхээр шаардлагатай олон хүнд тохиолдож байгаа нэг бэрхшээл бол хүссэн ажлаа хэрхэн олохоо мэдэхгүй байх явдал юм. Тэд “Би танилцуулга бичих хэрэгтэй юу эсвэл өөрийнхөө тухай интернэтэд тавих нь зөв үү? Эсвэл аль алиныг нь хийвэл яах бол?” “‘Таны сул тал юу вэ?’ ‘Би яагаад таныг энэ ажилд авах хэрэгтэй вэ?’ зэрэг асуултад хэрхэн зөв хариулах вэ?” хэмээн асуудаг.

Энэ нийтлэлд хүссэн ажилдаа орохын тулд юу мэдэх шаардлагатай болох мөн дараа нь хүссэн ажилдаа орохын тулд юу хийх хэрэгтэй вэ гэсэн асуултад хариулахад туслах нотлогдсон зургаан алхмыг танилцуулах юм. Энэ зургаан алхмыг Бригам Янгийн Их Сургууль дээр ирж, ажилтан элсүүлж авдаг 760 ажил олгогчийн дунд ажилд авах арга барилынх талаар хийсэн миний судалгааны үр дүн дээр үндэслэн гаргасан. Түүнчлэн ажил олгогч мэргэжлийн хүмүүсээс мөн 30 гаруй жилийн хугацаанд 20 гаруй орны олон мянга хүнд өгсөн ажилд орох, ажил олгох сургалтаас авсан мэдээлэл дээр тулгуурлан эдгээр алхмыг боловсруулсан болно. Эцэст нь эхнэр бид хоёр Европын орнуудаар Бие даах чадвар хөгжүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх ахмад номлогчоор томилогдон үйлчилсэн. Бидний туршлага ажил хайгчдад яг энэ тодорхой тусламж хэрэгтэй байгааг батлан харуулсан билээ. Та дэлхийн хаана амьдардаг, ажлын ямар ур чадвартай эсвэл ямар албан тушаалтай ажилд орохыг хүсэж байгаа гэдгээс үл хамааран энэ зургаан алхам танд тусалж чадна.

Хүссэн ажилдаа орох энэхүү үйл явц хэд хоногоос хэдэн долоо хоног, бүр хэдэн сараар ч үргэлжилж болно. Гэхдээ нэг сайхан мэдээ юу вэ гэвэл, энэ үйл явц үнэхээр үр дүнтэй. Энэ зургаан алхам (1) анх удаа ажил хайж буй хүмүүст, (2) өөр ажилд шилжихийг эсвэл одоогоор ажиллаж байгаа компани эсвэл байгууллагадаа тушаал дэвшихийг хүссэн хүмүүст мөн (3) өөр байгууллагад албан тушаал дэвшин орохыг хүсэж байгаа хүмүүст гээд дээрх гурван ангиллын аль нэгэнд багтах бүх түвшний ажил хайгчдад тусална.

1-р алхам. Хүсэж байгаа тодорхой ажлаа тодорхойл.

Та яг одоо өөрийн ажлын ур чадвар, дадлага туршлага, гаргасан амжилт эсвэл боловсрол зэрэгтэй нийцэхүйц бодит ажлаа олж тодорхойлох ёстой. Тодорхойлсон бол ажлынхаа нэрийг бичнэ үү. Танд тусламж хэрэгтэй бол олон янзын вэбсайт дээр янз бүрийн ажлын нэр, тодорхойлолтыг жагсаасан байдаг. 1-р алхмын хувьд та нээлттэй ажлын байрны зар олох хэрэггүй. Зөвхөн өөрийн чадварт тэнцэх, сонирхолтой ажлаа тодорхойлно.

Ажил эрэлхийлж буй хүмүүсийн

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ИКЭР АЙЭРСТАРАН

Таны өмнө хэд хэдэн ажлын сонголт байгаа үед өөрт тохирсон ажилдаа орохын тулд та ямар алхам хийх вэ?

гаргадаг хамгийн том хоёр алдаа бол үнэхээр хүсэж байгаа тодорхой ажлаа сонгохгүй байх эсвэл тавьсан шаардлагад хүрэхгүй албан тушаалыг сонгох явдал юм. Хэрэв та яг ямар ажлыг хайж олох, аль ажил мэргэжлээр замнахаа мэдэхгүй байгаа бол ямар ч ажилд орохгүй байж болно. “Ямар ч ажил байсан, болно” гэх нь туслахгүй. Ингэж хэлэх нь ажил олгогчид хүчтэй сэтгэгдэл төрүүлэхгүй бөгөөд ажил хайхад гаргаж буй хичээл зүтгэлийг тань баллах болно. Тиймээс одоо хийж чадах тодорхой ажлаа сонгоод, тэр ажилдаа ороход хамаг анхаарлаа хандуул.

2-р алхам. Хүсэж буй ажлынхаа тодорхойлолтыг олж мэд.

Бригам Янгийн Их Сургуулиас ажилтан элсүүлж авдаг 760 ажил олгогчийн дунд явуулсан миний судалгаанаас болон олон жилийн туршид янз бүрийн оронд ажиллаж байсан туршлагаасаа харахад ажил олгогч болон менежерүүд аливаа ажил дээр ажлын тохирсон ур чадвар, дадлага туршлага, гаргасан амжилт эсвэл боловсрол бүхий нэр дэвшигчдийг үргэлж авч үздэг. Энэ нь ялангуяа дунд ба ахисан түвшний албан тушаалуудад илт харагддаг. Эдгээр ажил олгогч ажил горилогчдыг шалгахдаа, нээлттэй ажлын байр болгоны хамгийн чухал шаардлагуудыг санахын тулд ажлын байрны тодорхойлолтын тоймыг эсвэл жагсаалтыг ашигладаг. Дараа нь ажил олгогч албан тушаалынх нь тодорхой тодорхойлолттой бүх ажил горилогчийг харьцуулдаг.

Та хүсэж байгаа ажлынхаа ажлын байрны тодорхойлолтыг олж авах ёстой. Энэ нь тухайн ажилд тохирох ажил горилогч болж чадах эсэхээ тодорхойлоход танд туслах юм. Энэ нь бас танилцуулга, хавсаргах захидалдаа болон ажил олгогчтой хийх ярилцлагаар юу хэлэх, юу хэлэхгүйгээ шийдэхэд тань тусална. Ажил олгогчид өөрсдийн вэбсайт, сонины зар

болон ажил хайхад зориулсан вэбсайт дээр ихэвчлэн нээлттэй ажил болгоныхоо ажлын байрны тодорхойлолтыг тавьсан байдаг. Ажлын талаар мэдэж байгаа одоо ажиллаж буй ажилчид нээлттэй ажлын байрны тодорхойлолт болон тавигдах шаардлагуудын талаар танд хэлж өгөх боломжтой.

2 дахь алхмаар таны хийх ёстой зүйл бол хүсэж байгаа ажлынхаа ажлын байрны тодорхойлолтоос тодорхой шаардлагуудыг олж мэдэх явдал юм. Та дараа нь түлхүүр мэдээллийг 3–6-р алхам дээр ашиглана.

3-р алхам. Сонгосон ажилд тань тохирох ур чадвар, дадлага туршлага, ажлын үр дүн, боловсролын шаардлагыг олж тодорхойл.

Энд л та 2-р алхам дээрх ажлын байрны тодорхойлолтод дүрсэлсний дагуу таны хувийн ур чадвар, ажилтай холбоотой гаргасан амжилтололт одоо хүсэж байгаа ажлын байранд тань тавигдсан түлхүүр шаардлагатай үнэхээр тохирч байгаа эсэхийг тодорхойлно.

Та өөрийн ажлын ур чадвар, амжилтын талаар ийм жагсаалт гаргах юм бол өөрийнхөө ажлын туршлагыг 2-р алхам дээрээс мэдэж авсан ажлын байрны тодорхойлолт дээрх түлхүүр шаардлагуудтай харьцуулж чадахуйц болно. Хэрэв таны ур чадварууд 1-р алхам дээр сонгосон ажлын тань хэрэгцээтэй сайн тохирч байгааг харуулж байвал 4–6-р алхам руу орно уу. Гэхдээ, хэрэв 3-р алхам дээр таны жагсааж бичсэн ур чадвар болон гаргасан амжилтололтууд 2-р алхам дээр тодорхойлсон ажлын байрны тодорхойлолттой нийцэхгүй байвал энэ удаа яг одоогийн ур чадвар, чадавхтай тань хамгийн сайн тохирох өөр ажлыг сонгох талаар нухацтай бодож үзэх хэрэгтэй.

4-р алхам. Тусгайлан тохируулсан нэг юм уу хоёр хуудас танилцуулга бич.

CV ч гэж нэрлэдэг танилцуулгыг бичих гол зорилго бол нээлттэй ажлын байранд хүн авахаар хайж буй ажил олгогчтой ярилцлага хийх явдал юм. Таны танилцуулга ажлын тань ур чадвар, дадлага туршлага, гаргасан амжилтололт эсвэл боловсрол гээд тухайн ажил олгогчийн ажлын байрны тодорхойлолтын хамгийн чухал үзүүлэлтүүдтэй хамгийн сайн тохирсон ажил горилогч гэдгийг товч тодорхой харуулснаар ярилцлагад орох үүд хаалгыг нээж өгдөг.

Та танилцуулгаа өөр өөр ажил олгогчийн нээлттэй ажлын байр бүрд *тохируулан бичсэн байх* ёстой. Та бүх танилцуулга дээрх ажлын намтар,

Өөрийн танилцуулгыг ажил болгон дээр тохируулан өөрчил. Ажлын тодорхойлолтод хамаарах ур чадвар, амжилт ололтоо жагсаан бич.

сургуулийн талаарх болон одоогийн холбоо барих мэдээлэл зэрэг оруулбал зохих үндсэн мэдээллээ өөрчлөх шаардлагагүй. Эдгээр мэдээлэл таны бүх танилцуулган дээр адилхан байх ёстой. Гэвч хэрэв та нэгээс дээш ажил олгогчид ажилд орох маягт бөглөн өгч байгаа бол ажил олгогч бүрийн ажлын тодорхойлолт дээрх шаардлага бага зэрэг эсвэл огт өөр байна. Тиймээс та ажлын байрны тодорхойлолт бүр дээр ямар ур чадвар, амжилт ололт тань илүү тохирохыг сонгох ёстой. Та эдгээрийг танилцуулган дээрээ "судалсан," "хөгжүүлсэн," "үйлдвэрлэсэн," "зохион байгуулсан" гэх мэт тодорхой үйл үгээр эхлэх товч тайлбар маягаар оруулаарай.

Жишээлбэл, хэрэв та борлуулалт, маркетингийн аль алинд ажиллаж байсан туршлагатай мөн борлуулалт, маркетинг гэсэн хоёр өөр ажил дээр маягт бөглөж өгөх гэж байгаа бол нэгэн дээр нь борлуулалтаар хийсэн ажил, гаргасан амжилт ололтоо, харин нөгөөх дээр нь маркетингаар хийсэн амжилт, гаргасан амжилт ололтоо хуваалцсан хоёр танилцуулга боловсруулах хэрэгтэй. (Хэрэв та ажлын арвин туршлага хараахан хуримтлуулаагүй байгаа бол Сүмийн үйлчлэлийн туршлагаа танилцуулга дээрээ хэрхэн ашиглаж болох талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **lds.org/go/71939** вэбсайтаас авна уу.)

5-р алхам. Одоо орохыг хүсэж байгаа ажлынхаа ажилд авч байгаа ажил олгогчдыг ол.

Цаг үе хүнд хэцүү байсан ч бөглөх хэрэгтэй ажлын орон тоо байсаар л байдаг. Ажилтнууд тэтгэвэртээ гарч, ажлын байраа сольж, тушаал дэвшиж, буурч эсвэл өөр газар руу шилждэг. Өсөж хөгжин, илүү олон хүн ажилд авах шаардлагатай бизнесүүд үргэлж байдаг. Энэ бүх нөхцөл байдал нь шаардлага хангасан ажил олгогчоор орлуулж болох ажлын байруудыг гаргаж өгдөг. Заримдаа бөглөх ажлын орон тоо цөөхөн байдаг бол заримдаа бөглөх ажлын байруудаар хахах нь ч бий. Тиймээс та ажил хараахан олоогүй байгаа бол сэтгэлээр бүү уна. Зүгээр л өөрт тохирсон ажлаа үргэлжлүүлэн хай.

Ажил олгогчдын болон ажлын байрны вэбсайт, сонины зар болон бусад эх сурвалжаас хүсэж байгаа ажлаа хай. Түүнчлэн нээлттэй ажлын байрыг олох хамгийн сайн аргуудын нэг бол харилцаа холбоо тогтоох явдал юм. Та өдөр бүр хөрш, тойргийн гишүүд зэрэг олон хүнтэй холбогдож, хайж байгаа тодорхой ажлынхаа талаар тэдэнд дуулгаж, ийм ажлын орон тоо нээлттэй байгаа эсэхийг мэдэхийг эсвэл энэ

Ажлын ярилцлаган дээр тавьж болох асуултуудад өгөх хариултаа төлөвлөж, давт.

талаар мэдэх хэн нэгнийг таньдаг эсэхийг асуу. Та өдөр бүр хүмүүстэй ярилцахдаа холбоо барих мэдээллээ хүн бүрд өгөхөө мартуузай.

6-р алхам. Ажил олгогчид танилцуулгаа явуулахаасаа өмнө ярилцлагад хэрхэн сайн орж болоход суралц.

Та ажил олгогчдод сайтар тохируулан бэлдсэн танилцуулгаа явуулахын өмнө эхлээд ярилцлагад төвөггүй орж сурах хэрэгтэй. Ихэнх хүн ярилцлагад сайн ороход бэлдэхийнхээ оронд танилцуулгаа хэт яаран явуулдаг. Асуудал нь ажил горилогчдын зарим нь ярилцлагад шууд орохоор уригдаж болоход оршино. Тухайн ажилд орохоор нэр дэвшигчдийн сэтгэл догдолж, ярилцлагадаа хангалттай сайн бэлдээгүйгээсээ болж ярилцлагадаа ч мөн ажилдаа ч амжилттай орж чаддаггүй. Үүнээс болж та тэр компанид юм уу ярилцлага хийгч дээр эргэн очиж, дахиад ярилцлагад ормоор байна, би одоо тэр асуултад хэрхэн зөв хариулахаа мэднэ гэж хэлэх боломжгүй юм.

Ярилцлагын асуулт бүхэнд хэрхэн хариулах нь хүссэн ажилдаа орох эсэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Хэдийгээр та бүх асуултад үнэнчээр хариулах хэрэгтэй ч ярилцлагын асуулт бүрд хариулах арга зам зөв эсвэл буруу байж болно. Танд тавьж болох асуултуудыг өгөв. Үүнд:

- Таны хүчтэй болон сул талууд юу вэ?
- Өмнөх ажил дээр тань тулгарч байсан асуудлыг та одоо хэрхэн өөрөөр шийдвэрлэж болох вэ?
- Та ямар цалин авахыг хүсэж байна вэ?
- Та таван жилийн дараа юу хийхийг хүсэж байна вэ?

Та ажил горилогчийн хувьд, тавьсан асуулт бүрд өгөх хариулт бүрээ урьдаас тооцоолж, төлөвлөсөн байх ёстой. Ганцхан муу хариулт ажилд орох боломжийг тань үгүйсгэж болно. Таны туршлага, ур чадвар, гаргасан амжилт ололт тэдний ажлын байрны тодорхойлолтод нийцэж байгааг харуулах богинохон, нэгээс хоёр минутад багтах хариултыг өгөхөд төвлөр. Эхний ярилцлагад орохоосоо өмнө хариултаа тэдний хэрэгцээнд нийцүүлэхийн тулд тухайн байгууллагыг судал.

Ихэнх ярилцлагын дараа танд ажил олгогчоос хэдэн зүйлийг асуух боломж гарна. Тавьж болох хамгийн сайн асуулт бол тухайн нээлттэй ажлын байрны талаар байх ёстой. “Энэ ажилд юу хийх эсвэл юуг өөрчлөх шаардлагатай вэ?” Энэ нь таныг эргэж ирэхийг урих үед болох дараа дараагийн ярилцлагад тус болно. Та ерөнхийдөө байгууллагын зорилго, ажлын соёл, цалин (танаас энэ тухай асуувал), ажлын цаг, урамшууллын талаарх асуултаа хадгалан, дараагийн ярилцлагаараа асууж болох юм.

Та одоо хүссэн ажилдаа орох зургаан алхмыг мэддэг боллоо. Хэрэв та ажилд орох хэрэгтэй бөгөөд ажилгүй байгаа бол материаллаг байдлын хувьд бие даах боломжгүй гэсэн үг. Хэрэв та ажилд орох шаардлагатай эсвэл илүү сайн ажил хэрэгтэй байгаа бол эсвэл ажилд орох хэрэгтэй хэн нэгнийг мэддэг бол эдгээр хүчирхэг, батлагдсан, ажил хайх хэрэгслийг ашиглаж эсвэл бусдад түгээнэ үү. Эдгээр нь танд хэрэг болно. Хүссэн ажилдаа орохын тулд гаргах хичээл зүтгэлийг тань Их Эзэн адислах болтугай. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

АЖИЛ ХАЙХАД ТАНЬ ТУСЛАХ СҮМИЙН ЭХ СУРВАЛЖУУД

Тойрог, гадасныхаа "Илүү сайн ажилтай болох нь" бие даах чадвар хөгжүүлэх бүлэгт нэгдэх талаар бодож үз. Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчөөсөө танай тойрогт эсвэл салбарт бие даах чадвар хөгжүүлэх эсвэл ажил олгох асуудал хариуцсан мэргэжилтэн байгаа эсэхийг асуу.

Ярилцлагад орох, харилцаа холбоо тогтоох, танилцуулга бичихтэй холбоотой видео бичлэгийг олъё гэвэл **lds.org/go/719** хаягаар орно уу.

АЖИЛЛАЖ ХӨДӨЛМӨРЛӨХ НЬ АГУУ БОЛОМЖ БОЛОЙ

"Ажил хөдөлмөр бол сэтгэл санааны зовлонг эдгээгч, уй гашууг илааршуулагч, боломжийг нээгч үүд хаалга юм. Амьдралын нөхцөл байдал ямар байгаагаас үл хамааран чадах бүхнээ хийж, хийдэг юм бүхэндээ гарамгай гэдгээ харуулцгаая. Шинэ өдөр бүрийн авчрах ажил хөдөлмөрийн агуу боломжинд оюун ухаан, бие бялдраа бэлдэцгээе."

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф, "Ямар ч эдийн засгийн үед хамаарах хоёр зарчим," ***2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган,*** **66.**

БИЕ ДААХ ЧАДВАР ХӨГЖҮҮЛЭХ АНГИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ СЭЛИА ЖЭФФРИ АВАВ

Тэр таны хийсэн ажлыг мартахгүй

Хэдэн сарын өмнө би нэг зүүд зүүдэлсэн юм. Уг зүүдэнд би ердийнхөөрөө оролцох ямар ч хүсэлгүй, арын эгнээнд суусан байсан ба миний ойлголт орвонгоороо өөрчлөгдсөн байв. Би энд тэнд таран суусан цугларагсдын дундаас хугацаанаасаа өмнө номлолоос буусан бусад номлогчийг олж харлаа. Эргэн тойрноо хараад, надад тэдэнд туслах хүсэл төрөв. Туршлагаа хуваалцах нь тэдэнд хүрч тохинуулах мөн замд нь хурд сааруулагч байж болох ч гэрээний замдаа үлдэхэд нь туслах арга зам байж болох юм гэдгийг би мэдэж байсан.

Энэ зүүдээр дамжуулан Тэнгэрлэг Эцэг анхаарал халамж тавьдаг гэдгээ надад мэдүүлсэн юм. Бидний бүрэн цагийн номлол хэр удаан үргэлжилснээс үл хамааран номлогч байхдаа үзүүлсэн зөв шударга үйлчлэлд маань Тэр талархдаг. "Түүний төлөө та нарын үзүүлсэн . . . үйлчлэл ба хайрыг чинь Тэр хайхралгүй орхихгүй. Бурхан шударга бус биш ээ" (Еврей 6:10). Би өөрийн нийтлэлээр (47-р хуудсыг үзнэ үү) дамжуулан, энэхүү санаанд оромгүй, хүндхэн замыг туулахад тань туслах судрын түүхээс болон хугацаанаасаа өмнө номлолоос буусан бусад номлогчийн туршлагаас хуваалцсан. Алэкс Мормоны Номын түүхийг ашиглан, зохистой байдлын асуудлаас болж хугацаанаасаа өмнө гэртээ эргэж ирсэн хүмүүст ч гэсэн найдвар байгаа гэдгийг олж харахад бидэнд тусалсан нь надад таалагддаг (44-р хуудсыг үзнэ үү).

Та зөвхөн цахим хувилбараас Эмили хэрхэн өөрийн санаа зовнил, айдас, цөхрөлийг хувийн, ариун нандин баяр баясгалан болгож чадсаныг олж унших болно. Мэргэжлийн зөвлөх Кэвин хайртай хүмүүс нь хугацаанаасаа өмнө гэртээ эргэж ирснээсээ болж зовж шаналж байгаа хүмүүсийг дэмжиж болох талаар зөвлөгөө өгсөн

Бидний буцаж ирэх болсон шалтгаан ямар байх нь хамаагүй. Харин гэртээ эргэж ирээд юу хийх вэ гэдэг нь чухал. Бид Аврагчийн тусламжаар эдгэрч, өсөж хөгжин, мөнхийн аялалдаа илүү их баяр баясгаланг үргэлжлүүлэн олох боломжтой.

Хүндэтгэсэн,
Лиахона Фикүэ

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ХАМГИЙН САЙН ЗӨВЛӨГӨӨ . . .

Залуучуудын хугацаанаасаа эрт номлолоос буусан талаараа хуваалцсан хамгийн сайн зөвлөгөөг доор оруулав. Үүнд:

"Бүх зүйл болно, бүтнэ гэдгийг мэдэж ав. Энэ нь тийм ч муу зүйл биш юм байна гэдгийг хүлээн зөвшөөрөх хүртэл чамд хэцүү байх болно гэсэн зөвлөгөөг надад өгч байсан. Ямар ирээдүйг бүтээхээ чи өөрөө шийднэ."
—Натаниэл Парк, Баруун Австрали, Австрали

"Энэ явдал чиний хэн болохыг тодорхойлох ёсгүй."
—Элэна Кингсли, АНУ, Юта

"Нөхцөл байдал ямар байхаас үл хамааран амьдралынхаа хэв маягт эргэн орохын тулд өөртөө шинэ дадал хэвшил суулгахыг хичээ."
—Роза-Линн Руйтэр, Нидерланд

"Нэг номлол дуусахад нөгөө номлолын үүд хаалга нээгддэг. Тэрхүү шинэ номлолоо ол!"
—Робэрто Алфонсо Мартинэз IV, АНУ, Юта

"Бурхан танд хайртай бөгөөд танд зориулсан төлөвлөгөө Түүнд бий. Итгэлтэй байцгаая!"
—Рэбэкка Стоктон, АНУ, Аризона

Гэрлэлтийн талаар хүлээн авсан хамгийн сайн зөвлөгөө тань юу байсан бэ? Хариултаа ***liahona.lds.org*** *вэбсайтаар 2019 оны 7-р сарын 31-ний дотор бидэнд илгээнэ үү.*

ЗАЛУУ НИЙТЛЭГЧДИЙН ТУХАЙ

Алэкс Хьюги нь АНУ-ын Орегоноос ирсэн. Тэр Бригам Янгийн Их Сургуулийг англи хэлний мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. Тэр залуучуудад зориулсан уран зохиол судлах, сонирхогчийн түвшинд богино түүх, өгүүлэл бичих мөн сүү уух дуртай.

Лиахона Фикүэ Францын өмнөд хэсгээс ирсэн. Тэр суралцах дуртай бөгөөд аавтайгаа байшингийнхаа эргэн тойронд ажиллах дуртай. Тэр анагаахын чиглэлээр суралцаж байгаадаа сэтгэл хангалуун байдаг бөгөөд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллахыг хүсдэг. Тэр одоогоор хугацаанаасаа өмнө номлолоос буусан номлогчдын оролцоотойгоор, тэдэнд зориулан бичсэн номын франц хэлний орчуулга дээр ажиллаж байгаа.

Эмили Ворнэр АНУ-ын Айдахогийн хойд хэсэгт өсөж торнисон ба энэ нь одоо ч гэсэн түүний дэлхий дээрх хамгийн дуртай газар хэвээр. Тэр Бригам Янгийн Их Сургуульд нягтлан бодогчоор суралцсан бөгөөд явганаар аялах, зураг авах, нөхөртэйгөө хамт дэлхийг тойрон аялах дуртай.

ТҮҮХЭЭ ХУВААЛЦ

Танд хуваалцах гайхалтай сайхан түүх байна уу? Эсвэл та аль нэгэн сэдвээр бичсэн нийтлэл уншмаар байна уу? Хэрэв тийм бол бид таны үгийг сонсохыг хүсэж байна! Та өөрийн түүх, санал, сэтгэгдлийг **liahona.lds.org** руу илгээнэ үү.

ЭНЭ ХЭСЭГТ

44 **Хэрэв номлолоо хугацаанаасаа өмнө дуусгасан бол бүү бууж өг***
Алекс Хьюги

47 **Хугацаанаасаа өмнө номлолоос буусан номлогчдод: Та ганцаараа биш***
Лиахона Фикүэ

* Энэ нийтлэлд цахим хувилбарт орох нэмэлт агуулга орсон.

ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР

Хугацаанаасаа өмнө номлолоос буусан номлогчдыг дэмжих нь
Кэвин Тэриот

Хугацаанаасаа өмнө номлолоос буусан ч Христээр дамжуулан баяр баясгаланг олох нь
Эмили Ворнэр

Эдгээр болон өөр бусад нийтлэлийг доорх эх сурвалжаас олно уу. Үүнд:

- **liahona.lds.org**
- **YA Weekly** (Gospel Library аппликэйшн дээрх "Young Adults" апп)
- **facebook.com/liahona**

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Хугацаанаасаа өмнө номлол тань дууссан бол бүү бууж өг

Номлолоосоо гэртээ эрт бууж ирсэн гэээд таны үнэ цэн буурахгүй.

Алэкс Хьюги

Хэрэв та үүнийг уншиж байгаа бол номлолоосоо гэртээ эрт бууж ирэх нь ямар хэцүү болохыг аль хэдийн мэдэж байгаа байх. Үйлчилж буй залуучууд бие махбодын гэмтэл, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, иргэний онцгой байдал, зохистой байдлын асуудал, бусадтай холбоотой ноцтой зөрчил гаргах эсвэл номлолын дүрмээ дуулгавартай дагахгүй байснаасаа болж товлогдсон хугацаанаасаа өмнө номлолоос буухад хүрч болно.

Ямар ч шалтгаантай байлаа гэсэн Бурхан энэ саад бэрхшээлийн улмаас аль ч хүүхдээ сүнслэг байдлын хувьд зэрэмдэг болгохыг хүсдэггүй. Тиймээс эрт бууж буй номлогчид энэ амаргүй өөрчлөлтийн үр дагавраас хэрхэн гарч чадах вэ? Эцэг эх, Сүмийн удирдагчид мөн хайртай хүмүүс нь тэдэнд хэрхэн тусалж болох вэ?

Мормоны Номын номлогч

Алмагийн номон дахь нэг түүх бидэнд тус болох нэгэн жишээг өгдөг. Нифайчуудын бошиглогч Алма хэдэн итгэлтэй хүнийг удирдан, ёс бус зорамчуудад номлохоор явдаг. Тэдний нэг нь түүний хүү Кориантон байсан ба тэр "тохинуулдыг орхиж, мөн лемenчүүдийн хилийн ойролцоох Широны нутаг тийш янхан эм Изабелын араас од[жээ]" (Алма 39:3). Үүнээс болж Алма "хэрэв энэ нь чиний тусын тулд байгаагүйсэн бол, би гэмт үйлүүдийг чинь нуршин, сэтгэлийг чинь шаналгахгүй сэн" (Алма 39:7) хэмээн Кориантоныг хатуу зэмлэж, түүнийг наманчлалд дуудав.

Кориантон эцгийнхээ зэмлэсэн үгийг даруухнаар хүлээн авч, нүглүүдээ наманчилж, зорамчуудын дунд номлогчоор үйлчилж, эргээд "үгийг үнэнээр мөн чандаар тунхагла[сан]" (Алма 42:31). Энэ түүх цааш нь Алмаг хөвгүүддээ хандан ярьсны дараа "Алмагийн хөвгүүд [Шиблон, Кориантон хоёул] хүмүүсийн дунд үгийг тунхаглахаар явцгаав" (Алма 43:1) гэж гардаг.

Үйлчлэх боломжтой буцаж ирэх нь

Энэ түүхээс бид юу ойлгож сурч болох вэ? Юуны түрүүнд эрт буусан номлогчид урьдчилан сэргийлж болох байсан шалтгаанаар буусан байсан ч гэсэн агуу зүйлсийг гүйцэлдүүлэх боломжтой хэвээр байдаг. Кориантон олон ноцтой алдаа

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД ГРИЙН

гаргасан байж болох ч агуу үйл хэргийг үргэлжлүүлэн гүйцэтгэхээр явсан. Үүнтэй адил, өөрийн үйлдлээс болж буусан номлогчид хүртэл сүнслэг хүчин чадлаа үгүй хийчихлээ гэж бодох ёсгүй. Кориантон алдаанаасаа суралцаж, Бурханы хаант улсыг гайхалтай арга замаар барьж байгуулахаар ирсэн бөгөөд хэчнээн бүтэлгүйтсэн гэж бодож байсан ч гэлээ, хүн бүрд иймчадвар бий.

Хоёрдугаарт, эрт буусан номлогчийн сүнслэг эдгэрэлтэд бусад хүн ямар чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг ойлгож авдаг. Кориантоны аав, санваарын удирдагч Алма Кориантоныг нэг талаар хурцаар зэмлэсэн боловч нөгөө талаар сүнслэг чадавхдаа хүрч чадна гэдэгт итгэлтэй байсан. Кориантонтай адил номлолдоо дуулгаваргүй байсны үр дагавар ирэх ч ямар ч сахилгажуулалтыг хайр, өршөөл, нигүүлсэл дагалдах ёстой (Сургаал ба Гэрээ 121:41–44-ийг үзнэ үү).

Өвчнөө эдгээхээр буух нь

Эрт буусан номлогчдод найдвар өгөх үүнтэй адил захиас өнөөдөр ч давтагдаж байна. Бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас болж номлолоосоо эрт буусан Маршаллд заримдаа номлолдоо бүхий л чадлаараа үйлчлээгүйдээ мөн заримдаа эрүүл мэндийн асуудал, хувийн хангалтгүй байдлынхаа аль алиныг буруутгадаг байв. Гэвч үйлчлэл нь үнэхээр үр дүнтэй байсан гэж тэр боддог.

"Бид номлогчийн хувьд төгс биш шүү дээ. Бид уруу таталтад ордог бөгөөд нүгэл ч үйлдэж магадгүй. Гэвч Сатан таныг хамгийн сайн номлогч байгаагүй үед Их Эзэн хичээл зүтгэлийг тань хүлээн аваагүй гэж бодогдуулан, таныг төгс бус байдал дээрээ анхаарлаа илүү хандуулаасай гэж хүсдэг байж болох юм" гэж Маршал хэлсэн.

Их Эзэн номлогчдыг сонголтоосоо юм уу нөхцөл байдлаасаа болж үйлчлэлээ төгс хийгээгүй ч тэдний хийсэн үйлчлэлд сэтгэл хангалуун байгаагаа мэдээсэй гэж хүсдэг гэдэгт Маршалл итгэдэг.

Маршалл Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрт ойр байхын тулд чадах бүхнээ хийснээр аливаа зүйлийг давж гаран, эдгэрч чадна гэдгээ мэдсэн.

Наманчлахаар буух нь

АНУ-ын Колорадод үйлчилсэн өөр нэгэн номлогчийг сахилгын шалтгаанаар номлолоос нь буулгаж, Сүмийн гишүүнчлэлээс нь хассан ч тэр хожим нь дахин баптисм хүртсэн юм. "Гэртээ эргэж ирэх хэцүү байв. Надад төөрөлдсөн, хоосорсон мэт мэдрэмж төрж байсан. Заримдаа гэртээ ирсний хамгийн хэцүү хэсэг бол сүмдээ үргэлжлүүлэн явж, судраас уншиж мөн залбирах сэдлийг олох явдал байв. Энэ энгийн зүйлс хамгийн хэцүү байсан" гэж тэр хэлсэн.

Гэвч тэр гэр бүл, найз нөхдийнхээ дэмжлэгээр мөн наманчлахаар хичээж байх явцдаа хүч чадалтай болжээ.

“Зорилго тавьж, бишоптойгоо уулзаж, зохистой болсон үедээ ариун сүмд орох зэрэг нь Тэнгэрлэг Эцэгтээ илүү ойртоход гол үүрэг гүйцэтгэсэн. Би бишоптойгоо уулзаж чадахгүй, тавьсан зарим зорилгодоо хүрч чадахгүй байснаа санадаг. Дайсан үргэлж хажууд минь байж, уруу татдаг байсан” хэмээн тэр нэмж хэлэв.

“Надад хайртай, намайг аз жаргалтай байгаасай гэж хүсдэг Тэнгэрлэг Эцэг байгаа гэдгийг үргэлж санаснаар мөн Аврагчийн Цагаатгал, наманчлалын талаар гэрчлэлтэй болсноор хэчнээн хол мэт санагдаж болох ч бид Бурханд илүү ойртож чадна” гэдгийг мэдэх нь түүнийг эдгэрэх боломжтой болгосон юм.

Тэр цааш нь гэрт нь буцаах болсон үйл явдал болохоос өмнө үйлчилсэн хэдэн сарынхаа талаар дурдахдаа, “Номлолоо эргэн санахад, энэ нь хамгийн сайхан туршлага байсан гэж би одоо хүртэл бодож явдаг. Би их зүйл сурсан. Миний төлөвлөснөөр болоогүй ч би сайн мэдээний ачаар хүмүүсийн амьдрал өөрчлөгдөж байгааг харах боломжтой байсан. Би хэдэн алдаа гаргасан ч, наманчилж, урагшлахаар хичээхийн хэрээр миний гэрчлэл төдий чинээ өссөн” хэмээн тэр нэмж хэлсэн юм.

Тэрээр өөрсдийн хийсэн сонголтын улмаас номлолоосоо эрт буусан хүмүүс “бүх зүйл дуусаагүй” гэдгийг мэдээсэй гэж хүсдэг. Эрт ирэх нь наманчлалын эхний алхам юм. Та наманчлалын энэхүү үйл явцыг дуусгасныхаа дараа олон зүйлийг сурч мэдсэн байх болно. Үүрч байсан хүнд ачаа тань авагдах болно. Бурханы мэлмийд зөвт байгаагаа мэдэхээс илүү сайхан мэдрэмж гэж үгүй.

Эрт буусан номлогчдыг хайрлах нь

Гэртээ эрт ирсэн энэ хоёр номлогч хоёулаа эрт буусан номлогчдын найз нөхөд, гэр бүлийнхэн тэднийг хайрлаж, дэмжлэг үзүүлэх нь хэчнээн чухал болохыг онцолсон.

“Тэдэнд орон зай гаргаж өг. Гэвч тэд сэтгэлээр унаж магадгүй тул тэдэнтэй ойр байж, найз нь бай.” Бид Сүнсийг сонссоноор тэдний хэрэгцээг олж мэдэн, хэзээ тэдэнд тусламжийн гараа өгч үйлчлэх, хэзээ хувийн орон зайг нь үлдээж хүндэтгэхээ мэдэх боломжтой.

“Зүгээр л тэднийг хайрла. Есүс Христийн цагаатгагч золиосыг үргэлж санахад тэднийг урамшуулан дэмж” гэж Колорадод үйлчилсэн номлогч нэмж хэлсэн юм.

Хүмүүс эрт буусан номлогчдод хэрхэн хандсанаар тэднийг ичгүүртэйгээр унагахаар түлхэж эсвэл итгэлтэйгээр урагшлахад нь тусалж болно. Тэднийг шүүлгүй, тэврэн авах нь чухал.

Кориантоны нэгэн адил эрт буусан номлогчид одоогийн хүнд байдлаасаа Их Эзэний хүчирхэг зэмсэг болж өндийн босох чадавхтай.

Бурханы төлөвлөгөөнөөс итгэл найдварыг олох нь

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд эрт буусан номлогчдод хандан тайтгаруулах үг хэлсэн. “Хэн нэгэн чамаас номлолд үйлчилсэн эсэхийг тань асуух юм бол тийм гэж хариул. . . . Хийсэн үйлчлэлээ нандигнан хайрла. Гэрчлэх, Их Эзэний нэрээр үйлчлэх, номлогчийн нэрийн тэмдгийг зүүх боломжтой байсандаа талархаарай. Дахин үүнд бүү санаа зов, дахин энэ талаар бүү ярь. Өөрийгөө хангалтгүй эсвэл бүтэлгүй гэж бүү бод хэмээн ахин дахин гуйя”[1] гэж тэр хэлсэн юм.

Нүглээс болж эрт буусан хүмүүст хандан хэлэхэд, Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгч Жой Д.Жонсын: “Хэрэв бид гэм нүгэл үйлдсэн бол зохисгүй болж болох ч үнэ цэнээ хэзээ ч алдахгүй!”[2] хэмээн хэлснийг санаарай. Хэрэв бид Бурханд хандах юм бол Тэрээр бидний хамгийн харанхуй цаг мөчид өөртөө итгэх итгэлээ хөгжүүлэхэд тусална гэдгийг тэр батлан хэлсэн.

Мормоны Номон дахь болон орчин үеийн эрт буусан номлогчдын мөн Сүмийн удирдагчдын захиас бүгд адил. Найдвараа бүү алд. Учир нь Бурханд танд зориулсан, таны төсөөлж чадахаас ч илүү агуу төлөвлөгөө бий. Эдгээр номлогчийн хайртай хүмүүст хандан хэлэхэд, тэднийг гэртээ эргэж ирэхэд үзүүлэх таны хандлага тэдэнд эдгэрч мөн өөрсдийн чадавхад хүрэхэд асар ихээр туслах болно. Есүс Христийн Цагаатгал бүх шархыг, тэр дундаа номлолоосоо эрт бууж байгаа хүмүүсийн шархыг хүртэл эдгээнэ гэдгийг санаарай. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Та liahona.lds.org эсвэл Gospel Library аппликэйшн дээрх энэ нийтлэлийн цахим хувилбараас номлолд гарах гэж байгаа болон эрт буусан номлогчдод зориулсан эх сурвалжийн жагсаалтыг олж авч болно.

ЭШЛЭЛҮҮД

1. Jeffrey R. Holland, “Elder Holland’s Counsel for Early Returned Missionaries” (video), lds.org/media-library.
2. Жой Д.Жонс, “Хэмжээлшгүй үнэ цэн,” *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 141.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Залуучууд хугацаанаасаа өмнө номлолоос буусныхаа дараа хэрхэн амьдралын утга учир, амар амгаланг олсноо мөн та ч бас тэдгээрийг хэрхэн олж болох талаар хуваалцав.

Хугацаанаасаа өмнө номлолоос буусан номлогчдод: **Та ганцаараа биш**

Лиахона Фикүэ

"Бусдыг Христэд ирэхэд урих"[1] үүргээ биелүүлэхээр хичээнгүйлэн ажиллаж буй бүрэн цагийн номлогчдын арми олон хүнд "агуу найдлага хийгээд их баясал[ыг]" (Алма 56:17) авчирдаг. Энэ номлогчид яг л Мормоны Номын залуу дайчдын адил өдөр бүр "гайхамшигт хүчээр; мөн иймт агуу хүчтэйгээр" (Алма 56:56) тулалддаг.

Гэвч 2060 залуу дайчны дунд ч гэсэн "цус алдсанаас ухаан алдаж унасан нь хоёр зуу байлаа" (Алма 57:25). Энэ нь тэднийг эр зориггүй, хүчгүй, хулчгар, бусдад үнэ цэнгүй болгосон уу? Огтхон ч үгүй.

Яг л үүнтэй адил сэтгэл санааны эсвэл биеийн эрүүл мэндийн шалтгаанаас болж хугацаанаасаа өмнө гэртээ ирсэн номлогчид та нар эр зориггүй, хүчгүй, хулчгар *биш* эсвэл үнэ цэнгүй гэсэн үг биш юм. Тэдний сорилт бэрхшээлийг тэсэж гарах гэсэн оролдлогыг авч үзэхэд л гайхалтай. Та тун их шархадсан байсан байж магадгүй ч амьд үлдсэн. Таны шарх бие махбодын болон сэтгэл санааных эсвэл сүнслэг байдлынх уу гэдгээс үл хамааран одоо тэдгээртээ анхаарал тавих хэрэгтэй (Алма 57:28-ыг үзнэ үү). Зохистой байдалтай холбоотой шалтгаанаар гэртээ буцаж ирсэн хүмүүст хандан хэлэхэд, наманчлах нь эдгэрэх үйл явцын тань чухал хэсэг юм.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ТИФФАНИ МИЛОАН ТОНГ

Та гэртээ дасах зуураа өөртөө эдгэрэх цаг хугацааг өгч, Бурханд үргэлж итгэлтэй байхад анхаар (Алма 57:27-г үзнэ үү). Тэр бидэнд: "Миний нэрэнд ажил хийлгэхээр хүмүүний үрсийн [охид], хөвгүүдийн хэнд нь ч би зарлиг өгөхөд"—жишээ нь, номлолд үйлчлэх "мөн хүмүүний [охид], хөвгүүд өөрсдийн бүхий л хүчин чадалтайгаар мөн тэдэнд байгаа бүхэнтэйгээр одож, мөн хичээл зүтгэлээ үл орхин уг ажлыг гүйцэтгэхэд, мөн дайснууд нь"—бие махбодын, сэтгэцийн өвчин эсвэл бусад гэмтэл бэртлийн хэлбэрээр"—тэдэн дээр ирж мөн уг ажлыг гүйцэтгэхэд нь тэдэнд саад учруулах үед, болгоогтун, тэдний гараас уг ажлыг цаашид үл шаардан, харин өргөлүүдийг нь хүлээн авах нь миний хүсэл зориг болой" хэмээн сануулсан (Сургаал ба Гэрээ 124:49).

Та дайны талбарт байхдаа ямар шарх авсан эсвэл аль шарх тань сэдэрсэн байснаас үл хамааран, хэрэв та зохистойгоор үйлчлэн эсвэл бүрэн наманчилсан л бол таны хувь нэмэр Их Эзэнд хэрэгтэй бөгөөд Тэр хүлээн авах болно.

Дараах түүхүүдийг уншсанаар та ганцаараа биш гэдгээ мөн бусадтай түүхээ хуваалцсанаар бусдад тусална гэдгээ мэдэж авах ба энэ нь эдгэрэхэд тань туслах юм.

АВРАГЧ ТАНЫ ЗОВЛОН ШАНАЛЛЫГ МЭДЭРСЭН *гэдгийг ухааран ойлго*

Би номлол руугаа нисэж явахдаа, гэртээ ирэхэд ямар байхыг төсөөлж байв. Гэрийнхэн болон найз нөхөд маань хөөр баяр болон намайг тэврэн авч, би нэр хүндтэй буцаж ирсэн номлогчдын хүлээн авдаг адислал бүрээс хүртэн, үлдсэн амьдралаа амар тайван өнгөрүүлэх байв.

11 сарын дараа гэр рүүгээ нисэх үед, юу болох бол гэдэгт сэтгэл зовнин, өнгөрөх хором бүрийг өнгөрүүлж байлаа. Гэрийнхэн маань хүлээж байсан бөгөөд хэдийгээр тэд намайг баяр хөөр болон угтан авсан ч тун удалгүй ирээдүйд намайг юу хүлээж байгаа тухай бодон, ганцаар үлдэв.

Аврагч харанхуй цаг мөчийг маань харсан. Тэр намайг гурван долоо хоногийн турш орондоо уйлж хэвтэхийг мөн бодит байдлаас зугтахын тулд унтаж байгааг мэдэж байсан. Эргэн тойрны маань хэн ч миний мэдэрч буй зовлон, сэтгэл санааг ойлгохгүй тул Түүний хүч надад хэрэгтэй гэдгийг Тэрээр мэдэж байв. Тэр миний зовлонг ойлгож байсан. Би Түүнгүйгээр номлолдоо үлдэж ч, гэртээ хугацаанаасаа өмнө ирж ч чадахгүй байх байсан.

Али Боаза, Австрали, Квинсланд

Яагаад гэдэгт гайхширан, ЦАГАА ДЭМИЙ БҮҮ ҮР

Гэртээ хугацаанаасаа өмнө харина гэхээс айдас төрж байлаа. Зөвлөх надад ийн буухыг санал болгох үед ичгүүр, тайвшрал, гэмшил, амар амгалан, харуусал гээд олон янзын сэтгэл хөдлөлийг бүгдийг нэг дор мэдэрч билээ.

Нэгэнт би гэртээ очсон эхний долоо хоногоо даван гарсан тул Бурхан намайг дэмжиж байсныг мэдэж байсан. Дараа нь дахиад нэг долоо хоног, бас дахиад нэг долоо хоног өнгөрлөө. Эцэст нь би хэвэндээ буцаж орлоо. Аав маань миний хамгийн том дэмжлэг болж, намайг өөрийнхөө нөмөр нөөлөг доор авсан юм. Тэр үргэлж надтай ярьж, цагаа өнгөрүүлэхийг хүсдэг байв. Тэр "юу нь буруу болсныг" сонирхохын оронд надад ямар байгаад илүү санаа тавьдаг байсан.

Аавыг хэдэн сарын дараа хаданд авирч яваад осолдож нас барах үед Бурханд надад зориулсан төлөвлөгөө байгаа гэдгийг би шууд ойлгосон юм. Аавтайгаа амьдралынх нь сүүлийн хэдэн сарыг хамт өнгөрүүлэх боломжтой байсан маань авралын төлөвлөгөөний талаарх гэрчлэлийг минь хүчирхэгжүүлсэн билээ. Би гэртээ буцаж ирэхдээ, ирэх болсон бүх шалтгааныг ойлгоогүй ч яагаад гэдэгт гайхширан хамаг цагаа үрвэл Бурханы өдөр бүр өгдөг гайхалтай гайхамшгуудыг анзааралгүй өнгөрүүлэх болно гэдгийг мэддэг болсон.

Кристэн Ватабэ, АНУ, Огайо

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

ИХ ЭЗЭНИЙ ТААЛЛЫГ *дагах хүсэлтэй бай*

Номлолд бүх юм сайхан өнгөрч байлаа. Сэтгэлд хоногшин үлдсэн олон гайхалтай үйл явдал надад тохиолдсон. Гэвч найман сарын дараа надад эрүүл мэндийн асуудал тулгарч эхлэв. Маш их мацаг барьж, залбирсан ч намайг гэр лүү минь хугацаа дуусаагүй байхад явуулсан юм. Үүнд би ихэд сэтгэлээр унаж, бүх зүйлд өөрийгөө буруутгаж байлаа. Би судраас уншиж, байнга залбирдаг байснаа болив. Би бас номлолдоо үлдэхийн тулд чадах бүхнээ хийсэн эсэхтээ эргэлзэж байлаа.

Гэвч Их Эзэнд үнэнч хэвээр үлдэж чадах эсэхийг маань сорьж байсныг би ухааран ойлгосон. Надад хэцүү байсан ч би Түүнд итгэж, номлолын талбартаа эргэн очиж, гайхалтай туршлагыг дахин олж авсан.

Харин дараа нь эрүүл мэндийн асуудал маань дахин сэдэрч эхлэв. Гэвч энэ удаа би Тэнгэрлэг Эцэгийн таалллыг дагах илүү хүсэлтэй болсон байлаа. Тиймээс би хоёр дахь удаагаа гэртээ эргэж ирсэн юм. Хэцүү байсан ч гэлээ өөрийн туулсан бүхнээс суралцаж чадна гэдгээ би мэднэ.

Хэдийгээр би номлолдоо 24 сар үйлчлээгүй ч нэр төртэй үйлчилсэн гэдгээ мэднэ. Их Эзэнд үйлчилсэн цаг хугацаа минь надад болон миний тусалж байсан хүмүүсийн хувьд үнэ цэнтэй байсныг би мэднэ. Би Аврагчид Түүний хязгааргүй Цагаатгалын төлөө талархдаг. Тэр бидний асуудлуудыг нэг бүрчлэн мэднэ. Хэрэв бид Түүнд бүрэн итгэлээ тавих юм бол хэзээ ч ганцаараа үлдэхгүй.

Филип Хоффман, Бразил, Гоиас

ӨӨРИЙГӨӨ *сайн сайхнаар хүрээлүүл*

Би хугацаанаасаа өмнө номлолоос бууна гэж хэзээ ч бодож байгаагүй бөгөөд хүмүүстэй таарaлдахаасаа ичиж, санаа зовж байлаа. Энэ нь миний амьдралд тохиолдсон хамгийн хэцүү үеүдийн нэг байсан ч би энэ туршлагынхаа үр дүнд өсөж хөгжсөн юм. Энэ намайг илүү сайн хүн болгосон.

Би гэртээ ирснээр наманчлах үйл явцаа үргэлжлүүлсэн. Номлолын өмнө хийсэн зарим сонголт маань сайн мэдээний сургаал, зарлигтай нийцэхгүй байв. Би ичсэндээ болж мөн Сүмийн гишүүнчлэлээ хадгалж үлдэх хүсэлтэй байсан тул номлолынхоо өмнө бишоптойгоо наманчлалын үйл явцыг эхлүүлээгүй юм. Гэвч эхний хэдэн сарын дотор би үнэнч, шударгаар үйлчлэхийг хүсэж байвал гэртээ харьж, наманчлах хэрэгтэй гэдгийг мэдэрсэн.

Гэртээ ирэхэд намайг хамгийн ихээр урамшуулсан зүйлсийн тоонд сүнслэг байдлын хувьд сэтгэл сэргээм үйл ажиллагаанууд, үүнд Сүмийн цуглаан, үйлчлэлийн төслүүд мөн зохистой болсныхоо дараа ариун сүмд орох зэрэг нь орж байв. Гэвч надад хамгийн их тусалсан зүйл бол гэр бүл, найз нөхөд, тэр байтугай өмнө нь хэзээ ч уулзаж байгаагүй гээд эргэн тойрон дахь хүмүүсийн маань надад үзүүлсэн хайр, сайхан сэтгэл байсан юм.

Эцэст нь би Их Эзэний тусламж болон эргэн тойрныхныхоо Христийнхтэй адил үлгэр жишээгээр дамжуулан Флорида руу эргэн очиж, номлолоо дуусгаж чадсан. Хугацаанаасаа өмнө буусан байна уу, зүгээр л тусламж туслалцаа хэрэгтэй байна уу гэдгээс үл хамааран бид бүгдээрээ бусдад Христтэй адил хандахыг хичээх болтугай.

Кайгэн Стюарт, АНУ, Юта

"Их Эзэн амьдралдаа үйлдсэн сайн сайхны тань төлөө таныг шагнах болно" хэмээх номлолын дуудлагын захидал дээрх амлалт энэ ажлыг хийхээр шийдэж урагш гарч ирэх үед биеллээ олох болно. Анхаарал, халамж тавьснаар таны шарх эдгэж, бусдыг Христэд ирэхэд туслах зэмсэг болох болно. Эцсийн эцэст энэ л номлогчдын жинхэнэ үүрэг юм. ■

Зохиогч нь Франц улсаас ирсэн бөгөөд АНУ-ын Ютад сурдаг.

Энэ нийтлэлийн бүрэн эх дээр байгаа, хугацаанаасаа өмнө буусан номлогчдын өөр олон түүхийг liahona.lds.org эсвэл Gospel Library аппликэйшнаас олж үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. "Номлогчийн хувьд миний зорилго юу вэ?" *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлд зориулсан удирдамж* (2018), lds.org/manual/missionary.

Би волейбол тоглож, гүйж, унших их дуртай.

Хэрэв бүтэн өдөржингөө хүссэнээ хий гэвэл би далайн эрэг рүү явах байх.

Би Иллиной мужийн Чигагод төрсөн ч асрамжийн газар байхдаа Наувуд ирсэн. Би асрамжийн газар ирэхээс өмнөх амьдралаа тийм сайн санадаггүй ч амар тайван байдаггүй байснаа санадаг. Би асрамжийн газар ирээд, аюулгүй байх гэж юу болохыг мэдэрсэн. Би сайн мэдээнд дуртай. Зарим найз маань жишгүүдээ дагаагүйгээс болж өөрсдийгөө хүнд байдалд оруулсан. Зарлигуудыг дагах нь намайг аюулаас хол байлгадгийг би мэднэ.

Гэр бүлээ олох нь сайхан үйл явдал байсан. Ээж маань багшийн туслах байсан тул сургуулийн өмнөх бэлтгэл ангид маань ирдэг байв. Тэр надтай хамт тоглож, багш нарын маань нэгэнд намайг эгдүүтэй хөөрхөн хүүхэд учраас гэртээ авч явахыг хүсэж байгаагаа хэлсэн юм. Багш "Түүнийг үрчлүүлэх учраас болох байх аа" гэв. Ээж хэрхэх талаарх үйл явцыг лавлаж, намайг хоёр ахтай минь өргөж авсан. Би гэр бүлгүй байх ямар байдгийг мэдэх тул гэр бүлтэй болсон маань миний хувьд онцгой сайхан зүйл юм.

Лили С., 14 настай, АНУ, Иллиной

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

ЭНЭ ХЭСЭГТ

52 **Судал, унш, давт, залбир. Давт.**
Марио Даис Алонсо

54 **Ажлын маань хамгийн сайхан өдөр энэ байх!**
Ахлагч Жони Л.Кок

56 **Шинэ Гэрээний хичээлүүд: Төлөөлөгчид бол Христийн гэрчүүд юм. Та ч бас гэрч болж чадна!**
Хийдэр Ваит Клариж

58 **"Чи эндээс явах хэрэгтэй"**
Сэржио Рикэлмэ Сэгүра

61 **Зурагт хуудас: Итгэл алхам алхмаар ирдэг**

62 **Хайрт ахын минь захидал**
Мэрилий С.Б.Авэрэтт

64 **Сүүлчийн үг: Та Мормоны Номоос юу олох вэ?**
Ахлагч Гари И.Стивэнсон

ГЭРЭЛ ЗУРГИЙГ КРИСТИНА СМИТ

СУДАЛ, УНШ, ДАВТ, ЗАЛБИР. *Давт.*

Марио Даис Алонсо

Чилид коллежид элсэн орохын тулд их сургуулийн түвшин тогтоох шалгалт өгөх ёстой. Би инженерийн мэргэжлээр суралцахыг хүсэж байсан ба их сургууль маань миний амьдардаг газраас хол байв. Энэ нь маш үнэтэй тусаж байсан тул би шалгалтын оноогоороо тэтгэлэг авахын тулд түвшин тогтоох шалгалт дээрээ аль болох өндөр оноо авахыг зорьж байлаа.

Би хаана, юу сурахаа мөн ийн сурахын тулд юу хийх ёстой гэдгээ ч мэдэж байв. Би шалгалтдаа бэлтгэж эхлэв. Би материалаа судалж, уншиж, давтаж байсан ч сорилт шалгалт дээр шаардлагатай оноогоо авч чадахгүй л байлаа. Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч, зорилгодоо хүрэхэд туслахын тулд илүү их ухааруулан, гэгээрүүлэхийг Түүнээс гуйв. Би бүтэн жилийн турш, өдөр бүр ингэж залбирсан юм. Би сургуулийнхаа тусгай бэлтгэл ангид сууж, шалгалтад бэлтгэх хичээлүүдэд бүртгүүлэв.

Би өдөр бүр судраас суралцаж, семинарын өдрөө ганц ч өдөр алгассангүй. Би Аароны санваарын бүх үүрэг даалгавраа гүйцэтгэж, нөхцөл байдал хүнд байсан ч ням гарагт хичээлээ огтхон ч хийдэггүй байв. Би ням гараг Их Эзэний өдөр гэдгийг мэддэг байсан ба эцэг эхийнхээ заасаар уг өдрийг ариунаар сахихыг хүсдэг байлаа. Би Тэнгэрлэг Эцэгийнхээ

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АДАМ ХОУЛИНГ

Би тэтгэлэггүйгээр коллежид явах боломжгүй байв.

АМЖИЛТТАЙ СУРЧ БОЛОВСРОХОД ТАНЬ ТУСЛАХ НЬ

Сүмийн зүгээс ахлах сургуулиа төгссөний дараах давтлага сургалт эсвэл сурч боловсроход тань туслах хэд хэдэн эх сурвалжийг өгдөг:

- Тасралтгүй Боловсролын Сан зарим оронд мэргэжлийн сургалтад хамрагдахад тус болох зорилгоор ажилладаг. Та энэ талаар бишоптойгоо эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилцаж эсвэл **pef.lds.org** вэбсайтаар зочилж болно.
- BYU-Pathway Worldwide нь хямд үнээр онлайнаар дээд боловсрол олгодог. Хүмүүст их сургуульд сурч эхлэх эсвэл эргэн ирж суралцахад нь тусалдаг PathwayConnect гэх нэг жилийн онлайн хөтөлбөрөөс оюутнууд эхэлдэг. Оюутнууд PathwayConnect хөтөлбөрийг дуусгасныхаа дараа ажиллахад бэлэн болсныг баталсан гэрчилгээгээ жил хүрэхгүй хугацаанд аваад, цааш нь зэрэг горилохоор бол үргэлжлүүлэн бага төлбөрөөр суралцах боломжтой. **Byupathway.lds.org** вэбсайтаар зочилно уу.
- Англи хэл сурах нь илүү сайн ажил олох боломжийг танд нээж өгдөг. EnglishConnect нь сайн мэдээнд төвлөрсөн орчинд сүнслэг болон материаллаг байдлын хувьд бие даасан байдлаа сайжруулахад хувь хүмүүст тусалдаг, Сүмээс англи хэл сурахад зориулан гаргасан хөтөлбөр юм. **Englishconnect.lds.org** вэбсайтаар зочилно уу.
- Сүмийн сурч боловсроход чиглэгдсэн бие даах чадвар хөгжүүлэх сургалтыг "Илүү сайн ажлын төлөө сурч боловсрох нь" гэж нэрлэдэг. Энэ танай гадас эсвэл дүүрэгт зохион байгуулагддаг 12 долоо хоногийн курс хичээл юм. Гарын авлагыг Self-Reliance хэсгийн доор байрлах Gospel Library-гаас эсвэл **lds.org/go/71857**-аас орж үзнэ үү.



БУСДАД ҮЙЛЧЛЭХЭД ТАНД БОЛОВСРОЛ ТУСАЛНА

"Миний өгөх зөвлөгөө . . . бол таны байгаа газар, сонирхол, боломж тань ямар байхаас үл хамааран боловсролоо үргэлжлүүл. Та гэр бүл, олон нийтэд хэрхэн хамгийн сайнаараа үйлчилж болохоо тодорхойлж, сайтар бэлд."

President Russell M. Nelson, "Education: A Religious Responsibility" (Brigham Young University–Idaho devotional, Jan. 26, 2010).

надад зориулсан адислалуудыг, ялангуяа надад хамгийн хэрэгтэй байгаа үед нь алдахыг хүсэхгүй байв. Энэ бүхнийг хийж байсан ч би сорилт шалгалт дээр шаардлагатай оноогоо авч чадахгүй л байв.

Би эцэг эхтэйгээ хамт залбирч, мацаг барьсан ба аав надад адислал өгсөн. Энэхүү сүнслэг болон бусад бэлтгэлийг хангаснаар би шалгалтаа өгөв. Би өөрт хэрэгтэй оноогоо авахын зэрэгцээ математикийн хэсэгт хамгийн өндөр боломжит онооны нэгийг авч, тавьсан зорилгоо давуулан биелүүлсэн юм. Би тэтгэлэг болон хэрэгтэй боломжуудаа авч, сонгосон их сургуульдаа суралцах боломжтой болсон.

Хэрэв би чадах бүхнээ хийж, сүнслэг үүрэг хариуцлагаа нэн тэргүүнд тавих юм бол Тэнгэрлэг Эцэг намайг адисална гэдгийг бүр багаасаа мэддэг байв. Аливаа зүйлс үргэлж миний хүссэнээр болохгүй байж болох ч Бурхан биднийг харж хандах болно. Зөвхөн Түүний тусламжийг авах үед бүх зүйл боломжтой гэдгийг би мэднэ. ■

Зохиогч нь Чилийн Каутин мужид амьдардаг.

Далын
Ахлагч
Жони Л.Кок

Ажлын маань хамгийн

Та ажлыг хайрлаж, үнэлж сурснаар баяр баясгалангийн агуу эх булгийг олох болно.

Би хэдэн жилийн өмнө ажиллаж байсан компаниа төлөөлөн Английн Кэмбрижийн Их Сургуулийн Чөрчилл коллежийн танхимд жил бүр зохион байгуулагддаг нэгэн хуралд оролцож байлаа. Тэр үед надад компанийнхаа олон улсын салбарыг хариуцсан ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал хоёроос тухайн жил багаараа хийж гүйцэтгэсэн ажлыг маань үнэлсэн шагналыг тэдний өмнөөс гардан авах боломж тохиосон юм.

Дэлхийн өнцөг булан бүрээс 80000 ажилтан, албан хаагчдыг төлөөлж ирсэн компанийн удирдагчид багийн маань амжилтыг сайшаан алга ташихад надад "Ажлын маань хамгийн сайхан өдөр энэ байх" гэсэн бодол орж ирэв. Тэр үед уур амьсгал үнэхээр сэтгэл хөдлөм байсан.

Хуваасан талх

Харин дараа нь 40 орчим жилийн тэртээ ажилд анх орсон өдөр минь санаанд орж ирж билээ. Аав маань талхны цех ажиллуулдаг байсан ба барьсан талхаа Бразилийн өмнөд хэсэгт байрлах хотынхоо жижиг захуудаар тараадаг байв. Багадаа би аавaасаа ажилдаа дагуулан авч явахыг байнга шалдаг байж билээ. Нэг өдөр тэр зөвшөөрөв!

Ээж надад жижиг цагаан хормогч, талхчны малгай оёж өгч, аав бид хоёр талхны цех рүүгээ явлаа. Бид зуурмагаа хамт зуурч, бэлтгээд, талхаа гараараа хэвэнд оруулан, тоосгон пийшиндээ хийв. Бид талхаа жигнэж дуусаад, урт модон хусуураар болгоомжтой гэгч гаргаж авч билээ. Бид хэдхэн секунд хүлээгээд, бүлээнээрээ байгаа талхаа хувааж идсэн. Ямар сайхан амттай байсан гээч!

Эргэн харахад, Кэмбрижид шагнал авсан явдал маань ажил дээрх хоёр дахь хамгийн сайхан өдөр болж таарав. Харин хамгийн сайхан, аз жаргалтай өдөр нь ямар ч үзэгч, нижигнэсэн алга ташилт байхгүй жижигхэн талхны цехэд, арай энгийн нөхцөлд болж өнгөрсөн байлаа. Тэнд аав, бид хоёр хоёулхнаа байсан. Аав тэр өдөр надад ажлыг хэрхэн хайрлаж, үнэлэхийг зааж өгсөн ба өөрийн гараар аливаа зүйлийг бүтээхийн баяр баясгаланг мэдрүүлэн тусалсан. Шаргуу ажиллаж хөдөлмөрлөх нь бие махбод, сэтгэл санааны аль алинд нь хэрэгтэй юм байна гэдгийг би тэгэхэд ойлгож билээ.

Би ээжийнхээ хийж өгсөн цагаан хормогч, талхчны малгайг мөн аавтайгаа хамт хийсэн талхыг хэзээ ч мартахгүй.

Ажил хөдөлмөр бол адислал мөн

Их Эзэн Адам, Ева хоёрт "Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

сайхан өдөр энэ байх!

иднэ” (Эхлэл 3:19) гэж хэлсэн нь тэднийг шийтгэж байсан мэт сонсогддог. Тэр үнэндээ бие дааж, өөрийн хүсэл, хэрэгцээг хангахын баяр баясгалан, сэтгэл ханамжийг мэдрэх боломжийг тэдэнд олгосон юм.

Бидний ихэнх нь ажлыг өөрсдийн болон гэр бүлийнхээ материаллаг хэрэгцээг хангах эсвэл чамин албан тушаалын нэр зүүж нийгэмд байр сууриа эзлэх арга хэрэгсэл хэмээн хардаг. Гэвч үүнээс ч чухал нэг зүйл бол Бурхан биднийг үүрэг даалгавраа биелүүлж, ямар нэг шинэ зүйлийг хийж бүтээж, өмнөх зүйлийг шинэчлэн, сайжруулж, амьдарч буй дэлхийдээ хувь нэмэр оруулан сэтгэл хангалуун байлгахын тулд биднээс ажиллаж хөдөлмөрлөхийг хүсдэг.

Сүнслэг байдлын хувьд ярих юм бол сайн мэдээнд төвлөрсөн амьдралд ажиллаж хөдөлмөрлөх ордог. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон: “Энэ ажил олон давтагддаг ч бай, муухай ч бай, ямар ч талархлыг хүртдэггүй ч бай, өргөл болгосон амьдрал үргэлж юмыг сайжруулах, эмхэлж цэгцлэх, дэмжин туслах, өөд нь татах, тохинуулах мөн тэмүүлэх хүчээр дүүрэн байдаг”[1] хэмээн хэлсэн.

Хүүхэд байхад тань танаас “Чи том болоод хэн болох вэ?” гэж асуудаг байсан байх. Харин өсвөр насанд тань энэ нь “Чи коллежид ямар мэргэжлээр сурах гэж байна вэ?” гэсэн асуултаар солигдох нь гарцаагүй.

Хүсэл тэмүүлэл, хүндэтгэл ба зорилго

Чи ямар ч мэргэжил сонгож, ямар ч ажил хийллээ гэсэн ажлаа хүсэл тэмүүлэлтэй, хүндлэл, зорилго тээн хийхийг эрэлхийлээрэй. Чи шаргуу ажиллан, ямагт хамгийн сайн үр дүн гаргахыг хичээх хэрэгтэй. Ажлаа ийм хандлагатай хийх нь таныг материаллаг болон сэтгэл санааны мөн сүнслэг байдлын хувьд хөл дээрээ найдвартай босоход тусална. Ажиллах боломж нь Их Эзэнээс ирж буй адислал юм. Та ажилдаа талархалтай хандаж, хайрлаж сурснаар бие дааснаас ирэх аз жаргал, зорилгыг хүлээн авах болно.

Кэмбрижийн Их Сургууль дээрх оролцогчдын алга ташилт, урмын үгс одоо хүртэл миний чихэнд сонсогддог ч аавтайгаа талхны цехэд өнгөрүүлсэн тэр өдрийн дурсамж, талхаа зуухнаас дөнгөж гаргах үеийн талхны үнэрийг илүү эрхэмлэн нандигнадаг. ■

ЭШЛЭЛ

1. Д.Тодд Кристоффэрсон, “Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,” *2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 17.

Төлөөлөгчид бол Христийн гэрчүүд юм.

Та ч бас гэрч болж чадна!

Хийдэр Ваит Клариж
Сүмийн сэтгүүлүүд

Хэрхэн Есүс Христийн гэрч болж болох вэ?

- “Итгэх хүсэлтэй” бай (Алма 32:27)[4].
- Судраас Аврагчийн тухай судал.
- Залбирч, Христ бол таны Аврагч мөн гэдгийг баталж өгөхийг Ариун Сүнснээс гуй.
- Шинэ Гэрээг судалж, төлөөлөгчид хэззэ гэрч болдгийг олж тэмдэглэ.

Таныг найзтайгаа сургууль дээр үдийн хоол идэж байгаагаар төсөөлье. Найзыг тань ууттай чихэр задлах гэж байтал нэг хүн ирээд, өөрийнхөө чихрийг хулгайлсан гэж гүтгэн, “эргүүлж өгөхийг” шаарджээ. Та найзыгаа чихэр худалдаж авахад нь хамт байсан болохоор хэдий сандарч тэвдэж байсан ч гэсэн уг гүтгэсэн хүнд найзыгаа хулгайлаагүй гэдгийг хэлэв.

Онцгой гэрч

Үүний адил үнэний төлөө зогсохыг “гэрч болох” гэж хэлдэг. Энэ жишээн дээр, та найзынхаа сайн зан чанарыг гэрчилнэ. Та найзынхаа гэрч болж болохтой яг адил Бурхан бошиглогч, төлөөлөгчдийг Өөрийн Хүү, Есүс Христийн онцгой гэрчүүд болгон дуудсан. Төлөөлөгчид зааж, гэрчилж, “бүх дэлхийд Христийн нэрний тусгай гэрчүүд болж үйлчлэхээр” (Сургаал ба Гэрээ 107:23) “тодорхой эрх мэдэл, үүрэг хариуцлагатайгаар илгээгддэг.”[1]

Төлөөлөгчид Христийг амилсны дараахан Түүний гэрчүүд байхаар дуудагдсан (Үйлс 1:8-ыг үзнэ үү). Та Шинэ Гэрээний Үйлс номыг судалж байхдаа, төлөөлөгчдийн Есүс Христ бол Бурханы Хүү болохыг гэрчилсэн олон жишээг олж уншиж болно (Үйлс 2:36; 5:27–32; 10:36–44-ийг үзнэ үү). Өнөөдөр төлөөлөгчдөд тусгай гэрч байх энэ дуудлага байгаа хэвээрээ бөгөөд та дурын Ерөнхий чуулганаас тэднийг Христийн тухай хэрхэн гэрчилж байгааг мэдэж болно.

Ариун Сүнс Христийг гэрчилдэг

Шинэ Гэрээний зарим төлөөлөгч Христийг дэлхийд байхад Түүнтэй хамт байсан ба Түүнийг тэнгэрт дээшлэхийг харсан (Үйлс 1:9–11-ийг үзнэ үү) бөгөөд өнөө үеийн төлөөлөгчид Христийг харсан байж болох ч[2] хэн нэгэн Есүсийн гэрч болохын тулд заавал нүдээр харах шаардлагагүй. Ерөнхийлөгч Жозеф Филдинг Смит (1876–1972) “[Ариун Сүнс] нь Есүс бол Христ бөгөөд түүний сайн мэдээ үнэн гэдгийг хүмүүн мэдэж авах цорын ганц арга зам юм”[3] хэмээн хэлсэн. Энэ нь төлөөлөгчид Христийг харсан байж болох ч Ариун Сүнс тэдэнд хэлсэн учраас тэд Түүнийг Аврагч гэдгийг мэддэг болсон гэсэн үг юм.

Та ч бас гэрч байж чадна

Хамгийн гайхалтай нь танд ч гэсэн Ариун Сүнсээр дамжуулан Есүс Христ бол таны Аврагч гэдгийг мэдэж авах амлалт өгөгдсөн (Сургаал ба Гэрээ 46:13-ыг үзнэ үү). Энэ нь зөвхөн төлөөлөгчдийн мэддэг зүйл биш юм! Хэдийгээр та Христийн тусгай гэрч байхаар дуудагдаагүй ч Христийн талаар гэрчлэлтэй болохыг эрэлхийлж мөн амьдралдаа уулзах хүмүүст Түүний гэрч болж чадна. Та Аврагчийн Петрт өгсөн “Чи нэгэн цагт дахин эргэж, ах, [эгчээ] батжуул” (Лук 22:32) гэсэн зарлигийг дагаж чадна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Gordon B. Hinckley, “Converts and Young Men,” *Ensign,* May 1984, 50.
2. Бойд К.Пакэр, “Гэрч,” *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган,*; мөн Lorenzo Snow, “A Visit from the Savior,” *Liahona,* Sept. 2015, 80-ыг үзнэ үү.
3. Joseph Fielding Smith, *Answers to Gospel Questions,* comp. Joseph Fielding Smith Jr., 5 vols. (1957–66), 3:31.
4. Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” *2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* х. 108–111-ээс үзнэ үү.

ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД СТОКЭР



"ЧИ ЭНДЭЭС ЯВАХ ХЭРЭГТЭЙ"

Гэрийнхэнтэйгээ Чилийн хойд хэсэгт нүүж очихоос эмээж байсан ч энэ цөл бидний амлагдсан газар болж хувирсан юм.

ЧИЛИЙН КОНСЕПСИОН ХОТЫН ЗУРАГ, GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Сэржио Рикэлмэ Сэгүра

Мормоны Номоос Нифай хэрхэн зөнч эцгээ үргэлж дэмждэг байсан тухай би олж уншихдаа Сүмийн ихэнх өсвөр үеийнхэн Нифай шиг байдаг байх гэж бодсон. Гэвч гэрийнхэн маань цөл рүү нүүх шийдвэр гаргахад би Лемен, Лемуел хоёртой тун адилхан хандсан юм. Би гэрээсээ явахыг хүсэхгүй байв.

Нифай болон түүний ах нар шиг би “буянт сайн эцэг эхээс мэндэлсэн” (1 Нифай 1:1). Тэд хоёулаа өсвөр насандаа сүмд нэгдсэн ба аавыг номлолд үйлчилж байхад ээж минь түүнийг хүлээсэн юм. Тэд Сүмийн идэвхтэй, хөдөлмөрч гишүүд байв.

Намайг ахлах сургуульд байхад бидний амьдарч байсан Чилийн Консепсион бүс нутаг хавиар эдийн засгийн уналтад орсон юм. Ажлын байр хомсдож, аав маань ажил олж чадахгүй байлаа. Эцэст нь тэр хотоос гадуур ажил хайж эхлэв.

Тэр ажил хайсаар Чилийн уул уурхайн бүс нутаг болох Калама хотын хойд хэсэгт хүрчээ. Тэр барилгын инженер байсан ба тэнд нэг сайн ажил олов. Гэвч тэр тэнд ганцаараа, гэрээсээ хол амьдрахаас аргагүй болсон юм. Бид аавынхаа царайг 32 цагийн турш автобусаар явж байж гэртээ ирсэн үед нь л хардаг байлаа.

Хэдэн жилийн турш аавыгаа жилд ердөө хоёр, гуравхан удаа хардаг болсны дараа ээж өөрчлөлт хийх цаг болсон гэж үзэв. Эцэг эх маань гэр бүлээ аваад хойд зүг рүү нүүх шийдвэр гаргасан.

Бид аавтайгаа байх хэрэгтэй

Дүү маань шилжихэд ямар ч асуудалгүй байв. Коллежид сурч байсан эгч маань надад сайн үлгэр жишээ үзүүлж, “Би сургуулиа хойшлуулж болно. Бид аавтайгаа байх хэрэгтэй” гэв.

Надаас бусад нь бүгд л нүүх шийдвэрийг дэмжиж байлаа. Би ч бас аавтайгаа хамт байхыг хүсэж байсан ч өөрчлөлт хийж, хувийн золиослол гаргахаас татгалзсан юм. Би найз нөхөдтэй бөгөөд эргэн тойрноо мэддэг, амьдралынхаа хэв маягт дассан байсан ба Консепсионд коллежид элсэн орохыг хүсэж байв. Бид явах шаардлагагүй гэж би ээжийгээ хамаг чадлаараа ятгалаа.

Эцэст нь ээж “Хүү минь, аав чинь ганцаараа байгаа. Тэр бидэнтэй хамт байхыг хүсэж байгаа. Чи ойлгодог ч болоосой, гэвч чи зөвхөн хувиа бодоод байна шүү дээ” гээд “Тэнд ч гэсэн бидэнд боломж гарна” гэж намайг урамшуулав.

Миний толгойд нэг л багтаж өгөхгүй байсан ч зүрх сэтгэлдээ түүний зөв гэдгийг би мэдэж байлаа. Тухайн үед надад хүчтэй гэрчлэл байгаагүй ч би гэр бүлтэйгээ хамт явах талаар залбирч үзэхээр шийдэж билээ. “Чи эндээс явах хэрэгтэй” гэсэн тодорхой хариулт надад ирэв. Надад гунигтай байсан ч би эцэг эхдээ явна гэдгээ хэлэв.

Сэржио найзуудтайгаа институт дээр сууж байгаа нь

Модод хаана байна вэ?

Консепсион бол ногоон, мод ихтэй газар юм. Тэнд жилд 50 инч (127 см) орчим бороо ордог байхад бидний нүүх гэж байсан Калама хотын ойролцоо Антофагастад ердөө 0.1 инч (0.25 см) бороо ордог байв.

Намайг хамгийн ихээр гайхшируулсан зүйл бол үнэндээ тэнд очих аялал байсан юм. Биднийг хойд зүгийг чиглэн автобусаар явж байхад, эргэн тойронд нов ногоон байснаа харлан хувирахыг харах нь шаналантай байв. "Модод хаана байна аа?" гэж би бодож байлаа. Хөдөө газрын үнээнүүд хаачив? Нүдэнд зөвхөн шороо, хад чулуу, толгод харагдаж байв.

Мэдээж, Чилийн хойд хэсэг элсэн цөл газар байхад би юу хүсэн хүлээсэн юм бол? Лихайн гэр бүлийг өвийн нутгаа орхин, цөл рүү авах үед Лемен, Лемүел хоёрт ямар санагдаж байсныг би санасан.

Биднийг Антофагастад хүрч ирэхэд надад үнэхээр аймаар санагдаж байв. Хэрэв би найз нөхөдтэй болохгүй бол яах вэ? Хэрэв би энэ газарт дасахгүй бол яана аа? Ирээдүйн итгэл найдвар минь биелэхгүй бол яах вэ?

Эцэст нь санаа зовох шаардлагагүй байсныг би ойлгосон. Биднийг боломж бололцоо, ялангуяа сүнслэг боломжууд хүлээж байгаа гэж хэлсэн ээжийн зөв байлаа.

Биднийг нүүхээс өмнө сайн мэдээ надад чухал санагддаггүй байв. Их Эзэн миний амьдралд чухал байр ээлдэггүй байсан. Гэвч Антофагастад сайн мэдээний сайн сайхан талыг олж харахад тусалсан хүмүүс амьдралд маань орж ирсэн юм. Би санваарын онцгой удирдагчдаас тусламж авч, одоо ч үнэ цэнтэй хэвээр байгаа найз нөхөдтэй болж чадсан. Миний сүнслэг амьдрал бүрмөсөн өөрчлөгдсөн юм.

Би ээжийгээ сонссондоо талархдаг. Би бас Их Эзэн миний залбиралд хариулсанд талархдаг. Эцэст нь гэрийнхэнтэйгээ хамт хойд зүг рүү нүүх зориг гаргасандаа би талархдаг.

Би энэ цөлд л өнөөдрийн намайг бий болгон тусалсан өөрчлөлтүүдийг хийсэн. Энд л би сайн мэдээг хүлээн авч, номлолд үйлчилж, ариун сүмд гэрлэж мөн Их Эзэнд амьдралаа зориулах амлалтуудыг өгсөн. Би энд л Лемен, Лемүел хоёр шиг болохгүй байхаар шийдсэн юм.

Манай гэр бүлийн болон миний хувьд цөл бидний амлагдсан нутаг болж хувирсан билээ. ■

Зохиогч нь Чилийн Антофагастад амьдардаг.

ИТГЭЛ

АЛХАМ АЛХМААР ИРДЭГ

"Иймийн тул, сайныг үйлдэхэд шантрамтгай бүү бай, учир нь та нар агуу ажлын суурийг тавьж байна."

Сургаал ба Гэрээ 64:33

МАДАГАСКАР ДАХЬ НОМЛОГЧДЫН ГЭРЭЛ ЗУРГИЙГ КОДИ БЭЛЛ АВАВ

ELDER GARY STEVE
Dear Merilee
well you have got the big
you. I guess when you get
already be past. I can't be
16 years old. It seems
years ago when you
red cowboy hat & pra
only 3½ or so, but
Stay sweet & pure
one know that the
actions speak loud.
you do fit your nam
of Humor. HAPPY
Love ya
Always
Gary

Хайрт ахын минь ЗАХИДАЛ

Том ах маань номлолд үйлчилж байсан тул миний 16 насны төрсөн өдрөөр байхгүй байж таарав. Гэвч түүний надад өгсөн зөвлөгөө миний үүрд нандигнаж явдаг бэлэг болсон юм.

Мэрилий С.Б.Авэрэтт

Ричард М.Ромнигийн өгүүлснээр

Арван зургаан нас! Амьдралын ямар чухал мөч вэ! “Хэн ч үүнийг ганцаараа туулах шаардлагагүй шүү дээ” гэсэн бодол надад төрлөө.

Ухаалаг эцэг эх маань сайхан сэтгэлтэй хүмүүс байсан ба надад үргэлж оновчтой зөвлөгөө өгдөг байсан юм. Том эгч маань дөнгөж гэрлээд, мужаас нүүсэн байсан ба миний дүү 11 настныхаа асуудалтай тэмцэж байв. Би гайхалтай найзуудтай байсан бөгөөд Сүмийн удирдагчид маань надад санаа тавьдгийг мэддэг байлаа.

Гэсэн ч миний том ах Гари цорын ганц итгэлт анд минь байв. Би өсвөр насандаа бүхий л зүйлд түүнийг дагадаг байсан. “Түүнтэй ярилцах болгонд юм илүү утга учиртай болдог байсансан. Тэр яг одоо энд байсан ч болоосой” гэж би өөртөө хэлэв.

Гэвч тэр байхгүй байлаа. Тэр алс холын Япон оронд бүрэн цагийн номлолдоо үйлчилж байв.

Гарийг санаж байсан ч би төрсөн өдрөө хөгжилтэй сайхан тэмдэглэсэн юм. Ээж төрсөн өдрийн уламжлал болсон өглөөний ундыг надад зориулан хийсэн ба би хичээлдээ явахаасаа өмнө хэдэн бэлэг хүлээн авсан. Тэр орой би гэрийнхэнтэйгээ хамт гарч, пицца идэж, сүүлд нь төрсөн өдрийн бялуу идэв. Би болзоонд явах, жолоо барих мөн 16 настангуудын хийдэг сэтгэл догдлуулам зүйлсийг хийхийг мөрөөдөж ч үзлээ.



Гэсэн ч тэр өдөр авсан хамгийн сайхан бэлэг бол шуудангаар ирсэн захидал байсан юм. Гари миний онцгой чухал өдрийг мартаагүй байв! Энэ явдал э-мэйл гэсэн зүйл сураг ч үгүй үед болсон тул захидал Японоос АНУ-ын Ютагийн Каш Валлид иртлээ урт удаан хугацаа туулж ирсэн ба яг миний төрсөн өдрөөр ирсэн нь гайхалтай тохиолдол байлаа! Захидлыг гараараа бичсэн байсан тул унших үед ах минь дэргэд байгаа мэт санагдаж байв.

“Хүндэт Мэрилий:

Удахгүй маш чухал төрсөн өдөр чинь болно, тийм үү? Энэ захидлыг авах үед төрсөн өдөр чинь аль хэдийн өнгөрчихсөн байна байх даа. Чамайг 16 хүрч байгаад би нэг л итгэж өгөхгүй байна! Жижигхэн улаан ковбой малгайгаа өмсөөд явдаг байсан цаг саяхан мэт санагдаж байна.

Элдэг, цэвэр ариун байж, Сүм чиний хувьд ямар нандин гэдгийг үргэлж хүмүүст хэлж байгаарай. Тэгвэл чи цаг нь болоход шийдвэр гаргах шаардлагатай хүнд хэцүү нөхцөлд орохгүй. Жишээлбэл, ахлах сургуульд хүн бүр намайг согтууруулах ундаа уух юм уу тамхи татах огтхон ч сонирхолгүй гэдгийг мэддэг байсан тул хэн ч иймэрхүү зүйл болдог үдэшлэгт урьж байгаагүй. Найзууд маань ч намайг ийм зүйл хийдэггүйг мэддэг байсан. . . .

Хэрэв чи хүмүүст өөрийнхөө жишгийг таниулах юм бол өөртэй чинь адилхан жишигтэй хүмүүс л чамайг тойрон хүрээлнэ. Чамайг хүн бүрд *зарла* гээгүй л дээ. Зүгээр л үйлдлүүд чинь үг хэлээгүй байсан ч бусдад харуулах болно. Чиний сүнс үнэхээр гайхалтай. Чи яг л нэрэндээ тохирсон. Чи бас гайхалтай хошин шогийн мэдрэмжтэй шүү. 16 насны төрсөн өдрийн мэнд хүргэе!” гэсэн байлаа. Хамгийн сүүлийн өгүүлбэрээ тэр улаанаар доогуур нь зурсан байв. Үнэнээс илүү сайхан төрсөн өдрийн бэлэг байсангүй. Би захидлыг нь түүнийг Японоос гэртээ эргэн иртэл, нүүр тулан ярих боломжтой болтлоо ахин дахин уншиж билээ.

Энэ захидлыг авснаас хойш олон жил өнгөрсөн ч би өнөөг хүртэл хадгалсаар. Тэр үеэс хойш олон зүйл өөрчлөгдсөн ч ахыгаа хайрлах хайр минь хэвээр үлдсэн. Өнөөдөр би түүнийг зөвхөн ах бас найз гэдгээр нь бус, Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Гари И.Стивэнсон хэмээн дэмжин баталдаг. Христийн онцгой гэрчийн хувьд бүх дэлхийд өгдөг зөвлөгөө нь яг л миний 16 насны төрсөн өдрөөр түүний илгээсэн захидал шиг миний амьдралд хүч нэмдэг юм. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ГЭРЭЛ ЗУРГУУДЫГ ЗОХИОГЧООС НЬ АВСАН БОЛНО; ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД СТОКЭР

Та Мормоны Номоос юу олох вэ?

Ахлагч Гари И.Стивэнсон
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

Та Мормоны Номыг унших цаг болон нам гүм газрыг олсноор хариулт олон, удирдамж хүлээн авч, Мормоны Номын болон Есүс Христийн талаарх өөрсдийн гэсэн гэрчлэлтэй болж байгаагаа харж байна.

Та нар энэхүү нандин номын хуудаснуудыг эргүүлэн уншихдаа өөрсдийн хайрт Аврагч, Их Эзэн Есүс Христ бараг хуудас бүрд гарахыг олж мэднэ. Түүний нэрийг аль нэг хэлбэрээр дунджаар 1,7 шүлэг тутамд дурдсан байдаг.[1] Христ Өөрөө хүртэл үүний үнэнийг хожмын өдрүүдэд "та нарын Их Эзэн Мөн чиний Бурхан амьдын адил энэ нь үнэн" (Сургаал ба Гэрээ 17:6) хэмээн гэрчилсэн.

Их Эзэний бошиглогч Моронайгаар дамжуулан та нарын хүн нэг бүрд болон Мормоны Номыг унших хүн бүрд зориулан өгсөн урилга, амлалтад би талархдаг. "Мөн та нар эдгээр зүйлийг Мормоны Номыг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Есүс Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулъя би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно" (Моронай 10:4 ба 3, 5-р шүлгийг үзнэ үү).

Мормоны Номоос олох үнэн та нарыг өргөн дэмжиж мөн зоригжуулах болно. Эдгээр нь та нарын итгэлийг хүчирхэгжүүлж, бодгалийг тань гэрэлтүүлж, та нарын ойлгож чадахаас хавьгүй илүүгээр та нарыг ирээдүйд бэлтгэх болно.

Та нар энэ номын хуудаснуудаас Бурханы хязгааргүй их хайр, санаанд багтамгүй ач ивээлийг олох болно. Үүн дээрх сургаалуудыг дагахын хэрээр та нарын аз жаргал болон ойлголт тэлж, мөнх бус амьдралын олон бэрхшээлийн талаарх асуултуудын хариулт тайлагдах болно. Та нар энэхүү номд хандсанаар Их Эзэнд хандах болно. ■

2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛ

1. Susan Easton Black, *Finding Christ through the Book of Mormon* (1987), 16–18-ыг үзнэ үү.

ХОСЫН БОЛОН МОГОЙНЫ МӨН ЯПОНЫ БАРИЛГЫН БОЛОН ДАСГАЛ ХИЙЖ БУЙ ХҮМҮҮСИЙН ШИГТГЭЭ ЗУРГУУДЫГ АНДРЬЮ РОБЭРТС

Дөрвөн хүүтэй.

1955 оны 8-р сарын 6-нд
Ютагийн Кэйч Вэллийд
төрж, өссөн.

Амьдралынхаа арав гаруй жилийг
Азид
өнгөрөөсөн.

Ахлагч

ГАРИ И.СТИВЭНСОН

1979 оны 4-р сард
Лиза Жийн Хайли-
тай Айдоха Фоллс ариун сүмд гэрлэсэн.

Юта Мужийн Их Сургуулийг
бизнесийн удирдлагаар
бакалавр зэрэгтэй төгссөн.

2015 оны 10-р сард
төлөөлөгчөөр дуудагдсан.

Эхнэрээ
“амьдралын минь нар” гэж үздэг.

Тэр залуу эр байхдаа аавтайгаа хамт тойргийнхоо
бэлэвсэн эмэгтэйчүүд
дээр айлчлан очиж, үйлчилдэг байв.

Арван хоёрын
чуулгад дуудагдсан
нь түүнийг сандаргасан гэж тэр хэлсэн.

Дасгалын тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг компанийг хэдэн хүнтэй
хамтран байгуулж,
2008 он хүртэл тэндээ ерөнхийлөгч болон үйл ажиллагаа хариуцсан ажилтнаар ажиллаж байсан.

Японы Фүкүока номлолд
залуу номлогчоор дуудагдсан.

Арван нэгтэй байхдаа хоржигнуурт могойг санамсаргүй сэрээхээс **аав нь түүнийг** *сэргийлжээ.*

Цана,
сноубордоор гулгах, явган аялах дуртай.

2004–2007 онд
Японы Нагояа Номлолын ерөнхийлөгчөөр
үйлчилсэн.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

ТА ХУГАЦААНААСАА ӨМНӨ НОМЛОЛООС БУУЖ, ГЭРТЭЭ БУЦАЖ ИРСЭН ҮҮ?

Та ямар ч шалтгаанаар буцаж ирсэн бай, сайн мэдээний адислалуудаас үргэлжлүүлэн хүртэж болно.

42

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

ТА ЕСҮС ХРИСТИЙН ГЭРЧ БОЛНО

56

ХУВИЙН ИЛЧЛЭЛТ

НИФАЙН ЖИШЭЭГ ДАГАХ НЬ

58

ХҮҮХДҮҮДЭД ЗААХ НЬ

ХРИСТИЙГ ДАГАНА ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН УТГАТАЙ ВЭ?

H12

MONGOLIAN
4 02186 07363 0

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

2019 оны 7-р сар

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргадаг *Лиахона* сэтгүүлийн хүүхдэд зориулсан хэсэг

Найз



Чи хэрхэн
анхдагч байдаг вэ?

Н7, Н10 хуудаснуудыг үзнэ үү.

Тэргүүн
Зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх
**Ерөнхийлөгч
Даллин Х.Өүкс**

Сайн мэдээг хуваалцах нь

Аврагч, Есүс Христ Өөрийн шавь нарт сайн мэдээг дэлхий дээрх хүн бүртэй хуваалцахыг тушаасан. Тэр

"Бүх ертөнцөөр явж, сайн мэдээг хамаг бүхэлд тунхаглагтун" (Марк 16:15) хэмээн хэлсэн.

Сайн мэдээг бүх дэлхийд хүргэхэд Сүмийн гишүүн бүрийн тусламж бидэнд хэрэгтэй байна.

Таны тусалж болох зарим арга замыг оруулав. Үүнд:

1. Есүсийн заасны дагуу хүн бүрийг ах, эгч шигээ **хайрла**.
2. **Зарлигуудыг дага,** тэгвэл та сайн үлгэр жишээ үзүүлж чадна.
3. Сайн мэдээг олж сонсоход бэлэн нэгнийг болон тэдэнтэй хэрхэн сайн мэдээг хуваалцаж болохоо мэдэхийн тулд **залбир.**
4. Есүс Христийн тухай илүү ихийг сурч мэдэхэд **бусдад тусал.**

Номлолын ажил нь бусдыг хайрлаж мөн туслах хандлагатай байхыг хэлнэ. Бусад хүн хэрхэн хандаж байгаагаас үл хамааран, хэрэв та сайн мэдээг хайраар хуваалцаж чадвал амжилттай номлогч байна. ●

"Сэргээгдсэн сайн мэдээг хуваалцах нь," 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулганаас *тохируулан авав.*

Хайраар хуваалц

Та өнөөдөр хайраа хэрхэн харуулж болох вэ? Зураг болгоныг ерөнхийлөгч Өуксийн захиасын дугаартай тохируулна уу.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РЭБЭККА СОРК

ФИЛИПТЭЙ
хамт залбирсан нь



Шөрли Эспада-Ричи
(Бодит түүхээс сэдэвлэв)

"Ямагт залбирагтун" (Сургаал ба Гэрээ 19:38).

Жозеф Филипийнд анх удаа ирээд байв. Тэд картон цаасаар сансрын хөлөг хийж цагийг сайхан өнгөрүүлсэн байлаа. Тэд бүр онгоцон дээрээ янзын гоё галын дөл зурж, өнгөөр будав. Филипийн ээж тэднийг оройн хоолонд дуудахад Жозеф Филипийг даган гал тогооны өрөөнд орлоо.

"Би ерөөл өргөе" гэж Филипийн аав хэллээ.

Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж Жозеф гайхан бодов. Тэр Филипийг болон түүний гэрийнхнийг духан дээрээ, дараа нь цээжнийхээ дунд, тэгээд зүүн, баруун тал руугаа ээлжлэн гараараа хүрч байгааг анзаарлаа. Жозеф хэнийг ч ийн хийж байгааг өмнө нь харж байсангүй.

Филип гараа сунгав. Жозеф эргэн тойрноо хараад, Филипийн гэрийнхэн гараа сунган, толгойгоо бөхийлгөсөн байгааг харлаа. *Тэд залбирах гэж байгаа юм болов уу? "Ерөөл өргөх" гэдэг нь үүнийг хэлсэн юм болов уу?* гэж Жозеф гайхав.

"Ерөөл өргөх" гэдэг нь юу гэсэн үг вэ?

Жозэф Филипийг гомдоохыг хүсээгүй тул түүний гараас барилаа. Филипийн аав Жозефын нөгөө гараас бариад залбирч эхлэв.

"Ай Эзэн, биднийг адисална уу . . ."

Филип болон түүний гэрийнхэн суухаасаа өмнө өмнөх шигээ дух, цээжин дээрээ гараа хүргэв.

Жозефыг гэртээ ирэхэд ээж нь түүнээс өдрийг хэрхэн өнгөрүүлснийг асуулаа.

"Чи цагийг сайхан өнгөрүүлсэн үү?" гэж ээж нь асуув.

"Тийм ээ" гэж Жозеф тайвнаар хариуллаа. Тэр цагийг сайхан *өнгөрүүлсэн* байв. Сансрын хөлөг гайхалтай, гамбургер амттай байсан ч нэг л зүйл түүний сэтгэлийг зовоож байлаа.

Ээж нь түүнд ойртож ирээд, "Зүгээр юм шиг сонсогдохгүй л байна даа. Ямар нэг юм болоо юу?" гэв.

"Юу л даа . . ."

Жозефт үнэндээ асуух зүйл олон байлаа! Нөгөө залбирлын талаарх бодол толгойноос нь салж өгөхгүй байв. Тэр залбирал яагаад түүний болон гэрийнхний нь залбирлаас өөр байсан юм бол?

"Ээж ээ, та Сүмд орохоосоо өмнө яаж залбирдаг байсан бэ?" гэж тэр асуулаа. Жозеф ээждээ Филипийн гэр бүлийн залбирлын талаар ярив.

"Тэд өмнө нь миний шүтдэг байсантай адил католик шашинтай юм байна. Тэд гараараа загалмайн тэмдгийг үзүүлж байгаа юм. Загалмай ямар байдгийг чи мэднэ шүү дээ? Энэ нь Есүс бидний төлөө нас барсныг сануулдаг" гэж ээж нь хариулав

Жозеф инээмсэглэлээ. "Тэгвэл Филип ч бас Есүст итгэдэг хэрэг үү?" гэхэд, ээж нь "Тийм ээ. Чи Филипийн аав юу гэж залбирсныг санаж байна уу?" гэж асуув.

Жозеф санах гэж хичээлээ. "Тэр Бурханы бидэнд өгдөг бэлгүүдийн төлөө талархаж байсан. Бас тэр Христийн тухай ярьсан!" гэв.

"Одоо ойлгов уу?" гээд ээж нь инээмсэглээд, "Бид тийм ч өөр биш байгаа биз. Би чамайг Филипийн гэрийнхэнтэй хамт залбирсанд баяртай байна" гэлээ.

Хэд хоногийн дараа Филип тоглохоор тэднийд иржээ. Тэднийг гадаа тоглож байхад аав нь оройн хоолонд дуудав. Тэднийг гал тогоонд гүйлдэн орж ирэхэд Жозефын гэдэс хоржигнон дуугарч байлаа.

"Би өлсөж үхэх нь ээ!" гэж Жозефыг хэлэхэд

"Би ч гэсэн" гэж Филип бас хэлэв.

Хүн бүр ширээ тойрон байраа эзлэн суулаа. Филип Жозефын хажууд суусан байв. Филип загалмайн тэмдэг үзүүлж, Жозефын гараас барилаа.

"Манайхан ингэж залбирдаг" гэж Жозеф хэлээд. "Бид гараа зөрүүлж, нүдээ анин, толгойгоо бөхийлгөдөг" гэхэд

тэр "Ингэж үү?" гэж асуулаа.

"Тийм, яг ингэж" гэж Жозефыг хариулахад

"Амархан юм байна" гэж Филип хэлэв.

Жозеф нүдээ аниад, инээмсэглэлээ. Тэр найзтайгаа хамт залбирч байгаадаа баяртай байв. ●

Зохиогч нь АНУ-ын Калифорнид амьдардаг.



Би сургууль дээрээ католик, мусульман шашинтай найзуудтай бөгөөд Есүс биднээс бие биедээ ингэж хандаасай гэж хүсдэг тул бид бүгдээрээ сайхан найзалдаг.

Элизабэт А., 8 настай, Английн Баруун Мидленд

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МИНА ПРАЙС

Сайн үйлсээр дүүрэн

Шинэ Гэрээнд гардаг энэ гурван эмэгтэй хүмүүст тусалдаг байв. Тэдний хийсэн зүйлийг уншаад, зурагтай нь тохируул. Та өнөөдөр хэн нэгэнд туслахын тулд юу хийж болох вэ?



Прискила амь зуулгаа залгуулахын тулд нөхөртэйгөө хамт майхан хийдэг байсан. Тэр нөхөртэйгөө хамт сайн мэдээний тухай заадаг байв. Тэд гэртээ Сүмийн цуглаан хийдэг байсан байж магадгүй. *(Үйлс 18:26-г үзнэ үү.)*

Лудиа нил ягаан өнгийн бөс даавуу зардаг байсан. Тэр Сүнсийг мэдэрч, баптисм хүртэхээр шийджээ. Тэр дагалдагчдыг аялж явах үед гэртээ байлгадаг байсан. *(Үйлс 16:14–15-ыг үзнэ үү.)*

Табита ядуут өглөг өгч, тусламж хэрэгтэй хүмүүст зориулан хувцас, дээл оёдог байв. Петр түүнийг нас барсны дараа үхлээс босгосон. *(Үйлс 9:36, 39–40-ийг үзнэ үү.)* ●

Энэ хуудас нь *Ирээд, Намайг дага—Хувь хүн, гэр бүлүүдэд зориулав* гарын авлагын 108-р хуудасны нэмэлт хэсэг юм.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ШОНА Ж.К.ТЭННИ

Анхдагч болохын тулд

Үг, аяыг Рут Мюур Гарднэр
Найруулан эмхэтгэсэн Ванжа В.Воткинс



© 1980, 2019 он, Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Энэ дууг ашгийн бус зорилгоор сүмд болон гэртээ ашиглахаар хувилж болно.
Энэ мэдэгдлийг хэвлэсэн хувь бүр дээр оруулсан байх ёстой.

Сайн байна уу? Камбожоос мэндчилж байна!

Камбож нь Зүүн Өмнөд Азид оршдог орон юм. 15 сая орчим хүн амьдардгийн 14000 нь Сүмийн гишүүд.



Камбожийн ихэнх хүүхэд эцэг эхтэйгээ хамт мотоцикл унан, сургуульдаа болон сүмдээ явдаг. Эсвэл тэд *tuk tuk* гэдэг жижигхэн мотоцикл тэргээр явж очдог.

Энэ бол камбож хэл дээрх Мормоны Ном. Камбож хэлийг кхмер (kuh-MY) гэдэг. Цагаан толгой нь дэлхийн хамгийн их, 74 үсэгтэй.

Сүмийн энэ гишүүд *sampeah* гэдэг Камбожийн уламжлалт аргаар хоорондоо мэнд-чилж байна. Гараа өндөрт өргөх тусам таныг төдий чинээ их хүндэлж байгаа хэрэг юм.

БИЕ БИЕТЭЙГЭЭ МЭНДЭЛЖ БАЙГАА ГИШҮҮД БОЛОН МОТОЦИКЛ УНАЖ БУЙ ЭРЭГТЭЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЖЭЙМС ИЛИФФ ЖЭФФРИ АВАВ

Ерөнхийлөгч Нэлсон өнгөрсөн жил Камбожийн нийслэл Пномпеньд анхны ариун сүм баригдана гэдгийг зарласан. Ариун сүм нь тэднийх шиг гэр бүлийг мөнхөд хамт лацдан холбогдоход туслах юм.

Камбожид Хүүхдийн хэсгийн олон хүүхэд сургуулийнхаа Христэд итгэдэг цорын ганц хүүхэд байх нь элбэг. Энэ нь Камбожид ихэнх хүн Буддын шашин шүтдэгтэй холбоотой. Шашин шүтлэг нь тэдэнд үнэнч, амар амгалан, ухаалаг байхыг заадаг. Энэ бол Камбож дахь Буддын алдартай хөшөө дурсгал бөгөөд дэлхийн өнцөг булан бүрээс хүмүүс энд айлчлан ирдэг.

Камбожийн ихэнх хоолонд *prahok* хэмээх загасны гашуун, давстай амтлагчийг хэрэглэдэг. Сүмийн гишүүд Ерөнхий чуулганы завсарлагаанаар гадасны төв дээр хамтдаа хооллохоор том тогоотой шөл хийсэн байгаа нь энэ.

Зарим камбож найзтай минь танилцана уу!

Би Бурханы дуулгавартай дагасан үедээ маш их аз жаргалтай байдаг.

Синэт Б., 6 настай, Камбож, Кампонг Том

Би номлогчдоос гэрээр хичээл авсныхаа дараа баптисм хүртсэн ба одоо маш их баяртай байгаа.

Сина Б., 8 настай, Камбож, Кампонг Том

Камбожоор бидэнтэй хамт аялсанд баярлалаа! Дараа дахин уулзацгаая!

Та Камбожид амьдардаг уу? Бидэнд захидал бичээрэй! Бид таныг сонсохыг хүсэж байна.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭТИ МАКДИЙ   ХООЛ ХИЙЖ БАЙГАА ГИШҮҮДИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ СЭЛИА ЖЭФФРИ АВАВ



Анхдагч Мара

Жэссика Ларсэн

(Бодит түүхээс сэдэвлэв)

2018 оны 10-р сар, Камбож, Пномпень

Мара банзлаа товчлон, толинд харлаа. Бямба гарагт сүмийн хувцас өмсөх хачирхалтай санагдсан ч энэ бол онцгой бямба гараг. Ерөнхий чуулгантай бямба гараг байв!

“Эмэгтэйчүүдийн хуралдаанд очих гэж байгаадаа сэтгэл чинь догдолж байна уу?” гэж Мак (ээж нь) асуув. Тэр Марагийн үсийг түргэн хэрнээ зөөлхөн гэгч самнаж байхдаа “Би чамайг аль болох олон зүйл олж сонсоосой гэж хүсэж байна” гэв.

“Тэгэлгүй яах вэ! Тэд анхдагчдын талаар ярих байх гэж найдаж байна!” гэж тэр хариуллаа. Энэ нь Марагийн хамгийн дуртай сэдэв байв.

Мак “Тэд ярьж ч магад” гээд, “Чи аавыгаа анхдагч гэдгийг мэдэх үү?” гэж асуув.

Мара мэл гайхлаа. Аав гар тэрэг түрж байгаагүй шүү дээ.

“Яагаад тэр анхдагч гэж?” гэж тэр асуув.

Мак цонх руу, голын зүг дохилоо. “Тэр тэнд загасчилж байхдаа номлогчидтой танилцсан юм. Тэр гэрээсээ баптисм хүртсэн анхны хүн болсон юм. Энэ нь түүнийг анхдагч болгосон! Одоо харин хоёулаа эмээгээ олохоор явцгаая” гэж Мак хэллээ.

Иэй (эмээ нь) тэднийг үүдний өрөөндөө хүлээж байв. Марагийн гэр бүл өвөө, эмээтэйгээ хамт амьдардаг. Иэй эцэг эхийгээ ажилтай байх үед хичээлийнх нь дараа Мараг харж өгч тусалдаг байв. Одоо харин Иэй хотоор авахдаа унадаг том моторт дугуй мопедных нь дэргэд зогсож байлаа.

Мак хаалгаа онгойлгон, мопедоо гудамж руу гаргангаа Марад “Сүм Камбожид ердөө л 25 жил болж байна шүү дээ. Тиймээс бид бүгдээрээ анхдагч. Чи ч гэсэн!” гэв.

“Би яагаад анхдагч гэж?” хэмээн Мара мопед дээр суунгаа гайхан бодов. Мак Иэйг ардаа, Мараг дундаа суулгаад, мопедоо жолоодов. Пиг дүүрэн хүнтэй гудмаар уруудахад Мара ээжээсээ чанга барилаа.

Тэднийг кафены хажуугаар өнгөрөхөд цайны үнэр ханхалж байлаа. Энд бараг хүн бүр цай уудаг. Харин Мара уудаггүй. Учир нь тэр мэргэн ухааны үгийг дагадаг. Мара инээмсэглэв. Энэ нь түүнийг анхдагч болгож байгаа нэг арга зам байлаа!

Мопедыг булангаар эргэхэд Мара *ват* гэдэг Буддын сүм хийдийг олж харав. Улаан шовх орой нь бусад барилгын дээгүүр харагдана. Үсээ хуссан, улбар шар нөмрөгтэй лам нар хашаан дотор ном үзэн сууна.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙН БИЙЧ

Камбожид ихэнх хүн Буддын шашин шүтдэгийг Мара мэддэг байв. Тэд Есүс Христэд итгэдэггүй ч, Мара итгэдэг. "Энэ ч бас намайг анхдагч болгож байгаа өөр нэгэн зүйл юм байна" гэж Мара бодов. Харин тэр өнөөдөр бошиглогчийг сонсох гэж байна!

Мопедоо сүмийн машины зогсоол руу оруулан тавихдаа Мара олон эмэгтэй ирж байгааг харав. Зарим нь алхаж, зарим нь мопед унасан байлаа. Харин зарим нь *tuk tuks* гэдэг мотоциклон жижиг тэргээр ирж харагдав. Эмэгтэйчүүдийн ихэнх нь Маратай адилхан даашинз эсвэл энгийн банзал өмссөн байлаа. Харин зарим нь *sampots* гэдэг өнгөлөг хээтэй даавуугаар хийсэн гоё урт банзал өмссөн байв.

Мара, Мак, Иэй гурав танхимд бусад эмэгтэйтэй зэрэгцэн суув. Үнэндээ чуулган АНУ-ын Солт Лэйк Ситид бүтэн долоо хоногийн өмнө болсон байлаа. Гэвч Камбож дахь хүмүүс шууд цацсан нэвтрүүлгийг одоо кхмер хэлээр үзэх боломжтой болсон. Мара англи, кхмер хэлийн аль алинаар нь гэртээ ярьдаг. Тэр бас сургуульдаа франц хэл үздэг. Гэвч олон камбож хүн зөвхөн кхмер хэлээр ярьдаг.

Эхний үг хэлсэн хүн анхдагчдын талаар ямар ч түүх хуваалцсангүй. Харин хоёр дахь үг хэлэгч сургуулиасаа гэртээ харих замдаа гүвээ өөд өгсөн, шороон замаар алхдаг байснаа хуваалцав. Үүнийг "хөвгүүдийн жим" гэж нэрлэдэг байсан ч тэр заримдаа гутлаа тайлан, хөл нүцгэн алхдаг байжээ. Тэр анхдагчтай адил байхын тулд хэцүү зүйлсийг хийхийг хүсэв. *Мара* өөрийг нь анхдагч болгож байгаа бүх зүйлийн талаар бодоод инээмсэглэлээ.

Сүүлийн үг хэлэгч бошиглогч байв. Тэр өндөрт зогсож байсан. Мара түүнийг чих тавин анхааралтай сонслоо. "Би та нарыг одооноос эхлээд, энэ ондоо багтаан Мормоны Номыг уншиж дуусгахад урьж байна. Тэнгэр таны төлөө нээгдэх болно. Их Эзэн таныг адислах болно" гэж тэр хэлэв.

Мара Мормоны Номыг бүрэн уншиж дуусгахад амаргүй гэдгийг мэдэж байлаа. Тэр эргэн тойрныхоо эмэгтэйчүүд рүү харав. Тэд бүгд Есүс Христийг дагахаар сонгосон байв. Тэд мөн бүгд энэ үдэш бошиглогчийг сонсохоор ирсэн байлаа. Тэр тэдэнтэй адил бошиглогчийг дагах болно. Тэр анхдагч болох болно! ●

Зохиогч нь АНУ-ын Техаст амьдардаг.

2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Камбожид ариун сүм баригдахыг зарласан.

Би Христэд итгэдэг!

Марисса Виддисон
Сүмийн сэтгүүлүүд



Би баптисм хүртэж, Сүмийн гишүүнээр батлагдахдаа Христийн нэрийг өөр дээрээ авсан. Энэ нь би Түүнийг дагахаар сонгож, зөвийг хийхээр хичээнэ гэсэн үг юм.

Би Христэд итгэдэг! Би судруудыг өдөр бүр уншин, Түүний амьдрал, гайхамшгууд, сургаал болон мөнхийн золиослолын талаар суралцдаг.

Би Христэд итгэдэг! Би дэлхийнхэн Есүс өөрсдийнх нь төлөө нас барсан гэдгийг мэдээсэй гэж хүсдэг. Тэр бидний төлөө амиа өгсөн тул бид бүгдээрээ амилах болно!

Би Христэд итгэдэг! Би Христ бол Бурханы Цорын Ганц Хүү гэдэгт итгэдэг. Мөн Амар амгалангийн Хан хүү, Сайн хоньчин, Амийн талх, Ариун Нэгэн гэдэгт итгэдэг.

Би Христэд итгэдэг! Сэтгэл маань нүгэлдээ эсвэл дэлхийн зүйлсэд шаналах үед би Есүст зүрх сэтгэлээ хандуулдаг ба Түүнийг байдаг гэдгийг мэднэ.

Би Христэд итгэдэг! Би өөрт байгаагаа ашиглан, найзууддаа хэрэгтэй үед нь тусалдаг. Би Христийн хийх байсан зүйлсийг хийхийг хичээдэг ба Түүний заавдыг дагаж байгаа.

Би Христэд итгэдэг! Би гэм буруу хийсэн хүн бүрийг уучилдаг. Би амар амгалан, нөхөрлөлийг хүлээн авч, хүмүүст тусалдаг.

Би Христэд итгэдэг! Би Христийг Түүний биднээс хүссэн арга замаар дурсан санадаг. Би долоо хоног бүр ариун ёслолоос хүртэж, үнэнч байх амлалт өгдөг.

Би Христэд итгэдэг! Би ганцаараа байсан ч үнэнч шударга байдаг. Би үнэнч, зоригтой, ариун журамтай. Та надад найдаж болно.

Би Христэд итгэдэг! Би Есүс Христийг бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг. Энэ бол үнэн! Одоо таны ээлж. Христэд итгэнэ гэдэг нь таны хувьд ямар утгатай талаар хуваалцана уу! ●

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

“Христэд итгэгчид” гэдэг нэр томьёог анх Шинэ Гэрээн дээр Есүсийг дагадаг байсан Антиох хотын хүмүүсийг дурслэхдээ ашиглаж байжээ. Та тэдний талаар Үйлс 11:26-аас уншиж болно.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АНДРЮ СЭОЛИН

“Чи миний баптисм дээр ирэх үү?”

Оливэр үүнийг дээвэр дээрээс, Английн бүх хүнд сонсогдохоор хашгирахыг хүсэж байв!

Рэбэкка Хог ба Эрик Б.Мөрдок
(Бодит түүхээс сэдэвлэв)

“Хэн ч чамайг залуу хүн хэмээн дорд бүү үзэг. Харин чи итгэгч хүмүүст үлгэр дуурайл бол” (1 Тимот 4:12).

Оливэр тэр долоо хоногийг тэсэн ядан хүлээж байлаа. Дараагийн долоо хоногт түүний дөрвөн настайгаасаа хойш хүсэн хүлээсэн том өдөр болох гэж байв. Тэр баптисм хүртэх гэж байлаа.

Оливэр баптисм хүртэх гэж байгаадаа маш их баярлаж байсан тул үүнийгээ дээвэр дээрээс Английн бүх хүнд сонсогдохоор хашгирахыг хүсэж байв! Тэр сургуулийнхаа найз Диланд хэлэхийг тэсэж ядан хүлээж байлаа.

“Итгэмээргүй юм! Миний баптисм *одоо л* нэг болох нь. Бүх зүйл гайхалтай сайхан байх болно!” гэж Оливэр хэлэв.

“Би жаахан хүүхдүүд л баптисм хүртдэг байх гэж бодож байсан” гэж Дилан гайхсан аятай харж байв.



“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптисм хүртэхийн тулд хүүхдүүд доод тал нь 8 хүрсэн байх ёстой. Энэ бол миний Сүм” гэж Оливэр хэллээ.

“Янзтай” гэж Дилан хариулав.

Гэнэт Оливэрт нэг бодол төрлөө. “Чи миний баптисмд ирэх үү?” гэхэд

Дилан “Мэдээж,” “Гэвч би эхлээд аав, ээжээсээ асуух хэрэгтэй” гэв.

Хариуд нь Оливэр “За!” гэлээ.

Оливэр Диланыг баптисмд нь ирэх байх гэж бодохоор сэтгэл нь хөдөлж байв. Энэ нь түүнд өөр нэг санааг өгөв. “Би баптисмынхаа талаар *ганцхан* найздаа хэлж болохгүй шүү дээ. Би аль болох олон хүн уримаар байна!” гэж боддоо. Оливэр гэр рүүгээ яаран ирж, төлөвлөгөөгөө ээждээ хэлэв.

Оливэр баптисмынхаа өмнөх мацгийн ням гарагт төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэллээ. Тэр индэр дээр гэрчлэлээ хуваалцсаныхаа дараа “Би дараагийн бямба гарагт баптисм хүртэх гэж байгаа. Хүн бүрийг ирээсэй гэж хүсэж байна. Та нар гишүүн биш юм уу сүмдээ ирэхгүй байгаа хэн нэгнийг миний баптисмд урьж болох уу?” гэж хэлэв. Түүнд номлогч болсон мэт санагдав! Тэрхүү мэдрэмж нь түүнд үнэхээр таалагдаж байлаа.

Дараагийн долоо хоногт нь Оливэр найз нөхөд, гэр бүлийнхэн, багш нараа баптисмдаа урив.

“Таныг ирвэл би баярлах болно” гэж тэр тэдэнд хэлж байлаа.

Бямба гараг дөхөх тусам Оливэр яг хэдэн хүн ирэх бол гэж догдолж эхлэв. Тэд бүгдээрээ завгүй эсвэл ирэхийг хүсэхгүй бол яана аа?

Урьсан хүмүүсээс нь цөөхөн ч гэсэн хүн ирээсэй хэмээн тэр хурдхан залбирав. Дараа нь тэр хэн ирэх бол гэдэгт санаа зовохоо больжээ. Тэр зөвхөн урьснаараа л сайн үйл хийсэн гэдгээ мэдэж байлаа. Түүнээс гадна тэр өдрийн хамгийн чухал үйл явдал бол баптисм хүртэх шүү дээ.

Оливэр баптисмын өдөр сүм дээр очоод, нүдэндээ ч итгэж чадсангүй. Олон найз нь түүнийг дэмжихээр ирсэн байв. Танихгүй хүмүүс хүртэл ирсэн байхыг тэр харлаа. Диланыг эцэг эхтэйгээ хамт орж ирэхэд нь тэр гараараа даллав.

Баптисм хүртэх цаг болоход Оливэр бүлээн ус руу алхаж оров. Аав нь өмнө нь сургуулилт хийж байсанчлан түүний гараас барилаа. Тэгээд тэр баптисмын богино залбирал хэлээд, Оливэрыг усанд дүрэв. Нэг мэдэхэд Оливэр ус дуслуулан, инээмсэглэн зогсож байлаа. Тэр Есүсийн үлгэр жишээг дагаж байгаагаа мэдэж байв.

Оливэрыг хуурай хувцас сольж өмссөний дараа аав нь хэдэн эрэгтэй хүнтэй хамт түүнийг Сүмийн гишүүнээр баталж, онцгой адислал өгч, Ариун Сүнсний бэлэг хүлээн авахад урилаа. Дараа нь Оливэр гэрчлэлээ хуваалцаж болох эсэхийг асуув.

“Миний хувьд онцгой энэ өдөр намайг дэмжихээр ирсэнд тань маш их баярлалаа. Энэ нь надад маш чухал. Би баптисм хүртсэндээ талархаж байгаа бөгөөд энэ бол дэлхий дээрх Христийн Сүм гэдэгт итгэдэг” гэлээ.

Дараа нь хүмүүс Оливэрт баяр хүргэхээр ирэв.

“Намайг урьсанд баярлалаа!” гэж Дилан хэлэв. Харин Диланы ээж “Надад маш сайхан мэдрэмж төрсөн.

Хүн бүр ямар сайхан сэтгэлтэй юм бэ!” гээд, “Бидэнд маш дотно сайхан мэдрэмж төрлөө” гэж хэлэв.

Тэр орой Оливэрын аав орных нь буланд суугаад, “Ямар гайхамшигтай сайхан өдөр байв аа!” гэв.

Оливэр толгой дохиод, “Би энэ өдрийг найзуудтайгаа хуваалцсандаа баяртай байна” гэлээ. ●

Зохиогчид нь Английн Кэнт болон АНУ-ын Ютад амьдардаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРҮК СМАРТ

Ахлагч Кристоффэрсон Филиппинд айлчилсан нь

Ахлагч Д.Тодд Кристоффэрсон, Кэти Кристоффэрсон эгч хоёр Филиппин дэх Сүмийн гишүүд дээр айлчлан очсон. Энэ нь 7000 гаруй арлаас тогтсон улс юм. Энэ улс 70000 гаруй Сүмийн гишүүнтэй.

Хэрэв та Филиппинд очвол нүүрэндээ баясал тодруулан гэртээ харих болно гэж тэр хэлсэн юм.

Филиппины Сүмийн гишүүдийн ихэнх нь, ялангуяа залуу эмэгтэйчүүд номлолд үйлчилдэг. Ахлагч Кристоффэрсон тэднийг хэл сурахдаа сайн гэдгийг олон хүн мэддэг гэж хэлсэн.

"Өчүүхэн жижиг зүйлс хувь хүн болоод гэр бүлийн амьдралд томоохон өөрчлөлтийг авчирдаг"



Ахлагч Кристоффэрсон ингэж заажээ.

Сайхан сэтгэлтэй байж, бусдыг харж ханд. Үүнийг тохинуулал гэдэг.

Сайн мэдээний бүх зарчмын дагуу амьдар.

Сайн мэдээг бусадтай хуваалц.

ГЭРЭЛ ЗУРГУУДЫГ © INTELLECTUAL RESERVE, INC.

Үүнийг хайж ол!

Филиппинд амьдардаг Мариа, Даниэл хоёр *lola* (эмээдээ) туслах дуртай. Өнөөдөр тэд эмээгээ баптисм хүртээсэн номлогчийнхоо тухай ярих зуур цэцэрлэгт хүрээлэнгээр тэргэнцрийг нь ээлжлэн түрж яваа харагдана. Та Мариа, Даниэл хоёрын хэзээ нэгэн өдөр номлолдоо ашиглаж магадгүй 9 эд зүйлийг олж чадах эсэхээ хараарай.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД ХЭЛТОН

Өөрийгөө таниулж, илэрхийлэх боломж

Алжбэта К., 7 настай, Бүгд Найрамдах Чех Улс, Злин бүс



Би амралтаар явж байхдаа далайн эрэгт нэг найзтайгаа танилцсан. Нөхөрлөл бол Тэнгэрлэг Эцэгээс өгсөн гайхалтай бэлэг юм!

Тэрэжка Ж., 6 настай, Бүгд Найрамдах Чех Улс, Злин бүс



Би Бурханы хүүхэд тул Тэр надад хайртай.

Нахоми К., 3 настай, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Төв Касаи муж

Би хүмүүсийг тэврэх дуртай.

Этан Л., 6 настай, Франц, Окситани

Би хүн болгонтой хуваалцахыг хүсэж байна.

Вэрланн Н., 8 настай, Филиппин, Тарлак

Сайхан сэтгэлийн цэцэрлэгт зориулан бидний юу хийснийг хараач!

Абнахиа болон Жацийл Г., 5 ба 7 настай, Пуэрто Рико



Би багадаа уснаас айдаг байв. Хүмүүс надад сандрах хэрэггүй гэж хэлдэг байсан ч би айдаг байсан. Есүс Христ үлгэр жишээ үзүүлэхийн тулд баптисм хүртсэн бөгөөд намайг айдсаа ялан дийлж чадна гэж номлогчид хэлсэн. Би баптисм хүртэхдээ асар их баяр хөөр мэдэрсэн.

Сара Т., 11 настай, Франц, Иль Де Франс

Энэ бол Түүний Сүм

Далын
Ахлагч Таниэла Б.Ваколо

“Миний нэр болох, Христийн нэрийг та нар өөрсдийн дээр авах ёстой” (3 Нифай 27:5).

Би Фижид төрсөн. Эцэг эх маань Сүмийн гишүүд байгаагүй ч өөр сүмд явдаг байлаа.

Би өсөж том болоод, эхнэр Анитатай-гаа гэрлэсэн. Тэр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн байв. Тэр номлогчдыг надтай уулзуула-хаар урьдаг байлаа.

Нэг удаа би тэдэнд гурван орой дараа-лан оройн хоолон дээр ирж болно гэж хэлсэн юм. Би тэдэнд миний асуултуу-дад зөвхөн Библийг ашиглан хариулах ёстой гэв. Тэдний хариулт төгс байлаа. Гурав дахь орой нь тэд *надад* нэг асуулт тавив.

“Хэрэв та хүнсний дэлгүүртэй байсан бол дэлгүүрээ юу гэж нэрлэх байсан бэ?” гэлээ.

“Миний дэлгүүр учраас би Вакологийн гэр бүлийн дэлгүүр” гэх байсан гэв.

“Сүм хэний нэрээр нэрлэгдвэл зохих вэ?” гэж тэд лавлаж асуулаа.

Харин энэ нь үнэхээр нүдээ оносон асуулт байсан юм. Би хариултыг зүрх сэт-гэл дотроо мэдэж байв. Үнэн Сүм Түүнийх учраас Сүм Есүсийн нэрээр нэрлэгдэх ёстой. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүү-дийн Сүм Түүгээр нэрлэгдсэн байлаа.

Надад дахиад ганцхан асуулт байсан тул “Би хэзээ баптисм хүртэж болох вэ?” гэж асуусан юм. Нэг долоо хоногийн дараа би баптисм хүртэж билээ.

Би баптисм хүртэхдээ Есүс Христийн нэрийг өөр дээрээ авсан. Энэ нь би Түү-ний Сүмийн гишүүн болж, Түүнийг дагах амлалт өгсөн гэсэн үг. Би Түүний адил амьдрахын тулд өдөр бүр хамгийн сайнаа-раа хичээдэг. Энэ бол Есүс Христийн үнэн Сүм гэдгийг би мэднэ. ●

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СИМИНИ БЛОКЭР

Есүс сайн мэдээг хуваалцахыг хэмээсэн



Есүс үхээд, амилсныхаа дараа Өөрийн дагалдагчид дээр ирсэн. Тэр зарлигуудыг дагаж, баптисм хүртэхийг бүх хүнд заа хэмээн тэдэнд хэлсэн.

Петр тэр үед дэлхий дээрх Сүмийг удирдах бошиглогч болсон байв. Есүс Ариун Сүнс тэдэнтэй хамт байх болно хэмээн амласан.

Дагалдагчдадаа заасныхаа дараа Есүс тэнгэрт буцжээ.

Дагалдагчид өөр өөр газраар аялж, хүмүүст зааж эхлэв.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

Би ч гэсэн сайн мэдээг хуваалцахад тусалж чадна.
Би бас сайн найз байж, зөв зүйлийн талд зогсож чадна! ●

Есүсийн Матай 28 болон Үйлс 1 дээр заасан зүйлийг уншина уу.

Есүс намайг сайн мэдээнээс хуваалцаасай хэмээн хүсдэг

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АПРИЛ СТОТТ

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Есүс Өөрийн дагалдагчдад сайн мэдээг "бүх дэлхийд" (Марк 16:15) хүргэ хэмээн хэлсэн. Энэ сарын сэтгүүл амьдарч байгаа газартаа сайн мэдээнээс хуваалцах санаануудыг танай гэр бүлд өгөх юм. Энэ сэтгүүлийг авах хүн бүр ердөө ганцхан гэр бүлтэй сайн мэдээг хуваалцах юм бол хэчнээн олон хүн Есүсийн талаар олж мэдэхийг төсөөл дөө! Түүх болгоныг уншихдаа ярилцах асуултуудыг өгөв. Үүнд:

- Манай гэр бүлийнхний дунд Хүүхдийн хэсэг, баптисм эсвэл Сүмийн үйл ажиллагаанд урьж болохоор хүн байна уу?
- Манай гэр бүл өөрсдийн үлгэр жишээгээр сайн мэдээнээс хуваалцахын тулд энэ сард юу юу хийж болох вэ?
- Христэд итгэдэг гэдгийг маань манай найз нөхөд, хөршүүд мэддэг үү?

Эдгээр түүхэн дээрх хэн нэгний сайн мэдээнээс хуваалцаж байгаа бүх цаг хугацааг гэр бүлээрээ тэмдэглэ. Дараа нь гэр бүлээрээ номлолын төлөвлөгөө гарга. Үүнийг хэрхэн хэрэгжүүлснээ бидэнд мэдэгдээрэй!

Дэлхийг сайн сайхнаар дүүргэцгээе!
Найз

New *Friend* section
50 E. North Temple Street, Room 2393
Salt Lake City, UT 84150-3220, USA.
liahona@ldschurch.org

Дотор нь нуусан Лиахонаг олоорой!

ГАРЧИГ

H2 Тэргүүн Зөвлөлөөс: Сайн мэдээг хуваалцах нь
H4 Филиптэй хамт залбирсан нь
H6 Сайн үйлсээр дүүрэн
H7 Дуу хөгжим: Анхдагч болохын тулд
H8 Сайн байна уу? Камбожоос мэндчилж байна!
H10 Анхдагч Мара
H12 Би Христэд итгэдэг!
H14 Чи миний баптисм дээр ирэх үү?
H16 Төлөөлөгчид дэлхий даяар: Ахлагч Кристоффэрсон Филиппинд айлчилсан нь
H18 Өөрийгөө таниулж, илэрхийлэх боломж
H19 Энэ бол Түүний Сүм
H20 Судрын түүхүүд: Есүс сайн мэдээг хуваалц хэмээсэн
H23 Будах хуудас: Есүс намайг сайн мэдээнээс хуваалцаасай хэмээн хүсдэг

***НАЙЗ* СЭТГҮҮЛИЙН ХАВТСАН ДЭЭР**
Зургийг Гай Франсис

© 2019 BY INTELLECTUAL RESERVE, INC. БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН

MONGOLIAN